



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2019 он

ЗОХИОГЧИЙН ЭРХ:

© АТГ 2019

Энэхүү номын аль ч хэсгийг Авлигатай тэмцэх газрын бичгэн зөвшөөрөлгүйгээр ямар ч хэлбэрээр, ямар ч аргаар хуулбарлах, дахин хэвлэхийг хориглоно.

Боловсруулсан:

Д.Наранчимэг

З.Баярчимэг

Д.Баяраа

Хянан тохиолдуулсан:

Д.Дуламсүрэн

Д.Цэнд-Аюуш

Талархал:

Энэхүү сургалтын модуль, гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн хамт олон болон практик жишээ, хууль тогтоомжийн хэрэглээний талаар зөвлөгөө, мэдээллээр хангасан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны ажилтнуудад гүн талархал илэрхийлье.

Энэхүү гарын авлага, модулийн талаар дараахь хаягаар холбогдож болно:

d_naranchimeg@msue.edu.mn

hutulbur@iaac.mn

Цаасны хэмжээ: B5

Хэвлэлийн хуудас: 12

Хэвлэсэн тоо: 6000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан билээ. Уг Конвенцид Оролцогч бүр ил тод байдлыг дэмжих болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна.¹ гэж заасан байдаг.

Монгол Улс гишүүн орныхоо хувьд дээрх Конвенцийг хэрэгжүүлэх, нөгөө талаас авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хийдлийг арилгах, нийтийн албаны ил тод, хариуцлагатай, шударга байдлыг хангах, бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажилласны дүнд 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан мөрдөж байна. Энэхүү хууль нь албан тушаалтны хувьд нийтийн албанд шинээр томилогдохоос эхлэн ажлаас чөлөөлөгдсөнөөс хойших 2 жилийн хугацаанд үйлчилж, төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхлын төлөө гүйцэтгэх нөхцөл боломжийг баталгаажуулан, төрийн албаны ил тод, олон нийтийн итгэл даах байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилготой юм. Монгол Улсын хувьд ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай зэрэг хуулиар зохицуулж байсан бөгөөд тусгайлсан хууль баталсан нь асуудлыг цогцоор авч үзэх оновчтой шийдэл болж чадсан гэж

1 НҮБ-ын Авлигын эсрэг конвенци, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2016

үзэж болно. Төрийн албаны тухай хуульд зааснаар ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь төрийн албанд баримтлах гол зарчмын нэг мөн.

Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой буюу албан хаагчийн ажил үүргээ тэгш шударгаар, хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй нь зөрчилдөх, зөрчилдөж болзошгүй тул энэхүү зөрчлийг зүй зохистойгоор удирдан зохицуулаагүйгээс улмаар авлига үүсэх орон зайг бий болгодог.

Албан тушаалаа урвуулан ашиглах боломжийг бууруулж, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй буюу үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ талаар журмын дагуу мэдүүлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх замаар шударга байдлыг тогтоох нь шийдлүүдийн гол зорилго юм.²

Иймд дээрх хуулийг сурталчлах, нийтийн албан тушаалтнуудад аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг олгох зорилгоор энэхүү гарын авлагыг толилуулж байна. Гарын авлагыг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээр хуулийг даган гарсан дүрэм, журмын хүрээнд боловсруулан ашиг сонирхлын зөрчлийг таних, урьдчилан сэргийлэх, зохицуулахтай холбоотой арга хэрэгсэл, механизмын талаар тодорхой ойлголт өгөхөөс гадна албан тушаалтны сонирхлын зөрчлийн асуудлууд, түүнийг шийдвэрлэж буй гол арга замыг тодорхой өгүүлэх болно.

2016 онд Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийн нэг чухал зорилт бол шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх явдал бөгөөд энэ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр авлигын эсрэг богино болон урт хугацааны, давтан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах гэх мэт олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Авлигатай тэмцэх газар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах,

2 М.Полейни, НҮБАЭК-ийн гарын авлага, 2015, Лондонгийн Олон улсын хуулийг практикт хэрэгжүүлэх төв, Авлигын эсрэг форум <http://www.icilp.org/wp-content/uploads/2015/02/Guide-to-the-UN-Convention-Against-Corruption-Martin-Polaine.pdf>

хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг улам идэвхжүүлэн, энэ чиглэлээр иргэд, төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, шударга, ил тод, нээлттэй, хариуцлагатай, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх стратегийг баримтлан ажиллаж байна.

Дээр дурдсан авлигын эсрэг сургалтын агуулгад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэв багтсан тул гарын авлага нь уг сургалтыг практик жишээн дээр тулгуурлан сургагч багш хөтлөн явуулах, цаашлаад баяжуулан ашиглах боломжийг олгож байгаа юм.

Гарын авлагыг модулийн хамт боловсруулсан бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад шаардлагатай иж бүрэн хөтөлбөр болж чадна гэж үзэж байна. Энэхүү гарын авлагыг боловсруулсан МУБИС-ийн зөвлөх баг, дэмжлэг үзүүлж хамтран ажилласан НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийг удирдлага, хамт олонд талархал илэрхийлье.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

АГУУЛГА

БҮЛЭГ 1. Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, тодорхойлолт, хамрах хүрээ, төрөл	8
1.1 Нийтийн алба, нийтийн албан тушаалтан, хувийн болон нийтийн ашиг сонирхлын тухай ойлголт, тодорхойлолт	9
1.2 Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, ангилал, илрэх хэлбэр	17
1.3 Ашиг сонирхлын зөрчил ба авлига	28
БҮЛЭГ 2. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлага, үндсэн арга зам, механизм	29
2.1 Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлага	29
2.2 Үндсэн механизм	33
2.3 Монгол Улсын хууль тогтоомж ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ба зохицуулах механизм	40
БҮЛЭГ 3. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад удирдлага ба нийтийн албан тушаалтны үүрэг	48
3.1 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг зохицуулахад удирдлагын хүлээх үүрэг	48
3.2 Нийтийн албан тушаалтны үүрэг	49
БҮЛЭГ 4. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад байгууллагын хүлээх үүрэг	54
4.1 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд байгууллагын хүлээх үүрэг	54
4.2 Яагаад байгууллагын соёл чухал вэ?	55
4.3 Байгууллагын соёл гэж юу вэ?	56

БҮЛЭГ 5. Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг	111
5.1 Хувийн ашиг сонирхлын ба хөрөнгө, орлогын мэдүүлэг	64
5.2 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг	70
5.3 Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар	71
5.4 Ил тод байдал, хувийн нууцлалын тэнцвэрийг хадгалах	76
БҮЛЭГ 6. Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт	78
6.1 Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт	78
6.2 Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон зохицуулалт	80
6.3 Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт	84
6.4 Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох	85
6.5 Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт	87
6.6 Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт	88
6.7 Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт	89
6.8 Бэлэг авахтай холбогдсон хориглолт, хязгаарлалт	90
6.9 Хандив авахтай холбогдсон хязгаарлалт	96
6.10 Давхар ажил эрхлэлт болон бусад орлогын талаарх ойлголт	100
6.11 Бусад орлогын хязгаарлалттай холбогдох зохицуулалт	110
6.12 Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт	113
6.13 Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараахь хязгаарлалт	118
6.14 Оффшорын асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт	121
БҮЛЭГ 7. Хэрэгжилтийг хянах, хариуцлага хүлээлгэх	125
7.1 Хэрэгжилтийг хянах механизм	125
7.2 Зөрчилд хүлээлгэх хариуцлага	131
БҮЛЭГ 8. Сонирхлын зөрчлийг зохицуулж буй олон улсын сайн туршлага, санаачилга	134
8.1 Олон улсын сайн туршлага, санаачилга	134
8.2 Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах зөвлөмж	150
Ашигласан ном зүй	152

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, ТӨРӨЛ

Төрийн албанд анх орж байгаа иргэн цагаан цаас адил цэвэрхэн, хоосон зүйл биш бөгөөд гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, дуртай зүйл, эвсэл, холбоо, нийгэмлэгийн гишүүнчлэл, харьяалал, өөрийн бизнес, эд хөрөнгө зэрэг хүн бүрт байдаг бүхий л зүйл, асуудалтайгаа хамт орж ирдэг. Эдгээр харилцаа холбоо, ашиг сонирхол нь албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй бөгөөд хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхлын төлөө, тэгш шударгаар ажиллах үүрэгтэй нь зөрчилдөхийг үгүйсгэхгүй. Нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, ард түмэнд үйлчлэх нь төр, засгийн газрын байгууллагын суурь зарчим, албан тушаалтны үндсэн үүрэг бөгөөд шударга, ил тод байдлыг хангах нь олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой гэж үздэг. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй хэмээн хэн нэгнийг буруутгахыг урьтал болголгүй тэдгээрийг зохицуулахыг чухалчлах, ялангуяа энэ талаар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь оновчтой шийдэл юм. Зохицуулаагүй ашиг сонирхлын зөрчил нь авлига болон бусад зөрчлийг үүсгэж болно.

Ашиг сонирхлын зөрчил ямар ч үед, ямар ч нөхцөл байдалд үүсч болзошгүй тул энгийн зохицуулалтаар хялбархан шийдвэрлэх боломж муу. Төрийн

байгууллага, албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлийн тодорхой тохиолдол бүрт оновчтой шийд гаргах ёстой.¹

1.1 | Нийтийн алба, нийтийн албан тушаалтан, хувийн болон нийтийн ашиг сонирхлын тухай ойлголт, тодорхойлолт

Хүн бүрт өөрийн гэсэн хувийн сонирхол бий. Нийтийн албан тушаалтан ч гэсэн аав ээж, ах дүү, гэр бүл, үр хүүхэд, найз нөхөдтэй, хүсэл мөрөөдөлтэй, хувийн сонирхолтой байх нь гарцаагүй. Харин нийтийн ашиг сонирхол нь “хамгийн шилдэг нь төрийн албыг хаших”-ыг шаарддаг.²

Төрийн албанд орсон хэн боловч хувийн ашиг сонирхлын асуудлаа зохицуулах шаардлагатай. *Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхолд хориг тавьж, хязгаарлах нь ярвигтай асуудал.* Гэхдээ төрийн алба хашиж, нийтийн албан тушаалтан болсноор тэрээр нийтийн эрх ашигт үйлчлэх үндсэн үүргийг хүлээж, албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн сонирхлоо нийтийн ашиг сонирхлоос илүүд үзэж хэрхэвч болохгүй. ***Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, түүний ажил, албан үүрэг хоорондын зөрчлөөс, ялангуяа энэхүү зөрчлийг зүй зохистойгоор удирдан зохицуулаагүйгээс авлига үүсэх орон зай бий болдог.*** Хэрэв нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах үүргээ умартан, хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн хууль тогтоомжийг гажуудуулж, албан үүргээ чин шударгаар хэрэгжүүлээгүй бол сонирхлын зөрчлийн асуудал үүснэ. Эндээс “ашиг сонирхлын зөрчил” гэсэн ойлголт, нэр томъёо урган гардаг.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, шийдвэрлэх арга замыг тайлбарлахаас өмнө ашиг сонирхлын зөрчил гэж чухам юу болохыг тодруулах нь чухал. Ялангуяа авлигатай тэмцэх үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс ашиг сонирхлын зөрчлийг авлигын хэрэг, ёс зүйгүй үйлдэлтэй адилтган ойлгох явдал түгээмэл байдаг учраас сонирхлын зөрчил гэж юу гэдгийг ойлгох нь ихээхэн ач холбогдолтой. Ашиг сонирхлын зөрчлийг дараахь элементүүдээр дамжуулан тайлбарлая. Үүнд:

1 OECD, Managing Conflict of Interest in the Public Sector 2005, p.8

2 Авилгалын эх сурвалж бичиг, УБ, 2013, 275-р тал

Нийтийн алба

Нийтийн албан тушаалтан

Хувийн ашиг сонирхол

Нийтийн ашиг сонирхол

1.1.1. Нийтийн алба, нийтийн албан тушаалтан

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль 2012 онд батлагдсны дараа “төрийн алба”-наас гадна “нийтийн алба” гэсэн шинэ ойлголт, нэр томъёог хэрэглэх болсон. Монгол Улсад төрийн албан хаагч биш боловч нийтийн эрх ашигтай холбоотой шийдвэр гаргадаг хүмүүс олон байдаг. Тиймээс төрийн албанд ажилладаггүй ч олон нийтийн итгэл үнэмшил дээр оршин тогтнож байгаа албан тушаалтан бүхэн нийтийн албанд хамаардаг гэдгийг ойлгох нь чухал.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д тодорхойлсноор **“төрийн алба гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ.**

Нийтийн алба гэдэгт төрийн албыг бүхэлд нь хамруулан ойлгож болно. Тиймээс нийтийн алба нь нийт иргэдийн эрх ашигт нийцсэн төрөөс хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээ, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм.

Дээр өгүүлсэнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1996 оны 51/59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрэм”-д **төрийн байгууллага нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах итгэл даасан байгууллага байхаар заасан**³.

Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т **“төрийн албан хаагч”** гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг ойлгохоор заасан байна. Нийтийн албан тушаалтан бол арай өргөн хүрээний ойлголт юм.

3 Төрийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрэм, Ес зүйн гарын авлага, УБ, 2010

Нийтийн албан тушаалтан гэдэгт олон улсын нийтлэг практикт төрийн алба болон татвар төлөгчдийн бий болгосон төсвийн хөрөнгөтэй их, бага ямар нэгэн хэмжээгээр харилцдаг этгээдийг хамааруулан ойлгодог. **НҮБ-ын** Авлигын эсрэг конвенцийн 2 дугаар зүйлд: (а) “Нийтийн албан тушаалтан” гэж:

1

оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн албан тушаалд томилогдон буюу сонгогдон, байнга буюу түр хугацаагаар, цалинтай буюу цалингүйгээр ажилладаг аливаа хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамааран;

2

оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг, түүний дотор нийтийн байгууллага буюу улсын үйлдвэрийн газарт зориулж нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа бусад хүнийг;

3

оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон аливаа бусад хүнийг тус тус хэлнэ. Харин энэхүү конвенцийн II бүлэгт заасан зарим тодорхой арга хэмжээний зорилгоор “нийтийн албан тушаалтан” гэж оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа хүнийг хэлж болно;⁴ гэж тусгасан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т **“нийтийн албан тушаалтан”** гэж уг хуулийн 4.1-д заасан этгээдийг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Харин дээрх хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан

4 НҮБ-ын Авлигын эсрэг конвенци, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2016, 7-р тал

албан тушаалтныг хамааруулахаар тусгасан бөгөөд уг зүйлд зааснаар дараахь албан тушаалтан “нийтийн албан тушаалтан”-д хамаарна:

Монгол Улсын Авлигын эсрэг хууль
4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчоос гадна улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтнууд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн удирдлага, нийтийн эрх ашгийг илэрхийлж байгаа буюу үр ашгийг нь нийтээрээ хүртэх гадаадын техникийн туслалцаатай хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж буй удирдах албан тушаалтнуудыг нийтийн албанд хамааруулдаг.⁵

5 АТГ, ОУХА, АНУ-ын Азийн сан, С.Оюунтуяа, Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага, УБ, 2015, 21-р тал

1.1.2. Нийтийн ашиг сонирхол

Нийтийн ашиг сонирхлыг янз бүрээр авч үзэж болно. Либераль үзэл санааны үүднээс нийтийн ашиг сонирхол нь өмчтэй байх, үг хэлэх зэрэг хувь хүний суурь эрхүүдээс бүрддэг байхад утилитар үзлийн үүднээс үүнийг хамт олны сайн сайхан гэсэн утгаар авч үзэх ба сайн сайхан гэдгийг хамт олны бие даасан гишүүн бүрийн сэтгэл хангалуун байдал гэж үздэг.⁶ Хувь хүн өөрийн хүлээсэн үүргээ гүйцэтгэж, бусад хүмүүсийн өмнө хүлээсэн бусад үүрэг хариуцлагаа биелүүлэн нийтийн сайн сайхны төлөө зүй зохистойгоор үйлчилдэг бөгөөд мөн тодорхой үүрэг хүлээх шаардлагатай.

Нийтийн ашиг сонирхол нь хувь хүний ашиг сонирхол, эсхүл бүлгийн сонирхлоос ялгаатай хамт олны буюу ихэнхдээ төрийн ашиг сонирхлоос бүрдэж, байгууллагын цогц зорилготой уялддаг. Нийтийн ашиг сонирхол нь иргэншил, төр улсын үүрэг, орон нутгийн эрх ашгийн талаарх ойлголтуудтай үргэлж өрсөлдөж байдаг.

“Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”-т “Нийтийн ашиг сонирхол гэдэг нь хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш, харин нийт иргэдийн нийтлэг сонирхол юм гэж тодорхойлсон байна.⁷

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийтийн ашиг сонирхол гэсэн нэр томъёог тодорхойлсон бөгөөд **“нийтийн ашиг сонирхол”** гэж **“нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг”** хэлнэ хэмээн тайлбарлажээ.

Олон нийтийн итгэл гэдэг нь нийтийн ашиг сонирхлын төлөө тэгш, шударга үйлчилнэ гэж сонгогдсон төлөөлөгчиддөө, томилогдсон албан тушаалтанд итгэх итгэл дээр иргэдийн хүлээлт суурилж байгааг хэлнэ.

Улс төрчид өөрийнхөө, эсхүл хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээд, тодорхой бүлгийн төлөө үйлчилж байвал тэдгээрт итгэх иргэдийн итгэл буурдаг.

6 Bozeman, B. (2007) Public Values and Public Interest: Counterbalancing Economic Individualism. Washington, DC: Georgetown University Press.

7 Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”, 87-р тал

Засгийн газар олон нийтийн итгэлийг буцаан олж авахын тулд хөнгөн шуурхай, уян хатан ажиллагаатай болж, нийгэмд шударга ёсыг тогтоох үйл хэрэгтэй илүү идэвхтэй, шинэлэг байдлаар хандах шаардлагатай болж байна. Иргэд аливаа асуудалд зүгээр нэг ажиглагчийн байр сууринаас ханддаг байснаа больсны дээр төр, засаг өөрсдийнх нь төлөө ямар нэг юм хийж өгөхийг хүлээхээсээ илүү хүссэн зүйлийг нь хийж гүйцэтгэх боломж олгохыг хүсэх болсон байна.⁸

Төр нь нийтийн ашиг сонирхлыг тодорхойлдог, яагаад гэвэл, хувь хүн, хамтын нийгэмлэгүүд өөрийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг⁹.

1.1.3. Хувийн ашиг сонирхол

“Сонирхол” гэж хувь хүн, эсхүл бүлэгт нөлөөлж болох аливаа зүйлийг хэлдэг.¹⁰ “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”-т дурдснаар “Хувийн ашиг сонирхол гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүнтэй хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг ойлгодог. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуутай бус байдал бий болгохыг зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал, өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно”¹¹ гэжээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т **“хувийн ашиг сонирхол”** гэж **“нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж** болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг” хэлнэ хэмээн тайлбарласан байна. Иймд ашиг сонирхлын

8 НҮБХХ, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар, УБ. 2018, 91-р тал

9 Alan lawton, Julie rayner and Karin lasthuizen, Ethics and management in the public sectors, 2013, p.37

10 ICAC, Managing Conflict of Interest in the Public Sector, Guidelines. 2004, p.8

11 Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”, 81-р тал

зөрчлийг тайлбарлахын өмнө **“хамаарал бүхий этгээд”**, **“нэгдмэл сонирхолтой этгээд”**, **“ашгийн төлөө үйл ажиллагаа”** зэрэг нэр томъёог ойлгох шаардлага гарч байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д **“хамаарал бүхий этгээд”** гэж “тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг”; тус хуулийн 3.1.6-д **“нэгдмэл сонирхолтой этгээд”** гэж “тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ” гэж, харин **“ашгийн төлөө үйл ажиллагаа”** гэж “Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг” хэлнэ хэмээн тус тус тодорхойлсон.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 3 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт
3.1.1. “нийтийн ашиг сонирхол” гэж “нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг хэлнэ”
3.1.2. “хувийн ашиг сонирхол” гэж “нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг”
3.1.5. “хамаарал бүхий этгээд” гэж “тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг”;
3.1.6. “нэгдмэл сонирхолтой этгээд” гэж “тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг”
3.1.7. “ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж “Компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг”.

“хамаарал бүхий этгээд”

- эцэг, эх,
- төрсөн ах, эгч, дүү,
- гэр бүлийн гишүүн,
- хамтран амьдрагч,
- эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү,
- бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг” хэлнэ.



1.2 | Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, ангилал, илрэх хэлбэр

Улсын салбарын ажилтны нийтлэг үүрэг нь батлагдсан ёс зүйн зарчимд нийцүүлэн зохих үүргээ гүйцэтгэхдээ нийтийн эрх ашгийн төлөө ажиллах явдал.¹²

Нийтийн албан тушаалтны хашиж байгаа ажил, алба зөвхөн нийтийн ашиг сонирхолд чиглэх бөгөөд тэрээр албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг өөрийн буюу хувийн ашиг сонирхлоос ангид байлгах зарчмыг баримтлан ажиллах ёстой. Энэ зарчим Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа, үйлчилгээ үзүүлж байгаа хүн бүрт буюу төрийн жинхэнэ албан хаагч, орон тооны болон орон тооны бус, түр, гэрээт ажилтан, удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх, сайн дурын ажилтан байхаас үл хамааран бүгдэд үйлчилнэ. Ашиг сонирхлын зөрчил гэж юу болох, түүнийг хэрхэн ангилдаг, ямар хэлбэрээр илэрдэг талаар доор авч үзье.

1.2.1. Ашиг сонирхлын зөрчил

Бодит байдал дээр ашиг сонирхлын зөрчил бол үйлдэл биш харин нөхцөл бөгөөд төрийн албан тушаалтан сонирхлын зөрчлийн нөхцөл тулгарсан ч авлигад автахгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой. **“Ашиг сонирхлын зөрчил гэдэг ойлголт бол заавал буруу үйлдлийг хэлдэггүй харин буруу үйлдэл хийж болзошгүй байдлыг хэлдэг.”**¹³ гэж судлаач эрдэмтэн W.Speck өгүүлсэн байдаг. Албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэх явцад нийтийн ашиг сонирхол түүний бусад сонирхлуудтай зөрчилдөх нөхцөл байдал үүссэн, үүсч болзошгүй тийм байдал тулгарч болно.

Их Британийн Төрийн албаны менежментийн дүрэмд ашиг сонирхлын зөрчлийг дараахь байдлаар тодорхойлсон байдаг:

Ашиг сонирхлын зөрчил нь албан тушаалтны санхүүгийн хувийн сонирхол, түүнчлэн илүү өргөн хүрээний ажил хэргийн хамаарал,

¹² ICAC, Managing Conflict of Interest in the Public Sector, Guidelines. 2004, p.10

¹³ Bruno W. Speck, Conflict of Interest: Concepts, Rules and Practices regarding Legislators in Latin America *The Latin Americanist*, Volume 49 Issue 2 (Feb 2008), p. 67.

*эсхүл холбогдох шийдвэр, хувийн сонирхлоороо холбогдсон этгээдтэй (Жишээ нь, ахан дүүсийн холбоо, нийгэмлэг, клуб, бусад байгууллагын гишүүнчлэл, гэр бүл гэх мэт) холбоотойгоор үүсч болно.*¹⁴

Хэрвээ хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой харшилдаж байвал нэг бол хувийн ашиг сонирхлоо хойш тавих, эсхүл төрийн албанаас чөлөөлөгдөх нь зүйн хэрэг.¹⁵ Төрийн албан тушаал хашиж буй хүн хэзээ ч ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд орж болно.

Ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд байна гэдэг нь төрийн албыг хувийн сонирхолд ашиглана гэсэн үг биш гэдгийг дээр онцолсон. *Нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөж буй албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь түүнийг албан үүргээ гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлж болох боловч тухайн тохиолдолд албан тушаалтан албан үүргээ хувийн ашиг сонирхлоос ангид хэрэгжүүлж болно.*

Хувийн сонирхол нь эдийн болон эдийн бус байж болохыг дээр өгүүлсэн. Гэр бүлийн гишүүнээ төрийн албанд ажилд ороход нөлөөлөх гэсэн албан тушаалтны сонирхол нь ихэнхдээ түүнд санхүүгийн ашиг авчрахгүй нь тодорхой юм.

Хувийн сонирхолтой холбоотой бас өөр нэг зүйл бол хувийн ашиг сонирхол биш атлаа нийтийн сонирхолтой зөрчилдөх ашиг сонирхлын асуудал юм. Энэ нь ялангуяа сонгуульт албан тушаалтанд хамаатай. Парламентын гишүүн жишээ нь, өөрийн сонгуулийн тойрог, эсхүл улс төрийн намын эрх ашгийн үүднээс нийтийн сонирхлын эсрэг зүйл хийх дарамтад орохыг үгүйсгэхгүй. Тухайлбал, сонгуульт албан тушаалтанд өөрийн улс төрийн намын сонгуулийн амжилтын төлөө албан тушаалаа ашиглах шахалт дарамт ирэх тохиолдол гарч болно.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай олон янзын тодорхойлолт бий. Доорх хүснэгтэд ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлолтоос доорх хүснэгтэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль, Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага

14 Их Британийн Төрийн албаны менежментийн дүрэм, 4.1.3 <http://www.civilservice.gov.uk/iam/codes/csmc/index.asp>

15 Л.Батжав, Б.Цэвээн, "Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу", УБ, 2009 он

болон “Транспаренси интернэйшнэл” байгууллага хэрхэн тодорхойлсныг харьцуулан харуулъя:

Ашиг сонирхлын зөрчил =>	“нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал”	Монгол Улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль ¹⁶
	“Нийтийн албан тушаалтан албан үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ гүйцэтгэлд зүй бусаар нөлөөлж болохуйц хувийн ашиг сонирхолтой байх буюу нийтийн албан тушаалтны албан үүрэг болон хувийн ашиг сонирхол хоорондын зөрчил” ¹⁷	Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ, 2003)
	“төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно”.	“Транспаренси интернэйшнэл” байгууллага

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд **“ашиг сонирхлын зөрчил”** гэж **“нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал”** гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, албан тушаалтны хувийн сонирхол түүний албан үүргийг давамгайлах тохиолдолд байгууллагын, цаашлаад олон нийтийн ашиг сонирхол орхигдох буюу зөрчигдөх нөхцөл байдал үүсдэг.

Тэгэхээр дээрх гурван тодорхойлолтын гол санааг нэгтгэн харвал, нийтийн албан тушаалтны хувьд нэг талаас олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг нь


¹⁶ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл, 2012

¹⁷ OECD, Managing Conflict of Interest in the Public Sector 2005, p.13


хувийн сонирхолтой нь зөрчилдөхийг, нөгөө талаас албан үүргээ хуулийн дагуу тэгш, шударгаар биелүүлэхэд зүй бусаар нөлөөлөх буюу харшлах нөхцөл байдлыг ашиг сонирхлын зөрчил гэж ойлгож болно.

Ашиг сонирхлын зөрчил нь нийтийн албан тушаалтны албан үүрэг ба хувийн ашиг сонирхол хоорондын зөрчил бөгөөд албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь албан үүргээ гүйцэтгэх, үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь зохисгүй нөлөөлж болно.¹⁸

Ашиг сонирхлын зөрчил



Ашиг сонирхлын зөрчлийн үр дагавар



албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлээгүй байх

Нийтийн ашиг сонирхол хувь хүний ашиг сонирхол, тодорхой бүлгийн ашиг сонирхлын нийлбэр цогц биш бөгөөд харин хамтын, бүх нийтийн ашиг сонирхол юм. Төрийн албан хаагчийн санхүүгийн, гэр бүлийн, найз нөхдийн зэрэг ямар ч төрлийн ашиг сонирхол албан ёсны шийдвэрт нөлөөлөх ёсгүй. Ашиг сонирхлын зөрчил нь аливаа байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд хохирол учруулж, олон түмний итгэх итгэлийг сулруулдаг тул шударга шийдвэр гаргах хэрэгтэй төдийгүй шийдвэр шударга гарч байгаа гэдэгт эргэлзээ төрүүлэхгүй байх хэрэгтэй.

18 ICAC, Managing Conflict of Interest in the Public Sector, Guidelines. 2004, p.6

Ашиг сонирхлын зөрчил нь гоц гойд, эсхүл зайлшгүй буруу зүйл биш. Харин түүнийг хэрхэн шийдвэрлэх нь чухал юм.¹⁹

1.1.2. Ашиг сонирхлын зөрчлийн ангилал, илрэх хэлбэр

Ашиг сонирхлын зөрчлийг шинж чанараас нь хамаарч дараахь байдлаар ангилж болно:



Бүдүүвч 1. Ашиг сонирхлын зөрчлийн ангилал

- **Бодит буюу одоо байгаа ашиг сонирхлын зөрчил.** Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлж болохоор байгаа буюу албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхэд хувийн сонирхол нь илтэд зүй бусаар нөлөөлж буй нөхцөл байдлыг хэлнэ. Жишээ нь: Таны удирдаж байгаа үнэлгээний хорооны хариуцсан тендерт танай ахын компани оролцож байгаа.
- **Төсөөлөгдөж буй ойлгогдохуйц ашиг сонирхлын зөрчил.** Тухайн ажилтан албан үүргээ гүйцэтгэж байхад хувийн ашиг сонирхол нь нөлөөлж байгаа гэж ойлгогдох нөхцөл байдал. Жишээ нь: эхнэр/нөхөр/-ийн тань дүү яаманд ажилд орохоор сонгон шалгаруулалтад орж байгаа. Та тэр яаманд газрын даргаар ажилладаг тул таныг ашиг сонирхлын зөрчилтэй хэмээн бусад хүн төсөөлж болзошгүй, эсхүл төсөөлнө. Өөрөөр хэлбэл, тухайн тохиолдолд таныг бусдад ашиг сонирхлын зөрчилтэй гэж бодогдуулахаар нөхцөл байдлыг ойлгоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д **“ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал”**

¹⁹ ICAC, Managing Conflict of Interest in the Public Sector, Guidelines. 2004, p.10

гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг хэлнэ” хэмээн тодорхойлсон байна.

Жишээ 1. Нийтийн албан тушаалтан хамт нэг ангид сурч байсан найзынхаа компанийг гүйцэтгэгчээр сонгож гэрээ байгуулсан. Тухайн тохиолдолд найзынхаа компанийг сонгох нь нийтийн албанд ашигтай байж болно. Мөн нийтийн албан тушаалтан энэ тохиолдолд хувийн сонирхолд авталгүй шийдвэр гаргасан гэж өөрөө итгэл үнэмшилтэй байж болно. Гэвч энэ тохиолдолд нийтийн албанд ашигтай учраас уу, эсхүл хувийн сонирхлын үүднээс тухайн шийдвэрт хүрсэн үү гэдгийг ялгах боломжгүй. Нийтийн сонирхлын үүднээс гарсан гэдэгт эргэлзээх үндэслэл байгаа учраас энэ төрлийн сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлагатай болдог.

- **Үүсч болзошгүй ашиг сонирхлын зөрчил.** Одоогоор сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсээгүй ч ирээдүйд тухайн ажилтны албан ажилд хувийн ашиг сонирхол нь нөлөөлж болзошгүй нөхцөл байдал буюу ирээдүйд бодит зөрчилд хүргэж болзошгүй нөхцөл байдал юм. Жишээ нь, таны хяналт тавьж ажилладаг дүүрэг буюу хорооны нутаг дэвсгэр дээр байгаа хувийн эмнэлгийг таны найз худалдан авах гэж байна. Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй боловч уг нөхцөл байдлаас ирээдүйд сонирхлын зөрчил бий болж болзошгүй.

Албан тушаалтан нь бодит ашиг сонирхлын зөрчилд орох, бодит ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй болон сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд орохоос зайлсхийх арга хэмжээ авах үүрэгтэй.

Жишээ 2. Албан тушаалтан нь ажил үүргийнхээ дагуу А компанитай холбогдох шийдвэр гаргах болсон ба тухайн албан тушаалтны гэр бүлийн хүн уг компанийн захирлаар 7 хоногийн дараа томилогдох нь тодорхой болсон. Энэ тохиолдолд сонирхлын зөрчил үүсээгүй боловч уг нөхцөл байдлаас ирээдүйд сонирхлын зөрчил бий болох нь гарцаагүй байна.

Албан тушаалтанд зөрчилт байдлыг үүсгэж буй хувийн сонирхлыг бүхэлд нь тоочин тодорхойлох боломжгүй тул хувийн эд хөрөнгө болон гэр бүлийн сонирхол, бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, шашны, хамт олны, нутаг усны нэгдэл, мэргэжлийн, улс төрийн, намын харилцаа холбоо гэх мэтээр нийтийн албан тушаал хашиж байгаа этгээд тухайн нөхцөлд үүргээ гүйцэтгэхэд зүй бусаар нөлөөлнө гэж ухаалгаар дүгнэж болох ямар ч хувийн сонирхол ашиг сонирхлын зөрчилд хүргэж болно гэж үздэг. Тухайлбал, “фаворитизм”, “кронизм”, “непотизм” гэх ойлголтууд үүнд хамаарах бөгөөд ажил мэргэжлийн ур чадварыг нь бодитой үнэлэхгүйгээр танил тал, найз нөхөд, хамаатан садандаа давуу байдал олгох, албан тушаалд томилох, тэдэнтэй гэрээ байгуулах, урамшуулал олгох зэрэг асуудлууд багтдаг.

Дайсагнал ба нөхөрлөлийн аль нь ч бодит, эсхүл төсөөлөгдөхүйц ашиг сонирхлын зөрчлийг үүсгэж болно.²⁰

1.1.3. Ашиг сонирхлын зөрчлийн илрэх хэлбэрүүд

Ашиг сонирхлын зөрчил нь дараахь нийтлэг хэлбэрээр илэрдэг.

- Албан тушаалтан хувийн сонирхлыг нь хөндөж буй шийдвэр гаргахад оролцох, шийдвэр гаргахад шууд болон шууд бусаар нөлөөлөх
- Нийтэд нээлттэй бус мэдээллийг хувьдаа ашиглах
- Ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө ивээл үзүүлж, давуу байдал олгох
- Албан тушаалтан бэлэг, хандив, үйлчилгээ авах, давуу байдал олгох
- Албан тушаалтан албан үүрэгт нь нөлөөлөхүйц болон хяналт тавьдаг байгууллагад давхар ажил эрхлэх
- Албан тушаалтан албанд байхдаа олж авсан мэдээлэл, харилцаа холбоог ашиглан албанаас гарсны дараа өөртөө ашиг олох гэх мэт.

Ашиг сонирхлын зөрчлийн нийтлэг хэлбэрүүдийг жишээгээр тайлбарлавал:

<p>Албан тушаалтан хувийн сонирхлыг нь хөндөж буй шийдвэр гаргахад оролцох, шийдвэр гаргахад шууд болон шууд бусаар нөлөөлөх</p>	<p>Жишээ нь, төсвийн байгууллага тоног төхөөрөмж нийлүүлэх компанийг сонгон шалгаруулахаар зарлажээ. Тендерийн үнэлгээний хорооны нэг гишүүн материалаа ирүүлсэн компанийн хувьцаа эзэмшдэг. Энэ нь түүнийг шийдвэр гаргахад нөлөөлж болно гэж үзэж болохоор байна.</p>
<p>Олон нийтэд нээлттэй бус албаны мэдээллийг хувьдаа ашиглах, ашиглахыг бусдад зөвшөөрөх</p>	<p>Жишээ нь, ажилтан байгууллагаа тендер зарлахаар төлөвлөж байгааг мэдээд найздаа хэлж өрсөлдөгчдөөсөө илүү бэлтгэх боломж олгон, олон нийтэд харахан нээлттэй бус, албаны мэдээллийг ашиглуулсан. Үүний дүнд шударгаар сонгон шалгаруулалт явуулах боломжгүй болж шударгаар өрсөлдөж буй бусад компаниудад хохиролтой болно.</p>
<p>Албан тушаалтан албан харилцаатай этгээдээс бэлэг, үйлчилгээ авах, хариуд нь ямар нэг давуу байдал олгох</p>	<p>Жишээ нь, Захирал өөрийн дасгалжуулдаг шатрын багаа аялал жуулчлалын компаниар ивээн тэтгүүлэн хариуд нь аялал жуулчлалын компаниас байгууллагаараа аялах үйлчилгээ авчээ. Энд ивээн тэтгүүлж хариуд нь бизнесийг нь дэмжин давуу байдал олгож байна.</p>
<p>Албан тушаалтан нь нийтийн албанд байхдаа олж авсан мэдээлэл, харилцаа холбоогоо ашиглан нийтийн албанаас гарсны дараа өөртөө ашиг олох, үйл ажиллагаанд нь хяналт тавьж байсан байгууллагад ажилд орох</p>	<p>Жишээ нь, нэгэн магадлан итгэмжлэлийн газрын удирдах ажилтан ажлаасаа чөлөөлөгдөнгүүт өмнө нь энэ байгууллагаар магадлан итгэмжлэгдэж байсан байгууллагад дотоод хяналт шалгалтын албаны даргаар томилогджээ. Энэ нь магадлан итгэмжлэхдээ давуу байдал, хөнгөлөлт үзүүлсэнийх нь хариуд ажилд авчээ гэж ойлгогдохоор байна.</p>

<p>Хуучин хамт ажиллаж байсан нийтийн албан тушаалтантай харьцах</p>	<p>Жишээ нь, төрийн нэгэн эрх мэдэл бүхий албан тушаалтан нэгэн компанийг хэд хэдэн том тендерт шалгаруулан, гэрээ хийгдсэний дараа ажлаасаа гарч тэр компанид ажилд оржээ. Байгууллагын албан хаагчид нь хамт ажиллаж байсан энэ албан тушаалтныхаа нөлөөнд автаж, түүний ажилладаг компанитай гэрээ байгуулсаар байж болзошгүй юм.</p>
<p>Ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө давуу байдал олгох</p>	<p>Жишээ нь, Албан тушаалтан албан үүрэгт нь нөлөөлөхүйц болон хяналт тавих үүрэгт нь багтдаг бусад байгууллагад давхар ажил эрхлэх, үйл ажиллагаанд нь өртөж буй аж ахуйн нэгжийн удирдах байгууллагын гишүүн байх ёсгүй²¹;</p>
<p>Фаворитизм буюу нэг талыг барих</p>	<p>Фаворитизм гэж эрх мэдлээ урвуулан ашиглаж танил тал, хамаатан садандаа бусдаас давуутай байдал олгохыг хэлнэ.²²</p>
<p>Непотизм</p> <p>Тайлбар: ‘cronyism’ ба ‘nepotism’ нь ойролцоо утгатай үгс боловч ‘cronyism’-ийг танил талын, ‘nepotism’-ийг хамаатан садангийн хүрээнд гол төлөв хэрэглэсэн байдаг.²³</p>	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, түүнийг зохицуулж чадаагүйгээс үүдэн гарах үр дагавруудын нэг бол непотизм юм. Уг ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг боловч үүнийг албан тушаалтан эрх мэдлээ ашиглан гэр бүлийн гишүүддээ давуу байдал (ажилд авах гэх мэт) олгох явдал гэж тодорхойлдог. Нийтийн албан дахь непотизм нь олон нийтийн эрх ашгийг хохироодог. Өөрөөр хэлбэл, тухайн албан тушаалд нэн тохиромжтой нэр дэвшигчийг томилохгүй, эсхүл тушаал дэвшүүлэхгүй бол үр дагаврыг олон нийт амсана. Нэг хамаатан нь нөгөөгийнхөө шууд удирдлагад ажиллахад зөрчил үүснэ гэж үзэн түүнээс зайлсхийх хэрэгтэй. Хууль тогтоомжоор эцэг, эх, ах, эгч, дүү, авга, нагац, эхнэр, нөхөр, хүү, охин, дагавар хүүхэд зэрэг хүмүүсийг нэг нь нөгөөгийнхөө шууд удирдлагад ажиллахыг хориглож болно²⁴.</p>

21 <http://www.info-evropa.rs/wp-content/uploads/2013/11/Londa-Esadze-Guidelines-for-Prevention-of-Conflict-of-Interest.pdf>

22 Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”, 43-р тал

23 Мөн тэнд, 67-р тал

24 ЕАБХАБ, Авлигатай тэмцэх гарын авлага, 2016, 81-р тал

Непотизмыг хориглохдоо хамаатнаа ажилд авахыг тэр чигт нь хязгаарлаж болохгүй. Харин непотизмыг бууруулах арга хэмжээ нь нийтийн албан тушаалтан гэр бүлийн гишүүнээ төрийн албан тушаалд ажиллуулахын тулд албан тушаалаа ашиглах (эсхүл урвуулан ашиглах)-ыг бууруулахад чиглэх ёстой. Үүний зорилго нь гэр бүлийн гишүүдийг хамтдаа ажиллахаас сэргийлэх бус гагцхүү албан хаагч олон нийтийн өмнөөс шийдвэр гаргахдаа чадварлаг боловсон хүчин ажилд авахын оронд гэр бүлийн гишүүндээ давуу байдал олгохоос сэргийлэх учиртай.

Непотизм нь доорх зүйлийн аль нэгийг, эсхүл хэд хэдийг нь агуулсан байдаг. Үүнд:

- Төрийн албан тушаал, эсхүл өөрийн хянаж, харъяалдаг байгууллагад гэр бүлийн ойрын гишүүн, эсхүл хамтран амьдрагчаа ажилд оруулах, албан тушаалд томилох, эгүүлэн томилох, албан тушаалын ангилал тогтоох, ангилал өөрчлөх, үнэлэх, тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, эсхүл сахилга бат сахиулахад оролцох буюу санал болгох;
- Гэр бүлийн ойрын гишүүн, хамтран амьдрагчийнхаа нөхөн олговрыг тогтооход оролцох;
- Гэр бүлийн ойрын гишүүн, эсхүл хамтран амьдрагчаа ажилд оруулах, албан тушаалд томилох, эгүүлэн томилох, албан тушаалын ангилал тогтоох, ангилал өөрчлөх, үнэлэх, тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, эсхүл сахилга бат сахиулахтай холбоотой аливаа ажил үүргийг доод албан тушаалтандаа өгөх;
- Гэр бүлийн ойрын гишүүн, эсхүл хамтран амьдрагчдаа шууд ба шууд бусаар зөвлөж зааварчлах, эсхүл ийнхүү зөвлөн зааварчлахыг доод албан тушаалтандаа үүрэг болгох.²⁵

25 Кинг Каунтигийн Ёс зүйн зөвлөл, Непотизм зөрчил болох нь, Зөвлөмж санал 95-11-1133, Вашингтон муж, АНУ <http://www.kingcounty.gov/employees/ethics/opinion/listing/family/1133.aspx>

Кронизм буюу тал тохой татах

Кронизм гэж ажил мэргэжлийн ур чадварыг нь бодитой үнэлэхгүйгээр танил тал, хамтран ажиллагчдад алагчилсан байдлаар давуутай хандахыг²⁶ хэлдэг.

Кронизм нь непотизмоос илүү өргөн хүрээтэй ойлголт. Непотизмыг цусан холбоо, эсхүл гэрлэлт, хамтран амьдрагчийн харилцаагаар нь тодорхойлох боломжтой байдаг бол кронизмыг эрх зүйн хувьд тодорхойлоход амаргүй байдаг. Албан тушаалтан нь нэр дэвшигчтэй харилцаа холбоотой бол тэрэрэ сонгон шалгаруулах үйл явцад оролцохгүй байх, харьяалах дээд албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлж болдог. Ер нь манай улсад аливаа сонирхлын зөрчил албан тушаалын томилгоо, ажилд орох, томилох үед хамгийн түгээмэл илэрдэг болохыг судалгаагаар тогтоосон байдаг. Тодруулбал, “Сонирхлын зөрчил ямар үед хамгийн их илэрдэг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон хүмүүсийн дийлэнх олонх нь буюу 60-аас дээш хувь нь “Ажилд авах, албан тушаал дэвшүүлэхэд” гэж хариулжээ.²⁷

Ямар нөхцөлд тухайн хүнийг танил тал гэж үзэх, мөн түүнд давуу тал олгох шийдвэрийг хэрхэн кронизм гэж ангилан үзэх вэ? Хамгийн гол нь, гаргасан шийдвэр нь бусад нэр дэвшигчид болон олон нийтийн хувьд шударга, үндэслэлтэй үү гэдэг л асуудал. Найз нөхөд, танил талаа тухайн албан тушаалд тохирох эсэхийг үл харгалзан нөхөрлөлийн үндсэн дээр шийдвэр гаргасан бол түүнийхээ хариуцлагыг хүлээдэг байх шаардлагатай.

26 Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”, 31-р тал

27 Д.Үлэмж <http://news.gogo.mn/r/123680>

1.3 | Ашиг сонирхлын зөрчил ба авлига

Ашиг сонирхлын зөрчил гэсэн ойлголт нь нэг талаас нийтийн албан тушаалтны ёс зүйн асуудал, нөгөө талаасаа авлигын урьдчилсан нөхцөл, шалтгаан бөгөөд албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэхэд хувийн сонирхол нь зүй бусаар нөлөөлсөн үед авлига үүсдэг. Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш, харин авлига бий болох хөрс суурь, шалтгаан болдог гэсэн үг. Товчоор хэлбэл, авлига бол ашиг сонирхлын зөрчлийн төгсгөлийн шат юм. Түүнчлэн авлига нь гэмт хэрэг бол ашиг сонирхлын зөрчил нь авлигатай харьцуулахад албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ танил тал харсан, алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдэг ихэвчлэн гэмт хэрэг болж хуульчлагдаагүй олон төрлийн зан үйлийн хэлбэрүүдийг багтаадаг. Иймээс төрийн албан тушаалтны хувийн сонирхол албан үүрэгтэй зөрчилдөхөд үүнийг зөв тодорхойлж, зөв удирдаж, оновчтой зохицуулахгүй бол сонирхлын зөрчил нь төрийн нөөцийг урвуулан ашигласан хууль бус үйлдэл, авлига болдог байна²⁸.

Авлига үргэлж ашиг сонирхлыг зөрчлийн тохиолдлыг өөртөө багтаадаг бол харин ашиг сонирхлын зөрчлийн тохиолдол бүр авлига болдоггүй. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чухал арга хэрэгсэл юм. ²⁹

Жишээ 3. Германд “ашиг олох” гэж нэрлэгддэг ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэрэгт дараахь зүйлс хамаардаг:

- Мөнгө, ваучер, жетон
- Үнэт гоёлын эдлэл
- Цахим хэрэгсэл зэрэг хувийн хэрэгцээний тоног төхөөрөмж
- Зээлийн хүүг бууруулах
- Илтэд амьдралынх нь өртөг буурах
- Давхар эрхэлж буй ажилдаа хэт өндөр цалин авах
- Хамаатан саднаа ажилд авах
- Унааны билет
- Үнэтэй хоол
- Тусгай шан урамшуулал
- Сексийн шинжтэй үйлчилгээ²⁹

28 Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу”, УБ, 2009 он

29 МануэльВиллориа-Мендиета, Политика и практика конфликтов интересов в девятистранах-членахес: сравнительный обзор, Доклад подготовлен для организации Sigma, 2005, стр. 16-17

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГА, ҮНДСЭН АРГА ЗАМ, МЕХАНИЗМ

2.1 | Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлага

Ашиг сонирхлын зөрчлөөс байнга зайлсхийх, эсхүл хориглох боломжгүй юм. Ашиг сонирхлын зайлшгүй зөрчлийг тодорхойлох, тодруулах, үр дүнтэй зохицуулах шаардлагатай.¹

НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцид Оролцогч бүр ийтийн албан тушаалтан нь нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаар зохих эрх бүхий холбогдох байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог тогтоохыг чармайна.² гэж заасан байдаг.

1 ICAC, Managing Conflict of Interest in the Public Sector, Guidelines. 2004, p.7

2 Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, НҮБАЭЖ, УБ, 2016, 11, 12-р тал

Албан тушаалаа урвуулан ашиглах боломжийг бууруулж, ашиг сонирхлын зөрчил байгаа бол түүнийг мэдүүлж, урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд шийтгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар шударга байдлыг тогтоох нь шийдлүүдийн гол зорилго билээ.³

- Ашиг сонирхлын зөрчил нь нийтийн албан тушаалтан албан үүргээ тэгш шударгаар, бодитойгоор гүйцэтгэхэд нөлөөлөх, нөлөөлөхүйц хувийн болон бусад сонирхлын үед үүсдэг.
- Улсын салбарт ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах гол асуудал нь авлигад хүргэхээр ашиг сонирхлоос сэргийлэх явдал юм.
- Тодорхой үйлдлийг буюу ашиг сонирхлыг хязгаарлах, хориглох нь зохицуулалтын үндсэн арга бөгөөд түүнийг бусад аргатай хослуулан хэрэглэж ашиг сонирхлын зөрчлийг үүссэн даруйд шийдвэрлэх, зохицуулах боломж бий.
- Ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт нь төрийн албан тушаалтанд үүрэг хүлээлгэхээс гадна зүй бус хандлагыг өөрчлөхөд туслах, төрийн албаны соёлыг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг.

Ашиг сонирхлын зөрчлийг авлигатай андуурах хандлага түгээмэл байдаг гэж дээр дурдсан. Ингэж андуурах нь ашиг сонирхлын зөрчлийг бүрэн хэмжээнд сэргийлэх, сэргийлэхийг оролдох, төрийн албан үүргээс гадна зарим албан тушаал эрхлэх, эд хөрөнгө өмчлөх, бусад сонирхолтой байхыг хориглох зэргээр их өргөн хэмжээний хориг, хязгаарлалт хийх хандлагыг бий болгох үр дагавартай.

Дээрх үндэслэл жишээнээс үзэхэд бүх ашиг сонирхлын зөрчлийг шуудхан л сэргийлэх, хориглох боломж байхгүй. Тодорхой албан тушаалыг давхар эрхлэх, хувийн секторт эд хөрөнгө өмчлөхтэй холбоотой зарим сонирхлын зөрчлийг хориглож болно. Албан тушаалтанд тулгарч болох зарим ашиг сонирхлын зөрчлийг үүссэн тухайн онцлог нөхцөл байдалд нь тохируулан зохицуулан шийдвэрлэх арга зам байх ёстой.

Тиймээс ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад дараахь зорилгыг дэвшүүлэн тавьдаг:

- Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл үүсэхээс боломжтой хэмжээгээр, хэрэгжиж болохуйц байдлаар сэргийлэх;

3 OECD, Managing Conflict of Interest in the Public Sector, 2003

- Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл үүссэн тохиолдолд түүнийг шийдвэрлэх дүрэм журмыг бий болгох;
- Төрийн албан тушаалтанд зааварчилгаа өгөх, өөрийгөө хялбар байдлаар хамгаалах боломж олгох.

Эдгээр зорилгыг хангах арга зам, механизм нь тодорхой үйл ажиллагаа, ашиг сонирхлыг хориглох, хязгаарлах, мэдүүлэг гаргуулах, ашиг сонирхлын зөрчлийн нөхцөлд шийдвэр гаргах үйл явцаас татгалзах үүрэг хүлээлгэх зэргийг багтаадаг.

Нийтийн албан тушаалтны ёс зүй, зан үйл, сахилгын дүрэм, эсхүл ашиг сонирхлын зөрчлийн хуулийн хэлэлцүүлэг хийх нь аргачлалын хувьд ач холбогдолтой гэж үздэг. **Ёс зүйн дүрэм, сонирхлын зөрчлийн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн хууль дүрэмд хамаарагдах хүмүүст дүрэм журмыг сайтар ойлгуулах шаардлагатай.** АНУ-ын Гүйцэтгэх засаглалын албан хаагчдын ёс зүйн дүрмийн⁴ төслийг бүх гүйцэтгэх засаглалын албан хаагчдаас санал авч нэлээд засвар өөрчлөлт хийсэн урт удаан үйл явцын дараа баталсан билээ. Иймэрхүү үйл явц нь төрийн албан хаагчид уг дүрмийг сайтар ойлгоход дөхөм болдог.

Сонирхлын зөрчлийг зохицуулснаар авлигаас наагуурх олон төрлийн зөрчлүүдэд хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх төдийгүй тохирсон хариуцлагыг оногдуулснаар дахин сонирхлын зөрчлийн нөхцөл байдалд хүргэхгүйгээр урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтнуудын дунд сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрмэлзлэл, ёс зүйн соёл бий болгох ач холбогдолтой. Мөн сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлуудыг анхнаас нь зохицуулан шийдвэрлэдэг тул нийтийн албан тушаалтныг олон нийтийн хоосон хардлагаас хамгаалж байдаг.

Томас Жефферсон(1807) “Хүмүүс олон нийтийн итгэлийг хүлээсэн үед өөрийгөө нийтийн өмч гэж үзэх ёстой”⁵ гэж хэлсэн байдаг. Өнөөдөр нийтийн албан тушаалтнууд олон нийтийн итгэлийг хүлээж, тэдний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай байх боловч албан тушаалд сонгогдохыг хувийнхаа бизнесийн ашиг сонирхлыг дэмжих хэрэгсэл гэж ойлгож байгаа байдал ажиглагддаг.

4 http://www.usoge.gov/laws_regs/regulations/5cfr2635.aspx

5 Alan Lawton, Julie Rayner and Karin Lasthuizen, Ethics and Management in the Public Sector, 2012, p.44

Сүүлийн жилүүдэд нийтийн болон хувийн хэвшил хооронд боловсон хүчний шилжилт хөдөлгөөн нэлээд хийгдэж, төрийн үйлчилгээ үзүүлэх чиглэлд эдгээр салбарын хамтын ажиллагаа нэмэгдэх болсон нь төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхэд нь түүний хувийн ашиг сонирхол зүй бусаар нөлөөлөх (эсхүл нөлөөлөхийг завдах) “саарал орон зай” тэлсээр байна.⁶

Төр, хувийн хэвшлийн хооронд олон тооны гэрээ хийгдэж, төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Ингэж хувийн болон сайн дурын байгууллагаар дамжуулан төрийн үйлчилгээг хүргэх нь нөгөө талдаа нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагааны уламжлал, төрийн үйлчилгээний ёс зүйг бүдгэрүүлж болзошгүй юм. Энэ үед зохицуулаагүй ашиг сонирхлын зөрчил нь эдийн засгийн үүднээс авч үзвэл үр ашиггүй зардал гаргах, хөрөнгө оруулалтыг хязгаарлах зэргээр улс орны эдийн засгийн хөгжлийг удаашруулж гадна шударга өрсөлдөөнийг хязгаарлаж олон түмнийг асар их бухимдуулдаг аж.

Ашиг сонирхлын зөрчлийг зүй зохистой тодорхойлж, мэдээлж, үр нөлөөтэй, ил тод байхаар зохицуулахгүй бол сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд гүйцэтгэсэн нийтийн албан тушаалтны гаргасан аливаа шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь ёс зүйн алдаатай, албан тушаалаа урвуулан ашигласан байдаг бөгөөд цаашилбал авлигын гэмт хэрэг болдог. Ингэснээр нийтийн албан тушаалтнууд эрх мэдлээ хувьдаа бус олон нийтэд зориулна гэсэн олон нийтийн итгэлийг алдагдуулж, нийтийн албаны нэр хүнд унах нөхцөл байдалд хүрнэ. Иймд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь нэн тэргүүний хийх ажлын нэг юм.



Бүдүүвч 2. Ашиг сонирхлын зөрчил ба авлигын хамаарал

⁶ М.Полейни, НҮБАЭК-ийн гарын авлага, 2015, Лондонгийн Олон улсын хуулийг практикт хэрэгжүүлэх төв, Авлигын эсрэг форум <http://www.iclp.org/wp-content/uploads/2015/02/Guide-tothe-UN-Convention-Against-Corruption-Martin-Polaine.pdf>

2.2 | Үндсэн механизм

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах механизмын үндсэн зорилго нь шийдвэрүүдийг зохих журмын дагуу хууль зүйн үндэслэлтэй, алдаагүй гаргахыг баталгаажуулах явдал юм.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах олон арга зам байдаг. Тухайлбал:

- ⇒ Хууль тогтоомжоор хориглох
- ⇒ Холбогдох хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх
- ⇒ Мэдүүлэг гаргуулах
- ⇒ Ёс зүйн дүрмийг сахиулах буюу албан хаагчдын ухамсар, хариуцлагыг дээшлүүлэх
- ⇒ Ашиг сонирхлыг мэдэгдэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- ⇒ Удирдах албан тушаалтан үлгэр дуурайл үзүүлэх гэх мэт

Гэхдээ улс орнууд дараахь гурван үндсэн зохицуулалтыг түлхүү ашигладаг. Үүнд:

- ◆ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулах буюу албан тушаалтанд өөрийн сонирхлоо ерөнхийд нь, эсхүл шаардлагатай үед тохиолдлын буюу цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан мэдүүлэг гаргах үүрэг хүлээлгэх;
- ◆ Хориг тавих буюу албан тушаалтныг тодорхой үйл ажиллагаа эрхлэх, албан тушаал давхар гүйцэтгэх, бусад сонирхолтой байх зэргийг хориглох;
- ◆ Шийдвэр гаргах үйл явцаас тусгаарлах буюу сонирхлын зөрчилтэй нөхцөлд тухайн төрийн албан тушаалтныг шийдвэр гаргах болон бусад холбогдох үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, эсхүл албан тушаалтан өөрийгөө тусгаарлах.

Эдгээр зохицуулалтыг үндсэндээ Төрийн албаны хууль, Сонирхлын зөрчлийн хууль, Ёс зүйн дүрэм гэсэн гурван хэлбэрээр дамжуулан хэрэгжүүлдэг. Гадаадын улс орнууд ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх болон шийдвэрлэх механизмыг тусгасан тусгай хууль, дүрэм журмыг баталсан байдаг. Зарим улсууд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон шийдвэрлэх цогц тогтолцоог бүрдүүлсэн, тухайлбал, Канад Улс 2006 онд Ашиг сонирхлын

зөрчлийн тусгай хуулийг батлан мөрдөж байна. Ихэнх улс ёс зүйн дүрмийг баталсан ч төрийн байгууллага бүр ёс зүйн дүрмээ илүү нарийвчлан гаргах нь зөв гэж үздэг. Жишээ нь, 2003 онд батлагдсан Кенийн Төрийн албан тушаалтны ёс зүйн хуульд⁷ ерөнхий дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, түүний дотор зан үйлийн дүрмийг зохицуулсан байдаг ба үүнээс гадна төрийн байгууллага бүр өөрийн дотоод дүрмийг батлах үүргийг хүлээлгэсэн байдаг. Их Британи Улсын хувьд төрийн албан хаагчид, сонгуульт албан тушаалтны асуудлыг ихэнхдээ дүрмээр зохицуулдаг.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахын тулд ямар механизмыг хэрэглэх нь тийм ч чухал биш байж магад. Гэхдээ **байгууллагын үйл ажиллагааны онцлогийг дүрэм журамд тусгахын тулд ёс зүйн/зан үйлийн дүрэм бий болгох аргыг хэрэглэх нь чухал**. Ес зүйн дүрэмтэй байх үүргийг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 8 дугаар зүйлд “оролцогч улс бүр нийтийн чиг үүргийг зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу стандартыг өөрийн институцийн болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна. Оролцогч улс бүр тогтоосон ёс зүйн дүрэм буюу стандартыг зөрчсөн нийтийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ” гэж заасан байдаг⁸.

Ёс зүйн дүрмийг заавал хуульчлах шаардлагагүй. Төрийн албанд **ёс зүйн дүрэм нь албан тушаалтны хүлээсэн үүрэг** болдог.

Мөн албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг үүрэг болгосон заалтыг хуульд тусгасан байдаг. Жишээ нь Кенийн хуульд “Төрийн албан тушаалтан нь нийтийн сонирхол түүний хувийн сонирхолтой зөрчилдөхөөс сэргийлэхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргах үүрэг хүлээнэ” гэж заасан байдаг. Их Британийн Дээд танхимын Зан үйлийн дүрэмд “Гишүүд өөрийн зан үйлээ төрийн үйл хэрэгт нийцүүлэх үүрэгтэй ба сонирхлын зөрчлөөс сэргийлж, зөрчил гарсан тохиолдолд төрийн сонирхлыг дээгүүрт тавина.”⁹ гэсэн байна. Тохиолдож болох бүх нөхцөлийг хуулийн заалт, заавар зөвлөмжид бүрэн тусгах боломжгүй учраас ийм ерөнхий заалт ихээхэн чухал байдаг. Ёс зүйн хэм хэмжээний нэг чухал хэсэг бол төрийн албан тушаалтанд шаардлагатай үед заавар зөвлөмж өгөх тухай заалт байдаг байна.

7 http://www.marsgroupkenya.org/Reports/LawsandConventions/Kenya_PublicOfficer_Ethics_Act_2003.pdf

8 НҮБ-ын Авлигын эсрэг конвенци, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2016

9 <http://www.publications.parliament.uk/pa/cm/code.pdf>

Дээр дурдсан гурван төрлийн зохицуулалтын арга хэрэгслийг тодруулан үзье.

◆ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулах

Ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх нэг арга зам бол албан тушаалтнаар хувийн сонирхлын мэдүүлэг гаргуулах явдал бөгөөд энэ нь ил тод байдлыг бий болгох, албан тушаалтан өөрийн ашиг сонирхол, үүргээ эрэмбэд оруулахад ач холбогдолтой. Мөн шийдвэр гаргах үйл явцаас тусгаарлах, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөлийг илрүүлэх зэрэг бусад зохицуулалтыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл нь болдог. Иймд хувийн ашиг сонирхлоо мэдүүлэх механизмыг бүрдүүлэх нь чухал. Хамгийн гол нь зохицуулалтыг төрийн өөр өөр ангиллын албан тушаалтнуудад тохируулан зүй зохистойгоор найрийвчлан боловсруулах, ил тод байдлыг дээд зэргээр нэмэгдүүлэх, зохих шаардлагыг хангахад нь албан тушаалтнуудад заавар чиглэл, туслалцаа үзүүлж, зөвлөдөг байх шаардлагатай.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 8(5) дугаар зүйлд:

Төрийн албан тушаалтан нь төрийн албан тушаалтны хувьд гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбогдуулан сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлогын талаар эрх бүхий холбогдох байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог зохих тохиолдолд дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн тогтоохыг оролцогч улс бүр чармайна.¹⁰ гэж заасан.

Ашиг сонирхлын мэдүүлэг ба эд хөрөнгө, орлогын мэдүүлгийн ялгаа заагийг сайтар тодруулах нь зүйтэй. Хөрөнгө, орлогын мэдүүлэг бол санхүүгийн орлого, өмчлөлийн асуудалтай холбоотой бол хувийн сонирхлын мэдүүлэг өргөн хүрээний ашиг сонирхлыг багтаадаг бөгөөд зарим сонирхол нь мэдүүлэг гаргах хүртэл ямар нэг тодорхой ашиг өгөөгүй ч байж болно.

Нийтийн албан тушаалтны хувьд хэзээ нэг өдөр сонирхлын зөрчилд оруулах аливаа хувийн сонирхолтой байхаас сэргийлэх боломжгүй тул өөрийн хувийн сонирхол, эд хөрөнгөө мэдүүлэх үүрэг хүлээдэг. Хувийн сонирхлоо мэдүүлэх үүрэг хүлээлгэхийн өмнө аль түвшний албан тушаалтан мэдүүлэг

¹⁰ <http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/index.html>

гаргах, мэдүүлэг гаргах давтамж, гэр бүлийн сонирхлыг мэдүүлэгт оруулах хэмжээ хязгаар зэргийг шийдэх хэрэгтэй.¹¹

1990 оноос эхлээд зарим орнуудад сонгуульт албан тушаалтнуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд хувийн сонирхлын мэдүүлэг гаргуулдаг болсон. Сонгуульт албан тушаалтнуудын зайлшгүй мэдүүлэх ёстой ашиг сонирхлын жагсаалтыг гаргасан байдаг. Энэтхэгт парламентын дээд танхимийн гишүүдийг сонирхлын мэдүүлгээ дараах үзүүлэлтээр гаргахыг шаарддаг: удирдах зөвлөлд цалинтай ажиллах, тогтмол цалинтай ажил, хяналтын үүрэг бүхий хувьцаа эзэмших, цалинтай зөвлөх үйлчилгээ, мэргэжлийн ажлууд.¹² Үүний зэрэгцээ тэд хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн мэдүүлгээ нарийвчлан гаргах үүрэг хүлээдэг.

Орлого, эд хөрөнгийн хувьд ямар хэмжээний санхүүгийн босго тавигдсан болон ямар төрлийн сонирхлыг мэдүүлэх талаар тодорхой зааварчилгаа өгөх нь чухал байдаг.

Ашиг сонирхлын мэдүүлгийг шаардлагатай үед тохиолдлын байдлаар мэдүүлэх үүргийг хуулиар оногдуулах явдал байдаг. Өмнөд Африкийн Парламентын гишүүн нь дараахь үүрэгтэй:

Хорооны гишүүн нь парламентын чуулган, зөвлөл, хороонд хамааралтай асуудлаарх өөрийн болон өөрийн гэр бүлийн эхнэр, нөхөр байнгын хамтран амьдрагч, бизнесийн хамтрагчийн хувийн ба хувийн санхүү, бизнесийн сонирхлоо мэдүүлнэ¹³.

Энэтхэгийн Парламентын Дээд танхимын Үйл ажиллагааны дүрэмд дараахь байдлаар заасан байна:

Парламентын гишүүн нь танхим, хороогоор хэлэлцэж буй асуудлаарх шууд болон шууд бус мөнгөн сонирхлоо сонирхлын бүртгэлд мэдүүлсэн байсан ч уг сонирхлын шинж чанарыг талаар Танхим, хороонд мэдүүлнэ.....¹⁴

Гишүүдийн ашиг сонирхлыг бүртгэх газар нь гишүүд чухам ямар сонирхлоо бүртгүүлэхийг тодорхой хэмжээнд ангилан заасан байдаг. Их Британийн ёс зүйн дүрэмд сонирхлын мэдүүлгийн төрлийг Өмнөд Африк, Энэтхэгийнхээс

11 G. Carney, Conflict of Interest: Legislators, Ministers and Public Officials, Transparency International Working Paper, 1998.

12 http://164.100.24.167/template/mem_interest.pdf

13 Өмнөд Африкийн Парламентын Ёс зүйн дүрэм, 11-р бүлэг http://www.parliament.gov.za/live/content.php?Item_ID=235

14 Парламентын Ёс зүйн дүрэм, 294(1)-р дүрэм, http://rajyasabha.gov.in/com_ethics/ethics_main.asp

илүү дэлгэрэнгүй заасан байдаг. “Гишүүд өөрийн сонирхлоо бүрэн хэмжээгээр мэдүүлэх үүрэгтэй бөгөөд сонирхлын мэдүүлэг өгөх төрөлд тодорхойлон зааснаас өөр төрлийн сонирхлоо мэдүүлэх үүрэгтэй”, “Үг хэлэх, төлөөлөх, асуулт хариултын явцад нөлөөлнө гэж бусдад үндэслэлтэйгээр ойлгогдохоор мөнгөн сонирхлоо мэдүүлэх үүрэгтэй”.¹⁵

Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргахаас зайлсхийн, сонирхлын зөрчилд орохоор байна гэж үзвэл түүнийгээ заавал мэдүүлж, мэдүүлээгүй бол хариуцлага хүлээдэг.

◆ Хориг тавих

Нийтийн албан тушаалтныг зарим албан тушаал, үйл ажиллагаа давхар эрхлэх, өөр тодорхой зарим сонирхолтой байхыг хориглох нь хамгийн чанга зохицуулалт юм. Ихэвчлэн дараахь зүйлийг хориглосон байдаг:

- засгийн газрын өөр байгууллагад албан тушаал эрхлэх
- албан тушаалын дагуу захирагдах хүрээний байгууллагад албан тушаал эрхлэх,
- хувийн хэвшилд ажиллах
- хуулийн этгээдийн дүрмийн дагуу байгуулагдсан бүтцэд албан тушаал эрхлэх
- хувийн байгууллагад гэрээгээр ажиллах
- төрийн өмчлөлийн болон төрийн байгууллагатай бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хуулийн этгээдийн хувьцааг эзэмших
- засгийн газар, эсхүл өөрийн ажиллаж буй засгийн газрын байгууллагатай хийх гэрээний нэг тал болох
- төрийн албан ажлаа дуусгавар болгосны дараа хэсэг хугацаанд төрийн байгууллагатай бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд ажил эрхлэх, хувийн сонирхолтой байх

Эдгээр арга хэмжээг заавал хэрэглэнэ гэсэн үг бөгөөд тухайн нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Жишээ нь, 2003 онд батлагдсан Кени Улсын Төрийн албан тушаалтны ёс зүйн хуульд “компанийн хувьцаа эзэмших, хувийн аливаа сонирхолтой байх нь тухайн албан тушаалтны албан үүрэгт харшлахгүй бол” хувьцаа эзэмших, эсхүл аливаа сонирхолтой байхыг хориглоогүй байдаг.

15 Дээд танхимын Ёс зүйн дүрэм 2005, заалт 57. <http://www.publications.parliament.uk/pa/cm/code.pdf>.

Хууль тогтоох байгууллагын гишүүдэд дараахь нийтлэг хоригийг тувьдаг:

- Засгийн газрын өөр байгууллагад албан тушаал эрхлэхийг хориглох- энэ нь нийтлэг хэрэглэгддэг хориг боловч нэлээн маргаан дагуулдаг. Ардчилсан зарим орнуудад жишээ нь, Францад Парламентын гишүүн нь орон нутгийн сонгуульт албан тушаал эрхэлж болдог байна.
- Төрийн албан тушаал эрхэлж байхдаа засгийн газартай гэрээ хийсэн компанитай ямар нэг хувийн сонирхлоор холбоотой байх
- Парламентын гишүүний үүрэгт ажлаа хэрэгжүүлэхэд саад болох давхар ажил эрхлэх, ашиг сонирхолтой байх

Сонгуульт албан тушаалтанд эдгээр үндсэн хоригоос өөр хязгаарлалт хийх гэхээсээ илүүтэй сонирхлоо мэдүүлэх үүргийг онцлох, хувийн сонирхолтой асуудлаар шийдвэр гаргах үйл явцаас тусгаарлах үүргийг онцлох нь илүү түгээмэл, илүүд үзүүштэй байдаг. Хувийн ашиг сонирхлын талаар мэдүүлэх, мэдэгдэх, тусгаарлах үүргүүд өөр хоорондоо харилцан холбоотой.

◆ Шийдвэр гаргах үйл явцаас тусгаарлах

Ашиг сонирхлын мэдүүлгийг тохиолдлын байдлаар гаргах нь өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтны нөлөөлж болох, нөлөөлөхүйцээр харагдаж буй үйл ажиллагаатай холбогдох сонирхлын зөрчлийг шийдвэрлэх үйл явцын зөвхөн эхний шат. Үүний дараа дараахь алхмын аль нэгийг хийдэг:

- удирдах албан тушаалтны зүгээс уг зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргах, ялангуяа тухайн албан тушаалтныг үг үйл явцад цаашид оролцохоос тусгаарласан шийдвэр гаргах,
- тухайн албан тушаалтан өөрийгөө тусгаарлах.

Кенид, төрийн албан хаагч нь сонирхлын зөрчлийн талаар удирдах албан тушаалтандаа мэдэгдэхээс гадна “тухайн асуудлаарх аливаа үйл явцад оролцохоос татгалзах” үүрэг хүлээдэг. Удирдах албан тушаалтны шийдвэрээр үү, эсхүл албан тушаалтан өөрийгөө тусгаарлах үүрэгтэй байх уу гэдэг чухал асуудал.

Сонгуульт албан тушаалтны хувьд, шийдвэр гаргах үйл явцаас өөрийгөө тусгаарлах үүрэгт онцлох ач холбогдол өгдөг. Зарим оронд тухайлбал, АНУ, Канад, Австралийн парламентад гишүүдээс сонирхлын мэдүүлэг гаргахыг

бус, харин өөрийн санхүүгийн сонирхол бүхий асуудлаар санал өгөхөөс татгалзахыг шаарддаг гэж G. Carney тэмдэглэсэн байдаг.¹⁶

Өмнөд Африкт хууль тогтоогчид нэлээд хатуу үүрэг хүлээсэн байдаг. Ашиг сонирхлын мэдүүлгээ өгсний дараа парламентын гишүүд “хэрвээ хороо, чуулганаас тухайн гишүүний сонирхол чухал биш, холбогдолгүй гэж шийдээгүй бол хэлэлцүүлэг, үйл явцаас тусгаар байх” ёстой. Сонгуульт албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг өгөхийн зэрэгцээ тухайн асуудлаар өрнөх үйл явдлаас өөрийгөө тусгаарлах эсэх асуудал давхар яригддаг. Иймээс, парламентын гишүүд өөрийн эдийн сонирхол бүхий асуудлаар хэлэлцэгдэж буй үйл явцаас өөрийгөө тусгаарлах үүргийг тусгах нь хууль тогтоогчдын ёс зүйн зохицуулалтын үр дүнтэй хэсэг гэж үздэг. Ялангуяа, ‘сонирхол’ гэдэгт парламентын гишүүний сонгуулийн тойргийн сонирхлыг хамрахаар өргөн хэмжээгээр тогтоохгүй байх хэрэгтэй. Их Британийн жишээг авья: тэнд зөвхөн явцуу хүрээний сонирхлоо мэдүүлэх аргыг хэрэглэсэн байдаг. Сүүний үйлдвэрлэл эрхэлдэг парламентын гишүүний жишээг G. Carney авсан байна. Их Британийн ёс зүйн дүрмээр бол гишүүн өөрийн тойргийн бүх сүүний үйлдвэрлэгчдийг дэмжих хууль тогтоомжид санал өгөх эрхтэй. Харин зөвхөн өөрийн сүүний үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжид санал өгөхийг зөвшөөрдөггүй¹⁷. Хэрвээ эхний тохиолдолд гишүүнийг тусгаарлахаар зохицуулсан бол тухайн гишүүн өөрийн тойргийнхний эрх ашгийн төлөө ажиллах үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болно гэсэн үг юм.

Илт ашиг сонирхлын зөрчлийн жишээ нь нийтийн албан тушаалтан, түүний найз нөхөд, эсхүл хамаарал бүхий этгээд нь компанитай байх, тэрхүү компани нь тендерийн шалгаруулалтад оролцоо гэхэд тендерийг үнэлэхэд нийтийн албан тушаалтан оролцох, эсхүл өөрийн эрх мэдэл, нөлөөгөө ашиглан зохицуулалт хийх явдал гардаг.

Ашиг сонирхлын зөрчил заримдаа илт биш байж болно. Үүний шалтгааныг тодруулахын тулд шинжилгээ судалгаа хийх шаардлага гарна. Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүйг тодорхойлоход албан хаагчдад шалгах хуудас хэрэглэж болно.

Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд түүнийг шууд удирдлагадаа, хэрэв холбогдох асуудлыг хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж, зөвлөмж зааварчилгаа авах шаардлагатай.

¹⁶ G. Carney, Conflict of Interest: Legislators, Ministers and Public Officials, TI, Working Paper, 1998.

¹⁷ Мөн тэнд

Ашиг сонирхлын зарим зөрчил жижиг зөрчлүүд байдаг тул тэдгээрийг шийдвэр гаргах үйл явцад оролцож буй этгээдэд мэдэгдэхэд л болдог аж. Жишээ нь, албан тушаалтан нэгэн компанийн бага хэмжээний хувьцаа эзэмшдэг бөгөөд шалгагдаж байгаа тодорхой асуудлын үр дүн нь тэдгээр хувьцааны үнэд айхтар нөлөөгүй байх тохиолдолд оролцогч талууд тухайн албан тушаалтныг шийдвэр гаргах үйл явцад үргэлжлэн оролцохыг нэг их цааргалахгүй. Харин оролцуулахаас татгалзвал, тухайн албан тушаалтан нь уг үйл ажиллагаанаас чөлөөлөгдөнө.

Ашиг сонирхлын зөрчлийг төвөггүй тодорхойлж, удирдан зохицуулахын тулд байгууллага, газар, хэлтэс зэрэг нэгж болон бусад этгээд нь:

- Шийдвэр гаргах үйл явцыг бүрэн дүүрэн, үнэн зөв баримтжуулах;
- Байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр, үйл явцын талаарх мэдээллийг олон нийтэд үнэн зөв хүргэх замаар нээлттэй, ил тод байдлыг хангах;
- Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй эрсдэл бий болсон тохиолдолд бүх оролцогчдын эцсийн шийдвэрийг нотолгоо болгож баримтжуулах шаардлагатай.¹⁸

2.3 | Монгол Улсын хууль тогтоомж ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ба зохицуулах механизм

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг оновчтой зохицуулах нь нийтийн болон албан тушаалтны хувийн ашиг сонирхлын хоорондын тэнцвэрийг хадгалах зорилготой. Хэт чанга хатуу арга барил нь нийтийн албан тушаалтны бусад эрхүүдийг зөрчиж чадварлаг ажилтнуудыг нийтийн албанд ажиллах сонирхолгүй болгож болзошгүй. Улс орнууд сонирхлын зөрчлийг хууль тогтоомжоор, эсхүл нийтийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулах нь нийтлэг байдгийг өмнө өгүүлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх дараахь зохицуулалтын механизм үйлчилж байна:

18. ЕАБХАБ, Авлигатай тэмцэх гарын авлага, 2016, 82-р тал

1

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

2

Нийтийн албан тушаалтанд хориглолт, хязгаарлалт тавих

3

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах

4

Хуулийн хэрэгжилтийг хянах, хариуцлага хүлээлгэх

2.3.1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахын тулд хамгийн эхэнд ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байдаг. Үүний тулд ашиг сонирхлын зөрчлийг бүртгэх, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг авах, мөн ашиг сонирхлын зөрчилтэй байдалд орж болзошгүй нийтийн албан тушаалтан уг байдлаас зайлсхийх ёс зүйн үүргийг тодорхойлж, оноох зэрэг арга хэмжээ байдаг.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад байгууллага голлох үүрэгтэй бөгөөд байгууллагын удирдлага манлайлахын зэрэгцээ нийтийн албан тушаалтан өөрөө ч чухал үүргийг хүлээдэг. Иймд урьдчилан сэргийлэх арга хэмжээг ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад удирдлага ба нийтийн албан тушаалтны үүрэг(гуравдугаар бүлэг), Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахад байгууллагын хүлээх үүрэг(дөрөвдүгээр бүлэг), Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг(тавдугаар бүлэг) тус тус авч үзнэ.

2.3.2. Хориглох, хязгаарлах

Ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй нөхцөл байдалд тодорхой үйл ажиллагааг **хориглох, хязгаарлах** нь ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтад чухал байр суурь эзэлнэ. Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлүүдийг тодорхойлон, тийм нөхцөл байдалд хүргэхгүйн тулд нийтийн

албан тушаалтны тодорхой зан үйл, үйлдэл, үйл ажиллагааг хориглож, хязгаарлана гэсэн үг. Ийм аргаар төрийн албан тушаалтнуудад болзошгүй ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлдэг. Албан тушаалтан бүр ямар нэгэн байдлаар зөрчилтэй тулгардаг тул төрийн албан тушаалтны сонор сэрэмж, мэдлэг, зөрчлийг мэдүүлэх үүрэг хариуцлагыг дээшлүүлж, түүнийг шийдвэрлэх замаар ийм нөхцөл байдал гаргуулахгүй байх нь зохицуулалтын гол зорилго юм. Хэдийгээр аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах хориглолт, хязгаарлалт нь урьдчилан сэргийлэх механизмд хамаардаг боловч байгууллагаас гадна нийтийн албан тушаалтанд зориулан хэрэгжүүлдэг тул мөн тусад нь авч үзэж (зургадугаар бүлэг) тайлбарлах нь зөв юм. Энэхүү механизмыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлгийн 10-22 дугаар зүйлд тус бүр тусгасан тодорхой заалтуудаар нарийвчлан зохицуулсан.

2.3.3. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах

Улсын салбар хурдацтай өөрчлөгдөж буй орчинд ашиг сонирхлын зөрчил анхаарлаа хандуулах асуудал юм. Хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд хэт хатуу хандах нь бусад эрхтэй зөрчилдөх, практикт хэрэгжихгүй, эсхүл зарим хүмүүст төрийн алба хашихад шууд саад болж болох юм. Ийм учраас ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах орчин үеийн бодлого нь төрийн байгууллага, албан тушаалтны шударга байдалд эрсдэл учруулах хэлбэрийг хориглох, зөрчлийг зөв зохистой зохицуулах, олон нийтийн байгууллага, хувь хүний албан тушаалтнуудыг тохиолдлын зөрчлийг тогтоох үр дүнтэй журмыг тогтоох, ил болгох, удирдан зохион байгуулах, сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд зохистой шийдвэрлэх гаргахад туслах, дэмжлэг үзүүлэх байдлыг хангадаг.¹⁹

Нийтийн албан тушаалтан нэгэнт ашиг сонирхлын зөрчилд орсон тохиолдолд ашиг сонирхлоо зарлах, хувийн сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргахад оролцохоос татгалзах, албан үүргийг нь зөрчил үүсэхгүй чиг үүрэгт шилжүүлэх, албан хаагчийн ажил үүргийг дахин өөрчлөх тодорхойлох, зөрчил үүсгэх чиг үүргээс чөлөөлөх гэх мэт байдлаар шийдвэрлэнэ.

- Нийтийн албан тушаалтан сонирхлоо зарлах

¹⁹ OECD, Managing Conflict of Interest in the Public Sector, 2005, p 96

Зарим зөрчлүүд зөвхөн бүртгэгдэж, шийдвэр гаргалтад өртөж буй хүмүүст ил болж зарлагдсан байхад л хангалттай байхуйц ялимгүй зүйлс байдаг. Жишээ нь албан тушаалтан нэгэн компанид нийтийн албаны үүрэгт нь зохисгүй нөлөөлөл үзүүлэхээргүй маш бага хэмжээний хувь эзэмшдэг байж болно. Ийм тохиолдолд, бусад оролцогчид албан тушаалтны шийдвэр гаргалтанд оролцохыг эсэргүүцэхгүй байж болно. Хэрэв эсэргүүцвэл, албан тушаалтан цаашид оролцохоос өөрөө татгалзах хэрэгтэй.

- Хувийн сонирхолд нөлөөлөх шийдвэр гаргахад албан тушаалтан оролцохоос татгалзах

Нийтийн албан тушаалтын шашны, мэргэжлийн, нам улс төрийн, үндэс угсааны, гэр бүл болон бусад харилцаа холбоо нь албаны шийдвэр гаргах шударга байдалд нөлөөлөхгүй байх ёстой. Үүнтэй зэрэгцээд нийтийн албан тушаалтан нь хувийн санхүүгийн сонирхол, шийдвэр гаргах шударга байдалд эргэлзээ төрүүлэхүйц харилцаа холбоо таслах, хязгаарлах шаардлагатай. Ингэх боломжгүй бол жишээлбэл, гэр бүл хүүхэдтэйгээ харилцах харьцаагаа ажлаасаа болж таслах нь боломжгүй тул ийм тохиолдолд эдгээр хүмүүсийн хувийн сонирхолд нөлөөлөх шийдвэр гаргалтанд оролцохгүй байх шаардлагатай байдаг.

- Албан үүргийг зөрчил үүсэхгүй чиг үүрэгт шилжүүлэх
- Албан хаагчийн ажил үүргийг дахин өөрчлөн тодорхойлох
- Зөрчил үүсгэх чиг үүргээс чөлөөлөх

Зүүн Австралийн туршлагыг сонирхуулбал:

<p>Public duty versus private interests Хувийн ашиг сонирхлын эсрэг гүйцэтгэх төрийн үүрэг</p>	<p>Надад зөрчилд орж болохуйц, эсхүл миний албан үүрэгтэй зөрчилдөнө гэж ойлгогдохуйц амины буюу хувийн сонирхол бий юу?</p>
<p>Potentialities Боломжит байдлууд</p>	<p>иний бодит байдалд эргэлзээ төрүүлж болохуйц давуу байдал надад одоо эсхүл ирээдүйд бий юу?</p>
<p>Perception Төсөөлөх</p>	<p>Төсөөлөл нь чухал гэдгийг сана. Миний шийдвэр гаргахад, эсхүл үйл ажиллагаан дахь оролцоог бусад оролцогчид юу гэж үзэх бол?</p>
<p>Proportionality Тэнцвэртэй байдал</p>	<p>Шийдвэр гаргахад оролцох миний оролцоо бүх нөхцөл байдалд шударга, үндэслэлтэй байдаг уу?</p>
<p>Presence of mind Ухаалаг байх</p>	<p>Хэрэв сонирхлын зөрчлийг хайхрахгүй бол ямар үр дагаварт хүргэх вэ? Миний оролцоо олон нийтийн дунд эргэлзээ төрүүлбэл яах вэ?</p>
<p>Promises Амлалтууд</p>	<p>Би энэ асуудлаар ямар нэг үүрэг, амлалт авсан уу? Санал болгосон шийдвэр, эсхүл үйл ажиллагаанаасаа би ямар нэг ашиг, эсхүл хохирол амсах уу?</p>

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах ажилтан, зааварлагчийн ашиглах гол хувилбарууд буюу 6 R²⁰

<p>Record/Register Тэмдэглэл хөтлөх/бүртгэх</p>	<p>Сонирхлын зөрчил илрүүлснийг бүртгэж тэмдэглэх нь зөрчлийг шийдвэрлэх албагүй ч гэсэн анхан шатны чухал алхам юм. Нөхцөл байдлыг үнэлж дараахь стратегиудаас нэг, эсхүл хэд хэдийг хэрэглэх шаардлагатай эсэхийг тодорхойлох хэрэгцээ гарч болно.</p>
<p>Restrict Хязгаарлах</p>	<p>Энэ асуудалд оролцох оролцоогоо хязгаарлах, жишээлбэл, тодорхой асуудлаар хэлэлцүүлгэд оролцохгүй байх, шийдвэрлэх санал өгөхгүй байх ба/эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэлтэй ажиллах, олж авахыг хязгаарлана. Хэрэв нөхцөл байдал давтагдах ба ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал их бол өөр хувилбаруудыг авч үзэх хэрэгтэй байж болно.</p>
<p>Recruit Нэмж оролцуулах</p>	<p>Хэрэв оролцоог хязгаарлах боломжгүй бол шийдвэр гаргах үйл явцын шударга байдалд хяналт тавих буюу шалгах зорилгоор хараат бус гурав дахь талыг оролцуулж болно.</p>
<p>Remove Хасах</p>	<p>Тухайн асуудалд оролцуулахгүй байх нь тусгай стратеги, эсхүл түр зуур, эсхүл нэмж хүн оруулах стратеги нь боломжгүй, эсхүл зохимжгүй үед хамгийн сайн хувилбар юм.</p>
<p>Relinquish Татгалзах</p>	<p>Амины буюу хувийн сонирхлоосоо татгалзах нь таны албан үүрэгтэй зөрчилдөхгүй байх баталгааг хангасан хамгийн үр дүнтэй стратеги. Үүнд хувьцаа эзэмшихээс, эсхүл клуб, нийгэмлэгийн гишүүнээс татгалзах зэрэг орно.</p>
<p>Resign Чөлөөлөгдөх</p>	<p>Хэрэв сонирхлын зөрчлийг өөр аргаар шийдэх, ялангуяа зөрчилдөж буй хувийн ашиг сонирхлуудыг арилгах боломжгүй бол огцрох, чөлөөлөгдөх хувилбар байж болно.</p>

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 23-26 дугаар зүйл, 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах арга замуудыг тусгасан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах арга замуудыг тусгасан байна. Үүнд: Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болох зэрэг хамаарна.

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргах бөгөөд зарим тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болохоор зохицуулжээ. Түүнчлэн ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх бөгөөд тэдгээр нь тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн шийдвэр гаргана. Ийм шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцохоор хуульд заасан. Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллага, Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх, мөн албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд хэрхэн зохицуулахыг хуульд тусгасан байна.

2.3.4. Хуулийн хэрэгжилтийг хянах, хариуцлага хүлээлгэх

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэсэн үүргийг биелүүлэх, хориглолт, хязгаалалтыг мөрдөх, хувийн ашиг сонирхлоо мэдүүлэх, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд бичгээр тайлбар хийх зэрэг ашиг сонирхлын зөрчлийг зохицуулсан хэм хэмжээг нийтийн албан тушаалтан зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх нь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах бас нэг механизм юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд ямар байгууллага хяналт тавих болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан. Энэ талаар гарын авлагын 7 дугаар бүлгээс үзнэ үү.

Захиргааны хариуцлага
Шүүгч

- Мөнгөн торгууль ногдуулах
- Албан тушаалаас чөлөөлөх
- Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

Сахилгын шийтгэл
Эрх бүхий албан
тушаалтан

- Сануулах
- Цалинг хуульд заасан тодорхой хувь хэмжээгээр бууруулах
- Албан тушаал бууруулах
- Нийтийн албанаас халах

ГУРАВДУГААР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХАД УДИРДЛАГА БА НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ

3.1 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг зохицуулахад удирдлагын хүлээх үүрэг

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт төрийн байгууллагын удирдлагын энэ чиглэлээр хүлээх үүргийг заасан байна. Тухайлбал, төрийн байгууллагын удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон, мөрдүүлэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдлийг авах, бүртгэх, хянан шалгах, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдэгдлийн дагуу шалгалт хийх, хариуцлага тооцох, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх; ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх, хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн

удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

7.2.Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:

7.2.1.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх;

7.2.2.хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;

7.2.3.ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;

7.2.4.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;

7.2.5.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;

7.2.6.энэ хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.

3.2 | Нийтийн албан тушаалтны үүрэг

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах талаар удирдамж гаргасан байдаг. Энэхүү удирдамжид нийтийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх дараахь үндсэн зарчмуудыг дэвшүүлсэн:



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд албан тушаалтны баримтлах үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон:

Нийтийн албан тушаалтан:	
✓	Хууль дээдлэх зарчимд захирагдана.
✓	Албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэнэ.
✓	Албаны ёс зүйг сахина.
✓	Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.
✓	Албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй.
✓	Албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.
✓	Иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчинэ.
✓	Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.
✓	Ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

Улс орнууд хууль тогтоомждоо дараахь нөхцөлийг тодорхойлж тогтоосон байдаг. Үүнд:

- Ашиг сонирхлын зөрчлийн талаар ойлголттой байж, түүнээс аль болох зайлсхийхийг нийтийн албан тушаалтанд үүрэг болгох
- Нийтийн албан тушаалтан үүссэн ашиг сонирхлын талаар холбогдох дээд албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллага ба олон нийтэд мэдэгдэх үүрэг хүлээлгэх
- Асуудал үүсгэж буй хувийн ашиг сонирхлоос татгалзах, эсхүл зөрчлийн улмаас ноцтой байдалд орж болзошгүй үйл ажиллагаанд оролцохоос нэрээ татах зэргээр зөрчлийг шийдвэрлэх нь нийтийн албан тушаалтны үүрэг
- Шаардлагатай гэж үзвэл хувийн ашиг сонирхлоо тогтмол мэдүүлж байх үүрэг хүлээлгэх(хөрөнгө, орлогын мэдүүлэг).¹

Хуулиар нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг мөрдөж албан үүргээ гүйцэтгэхэд хувийн сонирхол нь сөргөөр нөлөөлөх,

¹ ЕАБХАБ, Авлигатай тэмцэх гарын авлага, 2016, 81-р тал

сонирхлын зөрчил үүсгэж болох эсэхийг сайтар бодож хууль дүрмийг сахих ёстой.

Нэн тэргүүнд **таны** хийх ёстой зүйл бол хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх явдал юм.

*Албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр **ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл** гаргаж байх бөгөөд тэрээр албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд **албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд **бичгээр мэдэгдэх** үүрэгтэй. Түүнчлэн энэ талаар мэдэж байгаа бусад этгээд мөн энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд **мэдээлж** болно.***

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно:

- тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
- тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан тушаалтны гаргасан хуульд заасан тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүргийг мөн хуулиар хүлээж байна.

Нийтийн албаны ёс зүйн дүрэм буюу албан тушаалтан өөрийн мэргэжил, салбар, байгууллагад баталж мөрдүүлсэн ёс зүйн дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж, өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүргийг хүлээлгэсэн байна.

Харин аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд дараахь байдлаар зохицуулсан:

Бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөлийг санал болгосон тохиолдолд:

Саналаас татгалзах

Санал тавьсан этгээдийг тодорхойлох

Эргүүлэн өгөх боломжгүй бэлгийг хадгалах, удирдах албан тушаалтандаа нэн даруй мэдэгдэх

Боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх

Болсон нөхцөл байдлын талаар удирдах албан тушаалтандаа бичгээр хүргүүлэх

Хариуцлага хүлээхээр зөрчил бол эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх

Сонирхлын зөрчлийг зохицуулах хууль, дүрмийн зохицуулалт нь албан арга юм. Нийтийн албан дахь ашиг сонирхлын зөрчлийг бүтцээр нь хувь хүний

дотоод зөрчилд хамааруулж болно. Нийтийн албан тушаалтан та өөрийн дотоод зөрчлийн асуудлыг албан бус аргаар эерэгээр зөв шийдэж сурах хэрэгтэй.

Тест:

Би ашиг сонирхлын зөрчилд орохоор байна уу?

Хэрвээ Та ашиг сонирхлын зөрчилд орж магадгүй гэж үзэж байгаа бол дараахь асуултуудыг өөртөө тавьж, хариултуудаар зохицуулахыг оролдоно уу:

- ⇒ Байгууллага болон миний гэр бүлийн гишүүдээс өөр хэн нэгэн намайг ашиг сонирхлын зөрчилтэй гэж бодож болох уу?
- ⇒ Хэрэв бусад хүн үүнийг хийвэл би юу гэж бодох вэ? Намайг хардах зүйл байна уу?
- ⇒ Миний үйлдлийн талаар сонины нүүр хуудсан дээр бичигдвэл би яаж хүлээж авах вэ?
- ⇒ Хэнд хохиролтой, эсхүл энэ нь хэнд ашигтай вэ?
- ⇒ Хүмүүс намайг шударга бус гэж бодох уу, эсхүл байгууллагыг шударга бус гэж үзэх үү?
- ⇒ Би энэ талаар илүү сайн мэддэг хэн нэгнээс асуух шаардлагатай юу?²

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХАД БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд байгууллагын хүлээх үүрэг

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийг зааж, ашиг сонирхлын зөрчлийг хэрхэн мэдэгдэх, тайлбарлах, албан үүргээ шударгаар гүйцэтгэхэд нөлөөлөх гэсэн нөхцөл байдлыг мэдэгдэх, албан тушаалтны албан үүрэгтэй нь холбогдуулан бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд авах арга хэмжээг хуульчилсан болно. Тухайлбал, хуульд заасны дагуу **төрийн байгууллага хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгахад болон ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.**

Төрийн байгууллагууд сонирхлын зөрчлийг зохицуулах, асуудалд тэнцвэртэй хандах, учрах эрсдлийг таних, шаардлагатай хориглолтыг хийх, сонирхлын зөрчлийн тохиолдлуудыг зүй зохистойгоор зохицуулах, ажилтнууддаа сургалт, сурталчилгаа явуулах шаардлагатай.

- Байгууллагууд ажлын орчиндоо ашиг сонирхлын зөрчлийг хянан зохицуулах зохицуулалтын бодлого, журам, арга замыг бий болгож хэрэгжүүлэх
- Ажлын байран дээрх сонирхлын зөрчлийн талаар нээлттэй харилцах, харилцан ярилцах байгууллагын соёлыг бий болгох, дэмжих, хөгжүүлэх
- Байгууллагын зохицуулалтын дүрэм журам нь албан тушаалтнуудын сонирхлын зөрчилтэй байдлыг илрүүлэх, хэлэлцэхийг нь дэмжиж илчлэгдсэн мэдээллийг алдагдах, бусдад буруугаар ашиглагдахаас сэргийлэх зөв зохистой арга хэмжээг багтаах,
- Төрийн байгууллагууд нь хөгжлийн динамикийг ойлгож, төрийн байгууллагын тогтоосон дүрэм журмын практик хэрэглээг сайжруулахад чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий удирдамжаар хангах ёстой.

4.2 | Яагаад байгууллагын соёл чухал вэ?

Төрийн байгууллагууд нь ашиг сонирхлын зөрчлийг байгууллагынхаа хүрээнд байгууллагынхаа соёлоор дамжуулан зохицуулах нь төрийн үйлчилгээг ард иргэдэд хүндрэл төвөггүй хүргэх, албан хаагчдаа аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх, цаашилбал нийтийн албаны нэр хүндийг өргөж иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж болно. ЭЗХАХБ-ын өгсөн удирдамжид сонирхлын зөрчлийг зохицуулахад мөрдөх дөрвөн үндсэн зарчмын нэг нь сонирхлын зөрчлийг үл тэвчих байгууллагын соёлыг бий болгох явдал гэж тусгасан байгаа.

Авлигад автах хандлага нь хүмүүсийн оюун ухаанд маш гүн суусан байдаг бөгөөд түүнийг устгахад зөвхөн албан төдийгүй, албан бус аргууд шаардлагатай байдаг. Учир нь авлигын зан үйл нь хүний хамгийн үнэт зүйлсийн чиг баримжаа гүн гүнзгий өөрчлөгдсөнтэй холбоотой байдаг. Ашиг сонирхлын зөрчил авлига бий болох үндэс, суурь шалтгаан болдог учраас ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх нэн чухал арга хэмжээ юм. Энэхүү бүлэгт ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд

байгууллагын соёлын үр нөлөө болон байгууллагын соёлоор дамжуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх боломжийг харуулсан гадаадын улс орнуудын туршлагатай танилцана. Үүний тулд эхлээд соёл, байгууллагын соёл гэж юу болохыг авч үзье.

Байгууллагууд сонирхлын зөрчлийг зохицуулах соёлоо шударгаар нээлттэй хөгжүүлж сонирхлын зөрчлөөс аль болох зайлсхийх, сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлыг зохицуулахад гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хэдийгээр байгууллагын бодлого нь хэн түүнийг хэрэгжүүлэх, хэн хяналтыг хариуцах ёстой, хэн нь болзошгүй зөрчлийн тохиолдолд үйл ажиллагаа явуулах үүрэгтэйг нарийвчлан заан өгөх нь чухал ч сонирхлын зөрчлийг зохицуулах нь зөвхөн менежерүүд болон удирдах ажилтнуудын л асуудал биш юм. Байгууллагын бүх ажилтнууд ёс зүйн дүрмийг сахих, сахиулах үүрэг хүлээсэн байх ёстой. Өөрийгөө сонирхлын зөрчилд байна гэж, эсхүл өөр хэн нэгнийг болзошгүй зөрчилд байна гэж үзэж байгаа бол уг асуудлыг гаргаж тавих ёс зүйн үүрэг хариуцлагатай байх хэрэгтэй. Сонирхлын зөрчлийн нөхцөл байдал нь амьдралын нэг хэсэг, заавал шийдвэрлэх асуудал бөгөөд байгууллагын соёл нь бүх албан тушаалтан байгууллагын ёс зүйн зан үйл, шийдвэр гаргалтад хариуцлага хүлээх чадварыг дээшлүүлэхэд тусална. Хүмүүс сонирхлын зөрчлийг “өөрөө мэдүүлдэг” соёлыг байгууллагад бий болгох нь нэн чухал.

4.3 | Байгууллагын соёл гэж юу вэ?

Соёл бол ойлгоход бэрх ухагдахуун бөгөөд түүнийг аль хүртэл удирдан зохицуулж болох нь маргаантай асуудал. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд хэрхэн ажилладаг талаар ойлголттой болохын тулд бид соёлыг нь ойлгох хэрэгтэй. Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын амжилттай байх, бүтэлгүйтэх аль нь болохыг шийддэг маш чухал зүйл юм. Хэдийгээр энэ нэр томъёо нь өргөн хэрэглэгддэг боловч ойлгоход амаргүй хийсвэр ойлголт. Өнгөрсөн хэдэн арван жилийн туршид олон эрдэмтэн, судлаач соёлыг хүмүүсийн харьцаа, эсхүл дэвшүүлж буй үнэт зүйлс, байгууллагын итгэл үнэмшлийн илэрхийлэлд тулгуурласан байгууллагын уур амьсгал, практик юм гэж үзэж ирсэн.¹ Байгууллагын соёл гэдэг нь байгууллагад ажиллах арга замд нөлөөлдөг бөгөөд үнэт зүйлсээр илэрхийлэгдсэн үндсэн

¹ Schein E.H. Organizational Culture and Leadership, Jossey-Bass, 3rd edition, 2004

төсөөллүүдийн багц юм. Байгууллагын соёл нь тухайн байгууллагын бусдаас ялгарах онцлог, байгууллага доторх гишүүдийн янз бүрийн үзэл бодол, үнэт зүйлс, туршлагыг нэгтгэж байдаг. Энэ нь байгууллага бий болохтой хамт үүснэ.² Соёлыг гадаад орчноо дотоод үйл ажиллагаатайгаа тохируулахын тулд тухайн бүлгийн нээсэн, илрүүлсэн, боловсруулсан багц үндсэн төсөөлөл гэж тодорхойлсон байдаг. Тиймээс эрх мэдлийн зааг шугам, үйл ажиллагааны горим, ажил үүргүүд нь маш тодорхой, шатлан захирах ёс бүхий байгууллага гадны тогтвортой орчинд илүү тохирсон байж болно. Харин ийм дотоод үйл явц, зохион байгуулалт нь маш хурдан шийдвэр гаргах шаардлагатай, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй орчинд тохирохгүй байх магадлалтай. Өнөөгийн байгууллагын соёл нь тухайн байгууллагын гишүүд орчиндоо хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг тодорхойлдог.

Нэлээд олон судлаачид байгууллагын соёлыг авлигал, ёс зүйгүй зан үйлийг дэмжих гол хувьсагч гэж үзсэн байдаг нь сонирхолтой.³ Хэдийгээр ном хэвлэлүүд авлигыг тайлбарлахад байгууллагын соёлыг холбох хандлагатай байдаг ч ажилтнуудын авлигад автахыг нэмэгдүүлдэг байгууллагын соёл гэж юу болох талаар мэдэгдэж байгаа зүйл ховор байна. Нөгөө талаас зарим судлаачид байгууллагын соёлыг авлигын эсрэг үр нөлөөтэй зүйл гэж үзсэн байна.⁴ Эцэст нь, хэд хэдэн судалгааны үр дүнд хийсэн шинжилгээ байгууллагын ёс зүйн соёл нь ёс зүйгүй зан үйл, авлигыг бууруулдаг болохыг харуулжээ.⁵

Schein E.H. “Манлайлагчдын хийх ёстой хамгийн бодит чухал зүйл нь соёлыг бий болгох, түүнийгээ удирдан зохицуулах явдал юм; манлайлагчдын өвөрмөц авьяас билэг нь соёлтой танилцаж, түүнтэй ажиллах чадвартай байх явдал; мөн үйл ажиллагааны хувьд доголдож байна гэж үзсэн үед тэрхүү

2 Schein, (1990) 'Organizational Culture', *American Psychologist* 45 (2): 109–19

3 Marlen Jamie-Lee Campbell, doctoral dissertation “Organizational cultures’ impact on employees’ corruption”, p.58

4 Ashforth, B. E., Gioia, D. A., Robinson, S. L., & Trevico, L. K. (2008) Introduction to special topic forum: Re-viewing organizational corruption. *Academy of Management Review*, 33(3), 670-684.

5 Kish-Gephart, J. J., Harrison, D. A., & Trevico, L. K. (2010). Bad apples, bad cases, and bad barrels: Meta-analytic evidence about sources of unethical decisions at work. *Journal of Applied Psychology*, 95(1), 1-31;

O’Fallon, M. J., & Butterfield, K. D. (2005). A review of the empirical ethical decision making literature: 1996-2003. *Journal of Business Ethics*, 59(4), 375-413; Trevico, L. K., den Nieuwenboer, N. A., & Kish-Gephart, J. J. (2014). (Un)ethical behavior in organizations. *Annual Review of Psychology*, 65(1), 635-660; Craft, J. L. (2013). A review of the empirical ethical decision-making literature: 2004-2011. *Journal of Business Ethics*, 117(2), 221-259;

Trevico, L. K., Butterfield, K. D., & McCabe, D. L. (2001). The ethical context in organizations: Influences on employee attitudes and behaviors. *Business Ethics Quarterly*, 8(3), 301-337.

соёлыг устгах нь манлайллын эцсийн үйлдэл юм” гэжээ.⁶ Тиймээс соёл нь байгууллагад өөрийгөө таних мэдрэмжийг өгч, түүнийг домог, зан үйл, итгэл үнэмшил, утга учир, үнэт зүйлс, хэм хэмжээ, хэл яриа зэргээр нь дамжуулан тодорхойлно. Байгууллагын соёл өнгөрсөн хугацаанд юу болж байсныг, юу сайн болсныг өөртөө туршлага болгож авдаг. Эдгээр туршлагыг байгууллагад удсан ажилтнууд ямар ч эргэлзээгүйгээр хүлээн авах нь түгээмэл байдаг. Байгууллагын дотор болсон явдлын талаарх зарим яриа байгууллагад байсаар байх ба сүүлдээ аливааг хийх тогтсон арга замын нэг хэсэг болдог. Цаг хугацаа өнгөрсний дараа байгууллага “хэм хэмжээ”-г өөрөөр хэлбэл, байгууллага дахь зан үйлийн хүсэн хүлээсэн загварыг бий болгодог. Хэм хэмжээг зан үйлийн тогтсон загвар бөгөөд соёлын нэг хэсэг гэж тодорхойлж болно. Schein “соёл нь бидэнд нөлөөллөөрөө маш хүчтэй боловч нүдэнд ил харагдахгүй, тодорхой хэмжээгээр ухамсартайгаар биш харин санаандгүй явагдаж буй аливаа үзэгдлийг зааж өгдөг” гэжээ.⁷ Өөрөөр хэлбэл, Schein байгууллагын соёл нь харагдах болон үл харагдах түвшинтэй байдгийг онцолсон. Энэ нь мөсөн уултай төстэй юм: ил харагдах хэсэг нь соёлын харагдах хэсэг бол усан доорх хэсэг нь үл харагдах хэсэг нь юм. Харагдах хэсэг буюу өнгөн илрэлд нь бэлэг тэмдэг, ёслолын үйл ажиллагаа, түүхэн яриа, уриа, хувцас, материаллаг байдал зэрэг нь орно. Харин үл харагдах хэсэгт үндсэн үнэт зүйлс, таамаг төсөөлөл, итгэл үнэмшил, хандлага, мэдрэмж зэрэг нь орно. Дийл, Кеннеди нар (1982) соёлын харагдах хэсгийг зан үйлийг бий болгон хэлбэржүүлдэг гол зүйлс гэж итгэж ихээхэн ач холбогдол өгсөн. Гэвч чухам соёлын үл харагдах хэсэг нь улсын салбарын байгууллагуудын өөрчлөлтийг түргэтгэх, эсхүл саад хийхэд илүү нөлөөтэй юм.

Байгууллагын соёл нь олон түвшинт үзэгдэл болох талаар төрөл бүрийн загвар байдгаас 1980 онд Schein-ийн боловсруулсан “сонгино” загварыг энд авч үзье. Түүнийхээр соёл нь гурван түвшинтэй байдаг. Үүнд хувь хүн шинэ соёлд нэвтрэхэд ажиглагдаж, мэдрэгдэж, сонсогдох боломжтой, хялбархан дүрслэгдэх **артефакт** гэж байна. Артефакт нь байгууллагын лого, байшин барилга, бүтэц, үйл явц, хувцас гэх мэт зүйлс юм. Жишээлбэл, 2017 онд Энэтхэг улсын Калькутта хотод нэгэн их сургуульд олон улсын хуралд оролцох үедээ нэг багш хэд хэдэн зүйлийг ажигласан нь артефактийн амьд жишээнүүд байсан гэж ярьж байв: зөвхөн захирлын зорчих цахилгаан шат,

6 Schein E.H. Organizational Culture and Leadership, Jossey-Bass, 3rd edition, 2004, p.10

7 Мөн тэнд, 8-р тал

зөвхөн зочинд зориулсан ариун цэврийн өрөөтэй төдийгүй үдийн хоолон дээр шөлөө эхлээд зөвхөн захиралдаа аягалдаг нь эрх мэдэл ба магадгүй тэгш бус байдлыг харуулж байна. Гэвч артефактыг өөрчлөхөд тийм ч хэцүү биш байдаг. Харин загварын гадна талаас дотогшлох тусам өөрчлөхөд улам хэцүү болдог.



Бүдүүвч 4. Байгууллагын соёлын түвшингүүд

Байгууллагын соёлын энэхүү артефактаас гадна **тунхагласан соёл** гэж байх ба энэ нь байгууллагын баримтлахаар тунхагласан зорилго, төгс загвар, хэм хэмжээ, стандарт, ёс суртахууны зарчмууд юм. Эдгээр нь нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшлээс үүдэлтэй ажилтнуудын мэргэжлийн болон хувийн зан үйлтэй холбоотой бөгөөд байгууллагын удирдлагууд, үндэслэгчид тэдгээрийг дэвшүүлдэг.

Байгууллагын соёлын хамгийн гүнзгий түвшин бол үндсэн төсөөлөл юм. Ажилтнууд ухаж ойлгохгүй байж болох ч маргаангүй ийм л байх ёстой гэж үздэг. Жишээ нь, гадны хүмүүс тэднээс байгууллагынх нь соёлын талаар асуухад ихэвчлэн тайлбарлаж чаддаггүй: "бид энд ингэж л хийдэг" гэж хариулдаг. Өөрөөр хэлбэл, эдгээрийг ийм л байх ёстой гэж үздэг ба тайлбарлаж чаддаггүй. Үндсэн төсөөллүүд нь хувь хүний зан үйл, удирдлагын шийдвэр гаргалт, сонголтод цаашилбал байгууллагын амжилттай байхад маш сайнаар нөлөөлдөг. Үндсэн төсөөллийг өөр орчинд хэрэглэх зорилгоор ямар нэг аргаар дууриалган бий болгох нь тун амаргүй. Өөрчлөх нь мөн хэцүү юм. Ажилтнуудын ухамсарт маш гүн суусан байх тул тэднээс салгах

боломжгүй ба ийм байгууллагууд маш гайхамшигтай, дахин давтагдашгүй, ямар ч салбарт өрсөлдөх чадвар өндөртэй байна. Энэ нь ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх асуудалд ч адил хамаатай юм. Авлигын эсрэг баттай зогсож амжилтад хүрэхийн тулд энэ түвшинд ашиг сонирхлын зөрчил, авлигын эсрэг зан үйлийн зарчмуудыг хэвшүүлэх нь маш чухал байдаг. Манай улсын байгууллагуудад бүх ажилтнууд нь “манай энд үргэлж зөвхөн нийтийн ашиг сонирхлыг өмнөө тавьдаг, үргэлж хүнд сурталгүй шуурхай үйлчилдэг, хэзээ ч, хэн ч авлига, хээл хахууль авдаггүй. Үргэлж ийм л байсан. Бид ингэж л ажилладаг. Өөрөөр байж болно гэж үү” гэсэн үндсэн төсөөллийг бий болгох хэрэгтэй. Тэгэхээр энд манлайлал, үлгэрлэх явдал чухал үүрэгтэй. Мөн зөв хандлага, болж өнгөрсөн муу зүйлийг их ярихаасаа илүү сайн жишээг сурталчлан таниулж урамшуулж домог болгож байх нь чухал юм.

Соёл нь цаг хугацаа, орон зайгаар, янз бүрийн механизмаар дамждаг. Урьдаас төлөвлөсөн механизмууд нь ажилд авах, дэмжих үйл явц, сургалт, байгууллагын ёс зүйн дүрэм, үнэт зүйлсийн баримтлал зэргээр дамжин ажиллана. Албан бус үйл явц нь ажилтнуудын нэг үеэс дараагийн үед бүлгийн зан үйлийн стандарт, ажлын албан ёсны арга замаас өөр дадал туршлага, домог яриа, түүхээр дамжин явагдана.

Соёлын өөрчлөлтийг хийх нь амаргүй. Үүний тулд хандлага, итгэл үнэмшил, үнэт зүйлсийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Эдгээр нь хувь хүний хувьд чухал ач холбогдолтой, хүнийг хувь хүнийх нь хувьд тодорхойлдог зүйлс. Тиймээс байгууллагын соёлыг хувь хүний үнэт зүйлсээс бүтдэг гэж үздэг. Соёл нь байгууллагын эзэмшдэг ямар нэг амьгүй зүйл биш, харин алгуур хувьсан өөрчлөгддөг амьд зүйл юм. Тиймээс соёлыг удирдан зохицуулах тухай ойлголт нь нэлээд бэрхшээлтэй байдаг.⁸

8 Alan Lawton, Julie Rayner and Karin Lasthuizen, *Ethics and Management in the Public Sector*, 2013, p.74

Жишээ 4. Enron-ы хэрэг

“Enron-ы хэрэг” нэртэй хэргийн улмаас болсон Enron компанийн дампуурал нь дэлхийн түүхэн дэх хамгийн дуулиант дампуурлуудын нэг болсон юм. 40 улсад 21 мянга гаруй ажилтантай энэхүү компани нь хөрөнгө оруулагчдаа хуурамч мэдээллээр төөрөгдүүлж байсан юм. Санхүүгийн болон оффшорын олон төрлийн схемүүдийг ашиглаж байсан нь илэрсэн. Хэрэг ид мандаж байх үед Дэд Ерөнхийлөгч Клиффорд Бакстер амиа хорложээ. Хууран мэхлэх ажиллагаа явуулахын тулд олон тооны хуулийн этгээдийг гол төлөв оффшор бүсэд байгуулж байрлуулсан байдаг. Кейман арлууд дээр 692 охин компани бүртгүүлсэн байна. Enron-ы мэхлэлт нь орлого нуух бус харин алдагдлыг нуун дарагдуулсан [5]. Enron нь Артур Андерсен компанийн аудитын мэргэжилтнүүдийн тайланг хуурамчаар үйлдэхэд оролцож эерэг дүгнэлт гаргуулж байжээ.

Хямралын шалтгаан, компанийн сүйрлийн гол шалтгаан нь гадаад, дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоогүй байсан, түүнчлэн корпорацийн нягтлан бодох бүртгэлийн тооцоо ашигтай гарвал хувь бодож ашиг урамшуулал авдаг байсан ахлах менежерүүдийн хувийн ашиг сонирхол болон компанийн ашиг сонирхлын хоорондын зөрчил юм. Энэхүү ашиг сонирхлын зөрчил нь компанийн алдагдлыг нуун дарагдуулж, орлогыг нэмэгдүүлэхэд хүргэдэг байв. Компанийн дампуурлын хохирогчид нь компанийн үнэт цаас эзэмшигчид болон компанийн ажилчид юм. Их Британид ашиг сонирхлын зөрчлийг ёс зүйн асуудал гэж үзэх хандлагатай. Орлого, өмч хөрөнгөө мэдүүлэхийг шаардсан ерөнхий шаардлага байхгүй. Үзэл санаа нь өндөр албан тушаалд очиж байгаа хувь этгээд өөрөө санхүүгийн болон бусад ашиг сонирхлоо мэдүүлэх ёстой гэж үздэг.

Аливаа салбар нь эзэмшсэн мэдлэг, туршлагыг хуримтлуулж байдаг бөгөөд эцэст нь философийн хэлбэр авдаг. Ихэнх тохиолдолд салбарын философи нь удаан хугацааны туршид хуримтлуулсан туршлага, хуримтлалаас илүү сүртэй зүйл биш байдаг.⁹

Ийм “удаан хугацааны хуримтлал” нь соёлыг хатуу хөшүүн болгож болзошгүй тул байгууллага хурдан өөрчлөгдөж буй орчинд нийцэж чадахгүй, эсхүл ёс зүйгүй үйлдлүүд нь байгууллагын бүтцэд нэвтэрч, өршөөгдөх болно.

9 Bridges, E. Sir (1950) Portrait of a Profession. Cambridge: Cambridge University Press. p.16

Ёс зүйгүй зан үйлийг шагнан урамшуулж ч байж мэднэ. Enron-ы хэргийг дараахь шигтгээнээс уншиж ярилцаарай.

Ёс зүйн соёлыг хөгжүүлэх олон тооны жор байдаг бөгөөд үүнд:

- байгууллагын дээд түвшинд ёс зүйн “манлайлагч”-ийг олох, эсхүл дээгүүр түвшинд байдаг хүмүүсээс дэмжлэг авах
 - үл гүйцэлдэх бус, бодитой зорилго, үнэт зүйлсээ тодорхойлох
 - нээлттэй харилцах, ил тод байх
 - үнэт зүйлсийг тогтоох, ёс зүйн хэм хэмжээг боловсруулахад үед хувь хүмүүст зөвлөлдөх боломжийг олгох
 - бүх албан хаагчдыг бүрэн итгэлтэй, үнэ цэнэтэй, дээд нөөц чадавхдаа хүрэх боломжтой хувь хүмүүс гэж хандах хэрэгтэй
 - олон янз байдал, санал зөрөлдөөн, өөр өөр үзэл бодлыг ойлгож дэмжих
 - ёс зүйн соёлыг хөгжүүлэх, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх, тухайлбал, шүгэл үлээх журмыг нэвтрүүлэх
 - бүх ажилтнуудад зориулсан ёс зүйн сургалтыг нэвтрүүлэх
 - ёс зүйн шийдвэр гаргах үйл явцыг гүйцэтгэлийг үнэлэх үйл явцтай нэгтгэх.
- Ихэнх байгууллагууд ёс зүйгүй зан үйлийг хурдан шүүдэг боловч харин ёс зүйтэй зан үйлийг ховорхон урамшуулдаг.

Соёлыг ерөнхийд нь шинжилдэг нэг арга нь таксономийг ашиглах бөгөөд ингэж хүнд суртал, зах зээл болон овог, бүлгийн соёлын хоорондох ялгааг олж болно.¹⁰ Хүнд суртлын соёлыг ихэвчлэн тогтвортой орчинд үйл ажиллагаа явуулдаг, хариуцлагатай байдал, хариуцлага хүлээх шатлан захирах ёсны тогтолцоотой, үйл явцад төвлөрдөг томоохон байгууллагуудад харж болно.

Зах зээлийн соёл нь гадаад өрсөлдөөнт орчинд хөтлөгддөг ба гол төлөв тогтворгүй гадаад орчинд уян хатан, мэдрэмтгий үр дүнд төвлөрдөг.

Бүлгийн соёл нь урт түүхтэй, тогтвортой гишүүнчлэлтэй, мэдлэг, үнэт зүйлс нь нэг үеэс дараагийн үедээ дамжиж байдаг. Гишүүд хоорондоо байнгын харилцаа холбоотой, урт хугацааны туршид зорилгоороо нэгдэх ба энэ нь нарийн төвөгтэй болон тодорхойгүй байдлын үед сайн хэрэгждэг.

Олон байгууллага дээрх гурван төрлийн соёлын аль алиныг нь харуулдаг. Хүснэгтэд соёлын эдгээр төрлүүдийн гол ялгааг харуулав. Энэхүү соёлууд

10 Ouchi, W. (1981) Theory Z. Reading, MA: Addison-Wesley.

нэг нь нөгөөгөөсөө илүү давуу талтай биш; харин өөр өөр соёлууд нь үйл ажиллагааны харилцан адилгүй орчинд тохирдог.

Байгууллагын онцлог ба соёл

	Хүнд суртал	Зах зээл	Бүлэг
Эрх мэдлийн тогтолцоо	Албан тушаалд төвлөрсөн, албан тушаалын зэрэг дэвээр шатлан захирах ёс	Хүн төвтэй, мэргэшсэн байх	Хүн төвтэй, үнэнч тууштай байдал, оролцоо
Гол зорилго	Бэлтгэл, стандартчилалт, мэргэшүүлэх	Шинэ санаачилга	Мэдлэг төвтэй
Чиг баримжаа	Дүрэм журмаар баримжаалдаг	Үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд хөтлөгддөг	Харилцаанд чиглэсэн
Шагналын систем	Байр суурь ба албан тушаалын зэрэг дэв	Нэмүү өртөг ба зорилтод нийцсэн	Хамтран ажиллагсдаа хүлээн зөвшөөрөх
Мэдээлэл солилцох систем	Албан ёсны бүтэц, газар нутгийн бүсчлэл, төвлөрсөн	Зах зээлийн мэдээлэл, өрсөлдөөн	Нээлттэй мэдээлэл, уялдаа холбоо ба мэргэжил нэгтний хамтын ажиллагаа
Шийдвэр гаргах	Шатлан захирах ёс ба дүрэм журам	Зөвшилцөл ба тохиролцоо	Хамтран ажиллагсадын өмнө хүлээх үүрэг
Өрсөлдөөн	Чадварт суурилсан мэргэжлийн	Харилцан хамааралтай, мэргэжлийн үнэлгээн дэх эргэлзээ	Мэргэжлийн үнэлгээ
Үйл ажиллагааны саатал	Дүрэм журам зөрчигдөх, эсхүл дүрэм журмаар халхавч хийх	Иргэдээс илүү харилцагч төвтэй	“Аахар шаахар ажлууд”

ТАВДУГААР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН МЭДҮҮЛЭГ

5.1 | Хувийн ашиг сонирхлын ба хөрөнгө, орлогын мэдүүлэг

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дөрөвдүгээр бүлгээр Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах харилцааг зохицуулж, албан тушаалтан хувийн сонирхлын мэдүүлгийг хэрхэн гаргах, урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэрхэн, хадгалах, мэдүүлгийг нээлттэй байлгах, хянан шалгах асуудлыг тусгасан бол Авлигын эсрэг хуулийн гуравдугаар бүлэгт Хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах талаар нарийвчлан зохицуулсан болно.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.7, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.8-д тус тус заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 2012 оны 5 дугаар тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг(ХАСХОМ)-ээ хуульд заасан хугацаанд, батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан байгууллага, албан тушаалтанд биечлэн болон журамд заасны дагуу хүргүүлнэ.

Ашиг сонирхлын зөрчлийг удирдах ба хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргуулах зохицуулалт хоорондоо нягт холбоотой. НҮБАЭК-ийн 8 дугаар зүйлийн 8(5) дахь хэсэгт “Оролцогч улс орон бүр ...төрийн албан тушаалтан нь төрийн албан тушаалтны хувьд гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбогдуулан сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлогын талаар эрх бүхий холбогдох байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог бий болгохыг чармайна”¹ хэмээн тодорхой заасан байдаг.

Төрийн албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлж, мэдээлэхэд юу шаардлагатайг мэддэг байх нь чухал. Энэ ч үүднээс албан тушаалтнаар мэдүүлэг гаргуулж, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах дэлгэрэнгүй заавар чиглэл өгөхөөс энэ үйл явц эхэлнэ. Албан тушаалтан албан тушаалаа үргэлжлүүлэн хашиж, чөлөөлөгдөх хүртэл мэдүүлэг гаргаж өгнө.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан ХАСХОМ-ээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй.

Мөн мэдүүлгээ бүртгүүлсний дараа түүний хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт² орсон бол энэ тухайгаа Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор мэдэгдэж бүртгүүлэх үүрэг хүлээдэг.

1 Мөн НҮБАЭК-ийн 7 дугаар зүйлийн 7 (4) дэх хэсэгт “Оролцогч улс дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн ил тод байдлыг дэмжих бөгөөд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, бэхжүүлэхийг чармайна” гэжээ.

2 Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн тайлбар: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хөрөнгө, орлогыг хэлдэг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24.1.1, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д тус тус заасны дагуу дараахь албан тушаалтан ХАСХОМ-ээ Авлигатай тэмцэх газарт гаргаж өгнө:

- 2.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;
- 2.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
- 2.1.3.Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;
- 2.1.4.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
- 2.1.5.Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч;
- 2.1.6.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 2.1.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- 2.1.8.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- 2.1.9.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- 2.1.10.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.1.11.Үндэсний статистикийн хорооны дарга;
- 2.1.12.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;
- 2.1.13.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
- 2.1.14.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.1.15.Ерөнхий аудитор, түүний орлогч;
- 2.1.16.Яамны төрийн нарийн бичгийн дарга;
- 2.1.17.Засгийн газрын агентлагийн дарга;
- 2.1.18.Чөлөөт бүсийн захирагч;
- 2.1.19.Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч;
- 2.1.20.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал;
- 2.1.21.Засгийн газар, Ерөнхий сайдаас томилогддог бусад албан тушаалтан.

Дээр дурдсан журмын дагуу доор дурдсан албан тушаалтан мэдүүлгээ дараах байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд;
- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд;

- .аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, ажлын албаны ажилтан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний орлогч, баг, хорооны Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд;
- аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалтан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт; төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал, эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
- төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;
- Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;
- орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн захирал тухайн шатны Засаг даргын Тамгын газарт;
- Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;
- эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;

- яам, агентлагын дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар нэгжийн удирдах албан тушаалтан харьяа байгууллагын түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
- Засгийн газрын тогтоолын дагуу гэрээ байгуулж төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт;
- төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /ерөнхий менежерт/;
- төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, бие төлөөлөгч Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан Улсын Их Хурлын Тамгын газарт;
- Улсын Их Хурлын гишүүнээс бусад улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, ажилтан тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд.

Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус тус бүртгэж Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон сонгогдогчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг архивын нэгж болгон тухайн сонгууль дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

Албан тушаалтны мэдүүлэг, мэдүүлгийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр явуулж болно. Мэдүүлгийг цахим хэлбэрээр бүртгэхтэй холбогдсон журмыг Авлигатай тэмцэх газрын дарга Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран батлан мөрдүүлж байна.

Үүний дагуу Мэдүүлэг гаргагч албан тушаалтнууд ХАСХОМ гаргахдаа цаасаар хэвлэн, баталгаажуулдаг байсныг өөрчлөн, зөвхөн "Баталгааны

маягт”-ыг гарган, мэдүүлгээ баталгаажуулдаг болсон. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Баталгааны маягт”-аар баталгаажуулж бүртгүүлж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 2017 онд 39742, 2018 онд 40073 албан тушаалтан ХАСХОМ-ээ гаргаж бүртгүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газар 2016 оноос албан тушаалтны мэдүүлэг хянах үйл ажиллагааг бүрэн цахимжуулахаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн цахим системийг шинэчилж, шинэ техник, технологийг нэвтрүүлж байна. Ингэснээр ХАСХОМ-ийг дан ганц бүртгэж, хүлээн авах биш судалгаа, дүн шинжилгээ хийх, мэдээ, тайланг цаг алдалгүй гаргах, ХАСХОМ-ийн хяналт шалгалтын үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, харьцуулах, судалгаа хийх ажлыг үр дүнтэй болгоход нөлөөлнө.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 7 дугаар хэсэргэлтэн "А"

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягт

Дугаар..... он сар өдөр

_____/Баяууллавын нэр/ _____/Овог, нэр/

_____/Салбар, нэгжийн нэр/ _____/регистрайн дугаар/

_____/Албан тушаал/ _____/албан тушаалд томилогдсон өгөөж, шийдвэрийн дугаар/

<https://meduuleg.iaac.mn/> цахим системд бүртгээгдсэн шигээн хаяг

ХАСХОМ-ийг мэдүүлэх болсон үндэслэлийг сонгож тэмдэглэнэ үү.

- Томилгогдсон, сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор гаргасан
- Шинэчлэн гаргасан тайлант он
- Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт

ХАСХОМ-ийг мэдүүлэх эрхийг цахим системд үүсгэсэн өгөөж:

ХАСХОМ-ийн баталгааны хуудсыг хүлээн авч,
Цахим системд баталгаажуулсан өгөөж:

..... овогтой миний бие Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь хэсэгт заасны дагуу хуудас бүхий ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх газрын (<https://meduuleg.iaac.mn>) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлсэнээ баталж байна.

ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой үүргээ эрчүүл хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан,
Мэдүүлэг гаргагч:

_____/Овог, нэр/ _____/Гарын үсэг/

Баталгааны хуудсыг хүлээж авсан,
Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан:

_____/Албан тушаал/ _____/Гарын үсэг/

_____/Овог, нэр/ _____/Гарын үсэг/

ХАСХОМ-ийг шалгах ажлыг өргөдөл, гомдол мэдээллийн дагуу, эсхүл төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд явуулна. Жилд дунджаар 500-600 мэдээлэлд нарийвчилсан хяналт шалгалт хийдэг.³

АТГ-аас төрийн өндөр албан тушаалтнуудын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн 14.1-т зааснаар цахим сайтдаа болон “Төрийн мэдээлэл” сэтгүүлд жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан нийтэлж хэвшсэн. 2018 оны 1 дүгээр улирлаас эхлэн ХОМ гаргадаг нийт албан тушаалтны мэдүүлгийг

3 <https://iaac.mn/news/tstsetsegdelgerekh-khom-gargagchdiin-medeelliig-khuraangui-bair-shuulj-baigaag-khardakh-shaardlagagi>

цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, олон нийтэд мэдээллээр ханган, уг ажлыг тогтмолжуулсан байна.

5.2 | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

Дасгал 1.

Барилга хот, байгуулалтын асуудал хариуцсан Сайдаар томилогдохоор нэр дэвшсэн “А”-ийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраас хянан үзээд тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлсэн байна. Учир нь нэр дэвшигч “А” нь барилгын салбарт нэр томоохон барилга угсралтын компанийг 100 эзэмшдэг бөгөөд сайдаар нэр дэвших үедээ уг компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулсны дараа тухайн албан тушаалд томилох үүрэгтэй.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт нэн даруй хүргүүлэх бөгөөд уг асуудлыг хариуцсан нэгж, албан тушаалтан ажлын 10 өдөрт багтаан хянаж, хариу мэдэгдэнэ.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт төрийн албан хаагчийн анкет, ял шийтгэлгүй эсэх талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө, оруулагчийн талаарх лавлагаа, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Авлигатай тэмцэх газар нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж үзээд 2015 онд 40, 2016 онд 39, 2017 онд 39, 2018 онд 25 этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлсэн байна.

2017 онд 276 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинээр, өмнөх оны үлдэгдэл 32 буюу нийт 308 албан тушаалтны мэдүүлгийг хүлээн авч, үүнээс 274 мэдүүлгийг хянан шалгасан байна.⁴

<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас</p>
<p>23.7.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол түүнийг тухайн албанд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй.</p>

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон бол албан тушаалыг нь бууруулах, удаа даргаа зөрчсөн бол төрийн албанаас халах шийтгэл ногдуулдаг.

5.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар

Нийтийн албан тушаалтан ХАСХОМ-ээ бүртгүүлсний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ тухай хуульд заасан байгууллага, албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт,

⁴ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2017, УБ 2018, 24-р тал

шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй талаар өмнөх бүлэгт өгүүлсэн.

Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх,
тайлбарлах:

Албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэнэ.

Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах, энэ талаар бичгээр мэдэгдэнэ.

Ашиг сонирхлын зөрчил байгаа талаар мэдэж байгаа бусад албан тушаалтан энэ тухайгаа холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно.

Ашиг сонирхлын зөрчлийн талаар дээр дурьдсан мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нэн даруй өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх, эсвэл хуульд заасан тохиолдолд тухайн албан тушаалтнаар гүйцэтгүүлж болно.

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан бичгээр тайлбар гаргаж, байгууллага, удирдах албан тушаалтандаа хүргүүлнэ. Үүнд болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар шийдвэр гаргана.

Албан тушаалтан дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг дор дурьдсан тохиолдолд гаргана:

- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түвшинд батлагдах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, гэрээ хэлцэлийн төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох.

“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл

Улсын Их Хурлын Хууль зүйн байрны хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хэсгээр

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эхийн нэр):	Нэр:
Албан тушаал:	Ажилтан байгаа байгууллага:	
Албан тушаалд томилогдон оч. сар, өдөр:	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм / Гүй

Хойр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд нийтийн албанд нийтлэн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй бололыг үүрэг мэдэгдэн байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх үрээр:

1. Гагцхад төрөөд оролцож шийдвэр нь захирагч буюу агаартай холбоотой гэх тухай нун, хуульч этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл:

2. Гэрээ гэрээ, хэлцэлийн оролцогч, ажил эзэл, хандив, тусламж, үйлчилгээг хуульч, хуульч этгээд өгч байсан байгаа-гүй холбоотой үүрэг хүлээн гэх.

Байгууллага, хуульч этгээд өгч байсан, гишүүнлэгтэй, ажил төлөөлөл хэрэгжүүлж байсан байгаа гэх.

Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал:

Нөхцөл байдал бий болсон гэх үзэх нийтийн албанд нийтлэн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлсний 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэн, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзан байна.

Дөрөв. Баталгаажуулалт:

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэ үйл мэдэгдлийг унан зөв гаргасан болохыг үүрэг баталгаажуулж байна.

Албан тушаалт / Сарын үсэг / Сарын үсгийг тайлбал /

... / ОН / Сар / Өдөр

Шиндээрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч эсэх Тийм / Гүй

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байгаа

Дэд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томоон ажиллуулж болохгүй

Мэргэжлийн өндөр мэдэл, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байгаа

Баталгаажуулалт:

Албан тушаалт / Сарын үсэг / Сарын үсгийг тайлбал /

... / ОН / Сар / Өдөр

2017 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг үндэслэн тухайн албан үүргийг гүйцэтгэхэд “ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлсэн мэдэгдэл” гаргасан 32287, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан 850 мэдүүлэг гаргагч нар тус тус бүртгэгдсэн байна.⁵

5 Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2017, УБ 2018, 21-р тал

Дасгал 2.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга “З” нь Анагаах ухааны сургуульд доод курсэд нь сурч төгссөн “С”-ийг Сум дундын эмнэлгийн даргаар томилсон тушаал гаргажээ. “З”-г сургуулийн найзыгаа удирдах албан тушаалд томилж, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан гэх асуудлаар сумын иргэдээс өргөдөл, гомдол ирсний дагуу аймгийн Засаг дарга “З”-д хариуцлага хүлээлгэсэн. Харин “З” нь “С”-ийг томилох асуудлыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдсэн. С нь төрийн үйлчилгээний удирдах албаны сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан, би даргын зөвлөлийн хуралд орохын өмнө болон томилох тушаал гаргахын өмнө “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”, тайлбараа Танд гаргасан тул хууль зөрчөөгүй” гэж маргажээ.

Асуулт: “З”-ийн маргаж буй үндэслэл нь зөв үү?

Хариулт: “З” нь дээрх нөхцөл байдалд ашиг сонирхлын зөрчил үүссэн талаар мэдэгдэл гаргаж үүргээ биелүүлэн, тайлбараа Засаг даргад гаргасан, түүнчлэн “С” нь түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээд бус, сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилсон байна.

Дасгал 3.

Дүүргийн Татварын хэлтсээс хийх татварын хяналт шалгалтын хуваарь батлагдахад татварын улсын байцаагч “Г” өөрийн төрсөн дүүгийн үүсгэн байгуулсан компанид хяналт шалгалт хийхээр хуваарилагдсан байсан тул “Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргаж хэлтсийн даргадаа танилцуулжээ.

Татварын хэлтсийн дарга “Д” нь мэдэгдлийн маягтын “тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй” гэх сонголт дээр тэмдэглэгээ хийж, “Г”-г төрсөн дүүгийнхээ үүсгэн байгуулсан компанид хяналт шалгалт хийхийг зөвшөөрсөн.

Асуулт: Татварын хэлтсийн дарга “Д” дээрх шийдвэрийг гаргасан үндэслэл нь зөв үү?

Хариулт: Дүүргийн татварын хэлтэст ажиллаж буй бусад татварын улсын байцаагч нараас дээрх хяналт шалгалтыг хийлгэх боломжтой байсан тул хэлтсийн дарга “Д”-ийн шийдвэр хуульд нийцээгүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

8.1.Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

8.2.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

8.5.Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно:

8.5.1.тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;

8.5.2.тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

29.2.2.энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

29.2.3. энэ хуулийн 10, 14, 17, 18 дугаар зүйл, 20.1, 20.4-т заасныг зөрчсөн, энэ хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй, энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, контракт байгуулсан, зөвшөөрөл олгосон, энэ хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах;

5.4 | Ил тод байдал, хувийн нууцлалын тэнцвэрийг хадгалах

Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байх асуудлыг авч үзье. Байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

Ил тод байх, хувийн мэдээллийн нууцлах тэнцвэрийг хадгалах ёстой. Энэхүү тэнцвэрийг хангахдаа дараахь ерөнхий зааврыг анхаардаг:

- төрийн албан хаагчийн нийтийн албан тушаалтны хувьд зөвхөн олон нийтэд шаардлагатай тохиолдолд тэдний хувийн мэдээллийг дэлгэнэ гэсэн дүрэм үйлчлэх ёстой. Ялангуяа өндөр албан тушаалтны хувьд мэдээллийг нийтэд ил болгох ёстой. Харин доод түвшний албан тушаалтны мэдүүлгийг байгууллага дотооддоо хяналт хийхээр зохицуулсан байхад хангалттай.
- Мэдүүлгийг нийтэд дэлгэх нь сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг илрүүлэхэд нөлөөлдөг. Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянан шалгахад олон нийт, хэвлэл мэдээллийн үүрэг нэн чухал.

Мэдүүлэгт орсон мэдээллийг нийтийн болон нийтийн бус гэж ангилдаг. Жишээ нь, Канадын төрийн албан тушаалтны эд хөрөнгийн мэдүүлэг дэх мэдээллийг нийтэд дэлгэх, дэлгэхгүй гэж ангилдаг. Нийтэд дэлгэх мэдээлэл нь засгийн газрын бодлого шийдвэр шууд ба шууд бусаар нөлөөлөх боломжтой эд хөрөнгөтэй холбоотой мэдээлэл байна. Нийтэд дэлгэхгүй мэдээлэл нь хувийн хэрэгцээ, гэр бүлийн орон байр, арилжааны бус эд хөрөнгийн мэдүүлэг багтдаг. Сонгуульт албан тушаалтны хувьд, жишээ нь Өмнөд Африкт парламентын гишүүдийн эд хөрөнгийн ерөнхий мэдүүлгийг нийтэд нээлттэй байлгадаг ба харин гэр бүлийн гишүүний мэдээллийг ил биш байхаар зохицуулсан байдаг.⁶

Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангах зорилгоор Авлигатай тэмцэх газар мэдүүлгийг цахим сайтад байршуулах ажлыг зохион байгуулдаг. Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1

⁶ G. Carney, Conflict of Interest: Legislators, Ministers and Public Officials, Transparency International Working Paper, 1998.

дэх хэсэгт заасан албан тушаал эрхэлж байгаа 236 албан тушаалтны 2017 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг <http://www.хасхон.iaас.тп> нээлттэй сайтад байршуулсан байна. Ингэснээр иргэдийг мэдээллээр хангах замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт, оролцоог дээшлүүлж, төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинд эерэг нөлөө үзүүлэх ба хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн дээшилж, хууль бус нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд зохих өөрчлөлт гарах боломжтой.⁷

Мөн дээрх хуулийн дагуу Албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар нээлттэй байна.

7 Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2017, УБ 2018, 23-р тал


ЗУРГААДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ

6.1 | Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдснаар нийтийн албан тушаалтны албан үүрэгтэй зөрчилдсөн хувийн сонирхлыг хориглох, хязгаарлах, зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Хуульд зааснаар албан тушаалтанд 13 төрлийн хориглолт, хязгаарлалт тавигдаж байна. Үүнд:

1. Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон зохицуулалт;
2. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон зохицуулалт;
3. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглосон зохицуулалт;
4. Сурталчилгаатай холбогдсон зохицуулалт;
5. Төлөөлөлтэй холбогдох зохицуулалт;
6. Төлбөр авахтай холбогдсон зохицуулалт;
7. Бэлэг хүлээн авахтай холбогдсон зохицуулалт;
8. Хандив авахтай холбогдсон зохицуулалт;
9. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон зохицуулалт;
10. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон зохицуулалт;

11. Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт;
12. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараахь зохицуулалт;
13. Бусад орлогын хязгаарлалттай холбогдсон зохицуулалт.



Бүдүүвч 4. Хориглолт, хязгаарлалтууд

6.2 | Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон зохицуулалт

Дасгал 4.

Танай байгууллага их хэмжээний бараа материал, бүтээгдэхүүнийг тогтмол худалдан авдаг ба өнгөрсөн хугацаанд бараа материал нийлүүлдэг 3 компанийн бараа нь чанар сайтай, үнэ өртгийн хувьд ч хямд байжээ. Харин таны дүү энэ салбарт үйл ажиллагаа явуулахаар компани байгуулан хамгийн сайн, хамгийн хямд бараа нийлүүлж байгаа компаниудын тендерт ирүүлсэн материал, өөр боломжтой бусад мэдээллийг хуулбарлан өгөхийг танаас хүсчээ. Авсан мэдээллээ цааш нь бусдад дамжуулахгүй, зөвхөн өөрөө хэрэглэнэ гэж зөвшөөрсөн тул та дүүдээ хүссэн мэдээллийг нь хуулбарлан өгсөн байна.

Асуулт: Дээрх үйлдлийн улмаас танай байгууллагад хохирол учраагүй бол ашиг сонирхлын зөрчилд хамаарах уу?



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолтод *“Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно”* гэж заасан. Дээрх тохиолдолд тухайн байгууллагад хэдийгээр хохирол учраагүй ч танил талдаа ашигтай байдлаар албаны мэдээллийг задруулсан нь нийтийн эрх ашигт харшилсан үйлдэл бөгөөд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.9-д *“албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг*

сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх”; 39.1.11-д албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завшихыг хоригложээ.

Нууцын асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид дараахь байдлаар тусгасан байна:



Бүдүүвч 5. Нууцын төрлүүд

Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох

нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.

Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох ба энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Мөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хэдэн жилийн өмнө Английн дээд шүүхээс “Барклейн” банк “CF Partners”-д хохирол учруулсныг тогтоож 10 сая еврог буцаан олгуулахаар болжээ. Банк нууцыг хадгалах үүргээ зөрчин “CF Partners”-ийн нэгэн компанийг худалдан авах зориулалтаар зээл авахаар бүрдүүлж өгсөн мэдээллийг өөрсдөө тэр компанийг худалдан авахын тулд хууль бусаар ашигласан байна. Энэ жишээ нь ашиг сонирхлын зөрчлийг зүй зохистойгоор зохицуулан нууц мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх ач холбогдлыг харуулж байна.

Жишээ 5. “CF Partners” нь байгалийн хий, цахилгаан, түүхий нефть, нүүрс зэрэг бүтээгдэхүүнийг борлуулдаг бөгөөд Шведийн “Трикорона АВ” фирмийг худалдан авах мөнгө зээлэхээр “Барклей” банкид 2008 онд хандсан. “Трикорона” нь нүүрс худалдаалдаг фирм бөгөөд түүнийг “CF Partners” хөрөнгийн зах зээлд доогуур үнэлгээтэй гэж үзэж байв. Зээлээ авахын тулд банкинд компанийн техникийн мэдээлэл, түүнийг авсаны дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэх мэт мэдээллүүдийг гарган өгчээ.



Гэвч “CF Partners” болон “Трикорона” хоёрын хэлэлцээр эцэстээ бүтээгүй бөгөөд харин банк өөрөө “Трикорона”-г 2010 онд худалдаж авсан байна. “CF Partners” нууцыг хадгалаагүй хэмээн банкны эсрэг 2011 онд зарга үүсгэсэн. 2012 онд банк “Трикорона”-г асар их ашигтайгаар зарсан байна. Шүүх “Барклейн” банкиг

шударгаар итгэл хүлээх үүргээ зөрчин мэдээллийг хууль бусаар ашигласан гэж үзэж хохиролд 10 сая еврог “CF Partners”-д олгуулахаар шийджээ.

Misuse Confidential Information and Risk a Significant Payment by Willis Towers Watson, October 31, 2014

<https://blog.willis.com/2014/10/misuse-confidential-information-and-risk-a-significant-payment/>

Жишээ 6. Чикагогийн цагдаагийн газар

"Associated Press"-ийн 2016 оны илтгэлд АНУ-ын цагдаагийн ажилтнууд хууль сахиулах байгууллагын мэдээллийн санг хууль бусаар ашиглан ойрхон хүмүүсийнхээ хувийн мэдээллийг байнга хянаж байсан болохыг тогтоожээ. Ихэнхи тохиолдолд өгөгдлийг хууль бусаар ашиглаж хувийн мөрдлөг хийх, дарамт шахалт үзүүлэх гэх мэт тохиолдлууд гарч байжээ.

<https://blog.willis.com/2014/10/misuse-confidential-information-and-risk-a-significant-payment/>

Жишээ 7. "AT&T Customer Information" (Хэрэглэгчийн мэдээлэл)

Үүрэн холбооны компани "AT&T"-д 2015 онд хийсэн шалгалтаар тус компанийн олон улсын ярианы төвийн ажилтнууд нь 280000 хэрэглэгчийн хувийн мэдээллийг хууль бусаар задруулсан нь илчлэгдсэнээр Холбооны харилцаа, холбооны хороонд 25 сая гаруй доллар төлжээ. Ажилтнууд АНУ-ын "AT&T"-ийн хэрэглэгчдийн нэр, нийгмийн халамжийн дугаарыг гуравдагч этгээдэд худалдсан бөгөөд худалдан авсан этгээдүүд уг мэдээллийг ашиглаж зарим гар утсыг блоколсон ба ингэснээр тэдгээр утсыг "AT&T"-аас өөр бусад сүлжээнд ашиглах боломжтой болгожээ.

(Cell phone unlocking became legal in the U.S. in 2014.) <https://blog.willis.com/2014/10/misuse-confidential-information-and-risk-a-significant-payment/>

Жишээ 8. Миннесотагийн Цагдаагийн Хэлтэс

Миннесота мужийн улсын аудиторууд мужийн хэмжээнд цагдаагийн 88 ажилтан (2013-2015 оны хооронд) жолоочийн үнэмлэхний өгөгдлийн улсын сангаас найз охин, гэр бүлийн гишүүд болон бусдын мэдээллийг харахаар зөвшөөрөлгүйгээр, албан ёсны мөрдлөгөтэй ямар ч холбоогүйгээр хайлт хийж байсныг 2016 онд илрүүлжээ. Аудиторууд үүнийг цөөн удаагийн тохиолдол биш, мужийн цагдаа нарын тэн хагас нь өгөгдлийн санд сэжиг бүхий хайлт хийж байсан гэж мэдэгджээ.

<https://blog.willis.com/2014/10/misuse-confidential-information-and-risk-a-significant-payment/>

Энэ бүх жишээ нь ажилтнууд мэдээллийг хууль бусаар ашиглах, гуравдагч этгээдэд ашиглуулах эрсдэл өндөр байдгийг харуулж байна.

6.3 | Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт



Дасгал 5.

Хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч “Г” аймгийн талх, нарийн боовны үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг ахлахаар болов. Тус шалгалтад “Г”-ийн нь гэр бүлийн гишүүний ажиллуулдаг “Зөөлөн Дэлбээ” цех хамрагдсан бөгөөд “Г” өөрөө хяналт шалгалтыг хийж гүйцэтгэснээс гадна өөрийн удирдлагад ажилладаг “Б”-д үүрэг өгч уг цехэд хамгийн өндөр үнэлгээг өгүүлжээ...

“Г”-ийн үйлдэл хуульд нийцэх үү, ямар арга хэмжээ авах байсан бэ?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Үүнд:

- захиргааны шийдвэр гаргах;
- удирдах;
- хяналт, шалгалт хийх;
- хариуцлага хүлээлгэх;
- гэрээ байгуулах;
- эдгээрийг хэлэлцэх;
- бэлтгэх;
- оролцох зэрэг үйл ажиллагаа явуулах.

Дээрх тохиолдолд улсын ахлах байцаагч “Г” нь өөрийн гэр бүлийн гишүүний ажиллуулдаг “Зөөлөн дэлбээ” цехэд хяналт шалгалт хийхээс татгалзах, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэж, тайлбар гаргах үүрэгтэй байсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар Албан тушаалтан өөрийн **нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд** тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг мөн хориглодог.

Мөн хуулийн 11.3-т зааснаар Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш **хоёр жилийн хугацаанд** тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг тус тус хориглодог.

Энэ заалтын захиргааны шийдвэр гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй байхаар хуульд тусгажээ.

6.4 | Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох

Өмнөх жишээ (Дасгал 5)-г эргэн харцгаая. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасан тул “Г” нь өөрийн удирдлагад ажилладаг улсын байцаагч “Б”-д нөлөөлж “Зөөлөн дэлбээ” цехэд хамгийн өндөр үнэлгээ өгүүлсэн нь “шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох” тухай заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх хуулийн 11, 12 дугаар зүйлд заасныг зөрчсөн тул уг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасны дагуу “Г”-г нийтийн албанаас халах шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Харин “Б” нь ахлах байцаагч “Г”-ийн хууль бус нөлөөллийн талаар Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүргээ хэрэгжүүлэх ёстой байжээ. Хуульд¹ “албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэж заасан байна. Хэрэв энэ үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар бууруулах шийтгэл ногдуулах үндэслэл² болдог.

Дасгал 6.

Нэгэн сумын Засаг дарга “О” нь сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан тамхи худалдан борлуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах аар ажлын хэсгийг байгуулан ажиллуулжээ. Шалгалтын дүнгээр “Ундрах” ХХК-ийн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлахаар болжээ. Гэтэл захирамж гарахын өмнө аймгийн Засаг дарга сумын Засаг дарга “О” руу утасдаж, “Ундрах” ХХК-ийн тамхи худалдаалах эрхийг цуцлахгүй байх үүрэг өгсөн.

Асуулт: Дээрх тохиолдолд та ямар хууль зүйн дүгнэлт гаргах вэ?

Тайлбар: “Ундрах” ХХК нь аймгийн Засаг даргын хадам эцгийн үүсгэн байгуулсан компани байсан.

1 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт.

2 Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт.

6.5 | Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт

Дасгал 7.

Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч “С” нь “М+” компанийн үйлдвэрлэсэн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг 100% байгалийн гаралтай түүхий эдээр хийж, шинэ технологиор савласан бүтээгдэхүүн учраас үндэсний үйлдвэрээ дэмжиж худалдаж авч хэрэглэж байхыг уриалсан сурталчилгааны бичлэгт оролцжээ. “М+” компани уг бичлэгийг телевиз, нийгмийн сүлжээгээр олон давтамжтайгаар нийтэд түгээсэн ба “С”-ийн оролцсон бичлэгт түүний нэр, албан тушаалыг тодорхой бичсэн тайлбартай цацагджээ. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч “С” дээрх бичлэгт орсныхөө төлөө “М+” компаниас ямар нэг хөлс, шан харамж аваагүй.

Асуулт: Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэх үү?

Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглодог. Харин дээрх хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй³.

Дасгал 8.

Нэгэн дүүргийн Засаг дарга өөрийн хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт баригдсан орон сууцны шинэ хорооллын нээлтэд оролцож үг хэлж тухайн орон сууцны компанийн барилгын чанар сайн, үнийн хувьд хямд хэмээн иргэдийг худалдан авах боломжтой талаар ярьжээ. Уг компани нь Засаг даргын хэлсэн үгийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон зар сурталчилгааны самбарт байршуулсан байна.

3 Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт.

Асуулт: Засаг даргын үйлдэл нь албан тушаалын байдлаа ашиглан зар сурталчилгаанд оролцсон үйлдэл мөн үү?

6.6 | Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт

Дасгал 9.

Цагдаагийн ерөнхий газрын тасгийн дарга “Я”-ийн эхнэр жолооны курс байгуулахаар болжээ. Эхнэр нь жолооны курс байгуулах зөвшөөрлийг компанийн нэрийн өмнөөс хөөцөлдөж өгөхийг “Я”-аас хүссэний дагуу тэрээр хариуцсан нэгжийн даргатай уулзаж, бүрдүүлсэн материалаа хүлээлгэн өгч, тодруулах шаардлагатай зүйл гарвал өөртэйгөө холбогдохыг хүсчээ...

Асуулт: Тасгийн дарга “Я”-ийн үйлдэл хууль зөрчсөн үү?

14.1. Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

14.3. Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:

14.3.1. өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;

14.3.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

14.3.3. албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

Дасгал 10.

Оролцогчдыг багаар ажиллуулж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан агууллагад нийцсэн жишээ зохиолгож хэлэлцүүлнэ.

14.2. Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно.

6.7 | Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт**Дасгал 11.**

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор сумын нутаг дэвсгэрт оторлосон, дамжин өнгөрсөн мал бүхий иргэдээс бэлчээрийн төлбөрт бод малын толгой тутам 1000, бог малын толгой 500 төгрөг хураан авч, сум хөгжүүлэх арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Гэтэл тус сумын нутагт өвөлжиж буй зэргэлдээх сумын малчид хууль бус төлбөр хураамж тул өгөхгүй гэж гомдол гаргажээ...

Монгол Улсад татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй⁴ байдаг. Харин зарим албан татвар, төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох эрхийг Засгийн газар болон аймаг, нийслэл, сумын ИТХ-д олгосон байдаг. Түүнчлэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс нийтээр дагаж мөрдөх төлбөр, хураамж, татварыг шинээр бий болгох, эсхүл хувь хэмжээг тогтоох, өөрчлөх эрх хэмжээ хуулиар олгогдоогүй байх тул Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр хууль бус юм.

Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.

4 Татварын ерөнхий хууль. 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт

6.8 | Бэлэг авахтай холбогдсон хориглолт, хязгаарлалт

Европын зөвлөл нь төрийн захиргааны шударга байдлын асуудлыг хөндөж, авлигатай тэмцэх үндсэн 20 зарчимдаа шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлын талаарх зарчмыг онцлон тусгасан байдаг. Европын зөвлөлийн Сайд нарын хороо 2000 онд ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэг, ажил үүргээ гүйцэтгэж байх явцдаа бэлэг дурсгалын зүйл авахтай холбоотой⁵ заалтуудыг агуулсан нийтийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний талаарх цогц зөвлөмж гаргасан. Сайд нарын хороо нь мөн шүүх засаглал, хууль сахиулах байгууллагуудын шударга байдал, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэд хэдэн зөвлөмжийг гаргасан байдаг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “Бэлэг” гэж “нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг хэлнэ” хэмээн тодорхойлсон⁶ байдаг.

Дасгал 12.

“МХМ” компаниас мэргэжлийн хяналтын байцаагчдыг байгууллагын ойг нь тохиолдуулан өөрийн шинээр нээгдсэн ресторанд нэг удаа үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн бичгийг, цаашид 10 хувийн хөнгөлөлттэй үйлчлүүлэх хөнгөлөлтийн картын хамт бэлэглэжээ.

Асуулт: Мэргэжлийн хяналтын байцаагчид дээрх бэлэг, үйлчилгээг хүлээн авч болох уу?

5 Европын зөвлөл, Сайд нарын хорооноос Нийтийн албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээний талаарх гишүүн улс орнуудад хүргүүлсэн R (2000) 10 тоот зөвлөмж, 2000. [https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec\(2000\)10_EN.pdf](https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec(2000)10_EN.pdf)

6 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт.

Дасгал 13.

Эрчим хүчний яамнаас 5000 ширхэг нарны зай нийлүүлэх тендер шалгаруулалт зарлажээ. Тендерт 10 орчим компани оролцож материал ирүүлснээс “Гэгээ” ХХК нь хуулийн дагуу хамгийн бага үнийн санал ирүүлж, улмаар шалгарчээ. “Гэгээ” ХХК-ийн гүйцэтгэх захирал тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд баярласнаа илэрхийлж, хүн тус бүрт гарын бэлэг хүргүүлсэн байна. Тендерийн үнэлгээний хорооны гишүүд уг бэлгийг хүлээн авчээ.

Асуулт: Үнэлгээний хорооны гишүүд тухайн бэлэг, үйлчилгээнээс татгалзах ёстой юу?

Дасгал 14.

Хяналт шалгалтын ажлаар нийслэлээс аймгийн төвд ирж томилолтоор ажиллаж байсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгалтын ажлаа дуусган зочид буудалдаа ирэхэд буудлын жижүүр дээр хүн тус бүрт цаасан ууттай бэлэг үлдээсэн байв. Бэлэг үлдээсэн хүний нэрийг хэлэхэд ажлын хэсгийн гишүүдийн нэг нь ч танихгүй хүн байв. Тиймээс хоорондоо ярилцаад тэдний хийсэн шалгалттай холбоотой байж болзошгүй тул бэлгийг авахгүй байхаар шийдэж энэ тухай нийслэл рүү удирдлагадаа мэдэгдэхээр болов. Удалгүй бэлэг үлдээсэн хүн өөрөө ирснээр асуудал тодорхой болж бэлгийг авчээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийслэлээс аймгийн төв рүү ирэх замд нь цасанд суусан машиныг татаж гаргасан байна. Ажлын хэсгийн гишүүдэд талархсан жолооч тэдэнд хувийн зүгээс бэлэг өгсөн байжээ.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.⁷

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн

⁷ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт

16.1-д зааснаар албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглосон.

Дасгал 15.

Төрийн албан хаагч “Т”-ийн багын найз “М” хувиараа бизнес эрхэлдэг. Төрсөн өдрөөр нь “М” найз “Т”-дээ 1.800.000 төгрөгийн үнэтэй гар утас бэлэглэжээ. Дээрх бэлэг нь “Т”-ийн нэг сарын цалингаас үнэтэй тул “Т” хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд бичгээр мэдэгдсэн байна.

Дээрх хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг уг хориглолтод хамаардаггүй.

“Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах журам”-ыг Засгийн газраас баталсан. Журамд зааснаар “дипломат журам” гэдгийг хэрхэн ойлгох, албан тушаалтан дипломат журмаар авсан бэлгээ маягтын дагуу хэрхэн мэдэгдэх асуудлыг зохицуулсан. Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, зарцуулах, тайлагнах асуудлыг эрхлэх орон тооны бус комисс ажилладаг бөгөөд бэлэгний бүртгэл, үнэлгээтэй холбоотой Комиссын чиг үүрэг, бүртгэлд орох мэдээлэл, үнэлгээний зарчим, бэлгийг захиран зарцуулах, ашиглах хэлбэр, бэлгийг албан тушаалтанд үлдээх болон бэлэгний зарцуулалтын талаар тайлагнах, мөн уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах маргааныг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг тусгасан байдаг.

“М” нь “Т”-ийн төрөл, садангийн хүн биш байна, энэ тохиолдолд тэрээр ажил үүрэгтэй нь холбогдолгүй бэлэг хүлээн авч болох боловч тодорхой шаардлага тавигдана. Тухайлбал, “Т” нь бэлгийг эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор заавал мэдэгдэх үүрэгтэй.

Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд

уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Дээрх тохиолдолд “Т” хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлсэн байна.

Албан тушаалтны авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг төрийн өмчид шилжүүлнэ.

Харин албан тушаалтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.⁸

Дасгал 16.

(Өмнөх дасгал 16-д) Хэрэв, “Т” найз “М”-ээс албан үүрэгт нь хамааралгүй бэлэг хүлээн авснаас хойш хоёр жилийн хугацаанд “М”-тэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлж болох уу? Багаар ажиллаж хариулт бэлтгэнэ.

Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

8 Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6

Дасгал 17.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн “Г” “Санхүүгийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан бөгөөд орон нутгийн өмчийн оролцоотой “AAA” компанийн удирдлага түүнд бэлэг гардуулахдаа бэлэгний үнийг уг компанийн хувь эзэмшигч хувийн компани төлсөн тул хуульд харшлахгүй байх гэж тайлбарлажээ. “Г” нь “AAA” компанийн орон нутгийн өмчид ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгчөөр ажиллаж байгаад жилийн өмнө уг үүргээс чөлөөлөгдсөн байна.

Асуулт: “Г” бэлгийг хүлээн авч болох уу?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.4-т заасан этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.



“Г” нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгчөөр ажиллаж байсан. Одоо төрийн албанд ажиллаад 1 жил болж байгаа. Тиймээс “AAA” компанийн удирдлагаас хоёр жилийн дотор бэлэг авч болохгүй бөгөөд тэрээр хуульд заасан хориглолтыг зөрчөөгүй байна.

Албан тушаалтан бэлэг авахаас өмнө хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

Бага түвшний авлига өргөн тархсан байдлыг арилгах зорилготой баталсан авлигатай тэмцэх нэгэн шинэ хууль⁹-ийг Солонгос Улс 2016 оны 9 дүгээр сараас мөрдөж эхэлсэн. Уг хуулийг тус улсын Дээд шүүхийн шүүгч асан Ким Ён-Ран боловсруулсан бөгөөд хуулийг боловсруулсан хүнийх нь нэрээр “Ким Ён-Ран¹⁰”-ны хууль гэж олон нийт нэрлэх болсон юм.

Жишээ 9. Тус хууль нь 50 сая хүн амтай БНСУ-ын 4 сая төрийн албан хаагчдад хамаарна. Хуулийн зорилго нь хүүхэддээ сайн үнэлгээ авах зорилгоор эцэг, эхчүүдээс багш нарт, төрийн албаны процессыг хурдасгах зорилгоор бизнес эрхлэгчдээс албан тушаалтнуудад өгөх хахуулийг бууруулахад чиглэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч 50000 вонь болон түүнээс дээш үнэтэй бэлэг авах, эсхүл 30000 вонь болон түүнээс дээш үнэтэй дайлуулж, цайлуулахыг хориглосон байгаа бөгөөд хууль зөрчигчдөд торгууль ногдуулах, эсхүл шоронд хорих шийтгэл оногдуулах аж.

“Шинэ хууль бол өмнөх хуулиудаас үнэхээр өөр. Энэ хуульд маш олон зүй бус зүйлийг хамруулж, түүнд хатуу шийтгэл ногдуулахаар болсон. Энэ хууль хүмүүсийн дунд тогтсон муу зуршлаас салахад туслах болно. Хүмүүст таагүй санагдаж байж магадгүй ч, сайн эм гашуун байдаг” хэмээн тус улсын Үндэсний Ассамблейн дарга Чун Си-Кун сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа дурдажээ.

Уг хуультай холбогдуулан борлуулалтын хэмжээ буурна хэмээн орон нутгийн бизнес эрхлэгчид, зоогийн газрын эзэд гомдол гаргасаар байгаа юм. Улмаар зарим зоогийн газрууд “Ким Ён-Ран”-ны хоолны зэс буюу 29900 вонь болон түүнээс бага үнэтэй хоолыг цэсэндээ нэмээд байгаа аж.

9 <http://newsinfo.inquirer.net/819878/tough-anti-corruption-law-takes-effect-in-south-korea#ixzz4LWdzIEAK>

10 Kim Young-Ran

Дасгал 18.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 95 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдад ОХУ-ын зүгээс бэлэг гардуулсан байна. Энэ тохиолдолд хууль зөрчих үү?

Хариулт: Сонирхлын зөрчлийн хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй байна. Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлагнах, зарцуулах журмыг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор баталсан

6.9 | Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

“Хандив” гэж “нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэх”-ийг ойлгохоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхойлсон.

Дасгал 19.

Дасгал 20. Сумын Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 99 дүгээр захирамжаар тус суман дахь сүм хийдийг сэргээж шинээр барих, энэ ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив цуглуулж авахыг сумын ЗДТГ-ын даргад даалгасан байна. Тус суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ф” компани сүм хийдийг сэргээн барих ажилд 20 сая төгрөгийн хандив өгчээ. Харин сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар захирамжаар “Ф” компанийн охин компани болох “П” компанид 5 жилийн хугацаатай 2 гектар газар ашиглуулах тухай захирамж гаргасан байв.

Асуулт: Хуулийн этгээдээс хандив авсан асуудал нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн үү?

Нийтийн албан тушаалтан хандив хүлээн авахад хуулиар тодорхой хязгаарлалтыг тогтоож өгсөн байна. Тухайлбал,

Нэгдүгээрт, Төрийн байгууллага, нийтийн албан тушаалтан нийтийн хэрэгцээнд хуулиар зөвшөөрснөөс бусад бэлэг, бусад санхүүгийн дэмжлэг хүлээн авахыг хориглоно,

Хоёрдугаарт, иргэн, хуулийн этгээдээс ямарч тохиолдолд бэлэг, санхүүгийн туслалцаа хүсэхийг хориглоно,

Гуравдугаарт, төрийн байгууллагын ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг зориулалтаар нийтийн албаны хэрэгцээнд хандив хүлээн авахыг төрийн байгууллага, албан тушааланд хуулиар зөвшөөрсөн бөгөөд уг хандивыг хүлээн авснаар тухайн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй байх ёстой.

Дөрөвдүгээрт, хэдийгээр хуулиар зөвшөөрөгдөх хандив боловч түүнийг хандив хүлээн авагчийн албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа тохиолдолд хүлээн авах боломжтой.

Тавдугаарт, хуулиар зөвшөөрөгдөх хандивыг хүлээн авахаас өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

Зургаадугаарт, хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглодог.

Дасгал 20.

Дүүргийн Засаг дарга ЗДТГ-ын ажилтнуудыг сургах, чадавхжуулах чиглэлээр хөтөлбөр батлав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Өндөр мэдлэг” төрийн бус байгууллагаас 14 хоногийн сургалтыг үнэ төлбөргүй явуулах саналыг дүүргийн ЗДТГ-ын даргад тавьжээ. Тэрээр “Өндөр мэдлэг” төрийн бус байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжин үнэ төлбөргүй сургалт авах болсныг Засаг даргадаа танилцуулан холбогдох зөвшөөрлийг авч сургалтыг хийлгэжээ.

Асуулт: Энэ үйлдэл хууль зөрчсөн үү?

Дасгал 21.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг сургах, чадавхжуулах хөтөлбөр ч амжилттай хэрэгжиж дууссан байна. Жилийн дараа “Боловсрол мэдлэг” төрийн бус байгууллагаас дүүргийн Засаг даргад хандаж, тухайн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах газар эзэмших зөвшөөрөл хүссэн албан бичиг ирүүлжээ.



Асуулт: Хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хуулиар хориглосон зохицуулалт энд үйлчлэх үү?

Албан тушаалтан эдгээр тохиолдолд

биечлэн, эсхүл

бусад этгээдээр зуучлуулан

**хандив хүсэх,
хандив цуглуулахад оролцох,
хүлээн авахыг**

ХОРИГЛОНО:

хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

Дасгал 22.

Яамны газрын дарга “В” нэгэн сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн. Сургуулийн захирал түүнээс сургуулийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай хандив цуглуулах ажлыг зохион байгуулахыг хүсч “В” зөвшөөрсөн байна. Тэрээр сургуулийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулан хандивын данс нээсэн болон өөрөө санаачилж 1 сая төгрөг хандивласан тухай зарыг олон нийтэд түгээв. Түүнчлэн хүлээн авалт, уран бүтээлийн тайлан тоглолт зохион байгуулж, ирсэн хандивыг биечлэн хүлээн авч байв.

Асуулт: “В” хандив цуглуулах, хүлээн авах үйл ажиллагаанд биечлэн оролцсон нь хууль зөрчсөн үйлдэл мөн үү?

6.10 | Давхар ажил эрхлэлт болон бусад орлогын талаарх ойлголт

Давхар ажил эрхлэх гэдэгт төрийн албан тушаалтны албан ажлаасаа гадуур түр, эсхүл удаан хугацаагаар нэмэлт ажил эрхлэхийг тодорхойлоход хэрэглэдэг нэр томъёо бөгөөд өөр байгууллагад ажиллах, бизнес эрхлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн бизнес эрхлэх зэргийг ойлгодог.

Өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийг үндсэн ажлынхаа хажуугаар зохих зөвшөөрөл, гэрээний дагуу болон төрөл бүрийн хэлбэрээр бие даасан өөр байгууллагад мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авч ажиллах гэж тодорхойлж болох юм. Давхар ажил эрхлэлтийн зохицуулалт төрийн албанд бүтэн цагаар ажилладаг, хагас өдөр, түр зуур ажиллах эсэхээс үл хамааран бүх нийтийн албан тушаалтанд хамаарна.

Нийтийн албан тушаалтны хувьд давхар ажил эрхлэхийг нь зөвшөөрсөн байх ёстой бөгөөд үүнийгээ баталгаажуулсан байвал зохино. Давхар ажил эрхэлснээр албан үүргээ гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлөх, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эсэхийг тэрээр сайтар тунгаан бодох ёстой. Нийтийн албан тушаалтан үндсэн ажил үүргийн хажуугаар давхар ажил эрхлэх нь ашиг

сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байдаг тул уг асуудлыг зохицуулах, тодорхой дүрэм журмийг тогтоож өгөх нь чухал байдаг.

Төрийн байгууллага албан тушаалтнуудын давхар ажил эрхлэлтийн эрсдэлийн үнэлгээ¹¹-г хийж дараахь эрсдлүүдийг илрүүлж болно. Үүнд:

- *Ажилтан улсын аливаа нөөцийг давхар ажил эрхлэхдээ ашиглах. Үүнд: ажлын байр, ажлын цаг, тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, бичгийн хэрэгсэл, хэвлэх, хувилах тоног төхөөрөмж, олон нийтэд хараахан ил болоогүй, хийгдэж буй гүйлгээний талаарх мэдээлэл зэрэг нууц мэдээлэл ашиглахыг ойлгож болно;*
- *Ажилтан давхар ажил эрхлэхийн тулд ажлаа таслах, чөлөө авах, ажлын цаг бүртгэлийг хуурамчаар үйлдэх, өвчтэй байсан гэх хуурамч нотолгоогоор цалин хөлс авах;*
- *Үйлчлүүлэгч тухайн байгууллагаар үйлчлүүлэхдээ өөрт давуу байдал олж авахын тулд ажилтнуудад урамшуулал болгон давхар ажил эрхлэлтийг санал болгох;*
- *Албан хаагч давхар ажил олж эрхлэхийн тулд хариуд нь албан үүргээ гүйцэтгэхдээ үйлчлүүлэгчид давуу байдал олгох, амлах;*
- *Төрийн байгууллагад ашигладаг бараа, үйлчилгээний бизнестэй холбоотой ажилтан байгууллагадаа ашиг сонирхлоо мэдэгдэлгүйгээр тендер ирүүлэх;*
- *Ажилтан доод тушаалын хүмүүсээр өөрийн давхар ажил эрхлэлттэй холбоотой ажил үүрэг гүйцэтгүүлэх.*

Төрийн албаны ажилтнуудын давхар ажил эрхлэлтийг зохицуулах гол шалтгаан нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ тэгш, шударга, бодитоор хандаасай гэсэн олон нийтийн ашиг сонирхол, төрийн алба, албан хаагчдад итгэх олон нийтийн итгэлийг баталгаажуулах явдал юм. Төр болон олон нийтийн зүгээс эрх мэдэл бүхий албан тушаалтнуудыг үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх давхар ажил эрхлэхгүй байх сонирхолтой байдаг.

Монгол Улсын нийтийн албан тушаалтнуудын хувьд давхар ажил эрхлэлт болон орлогын бусад эх үүсвэрийн талаар хуулиар хэрхэн зохицуулсныг авч үзье.

11 <http://www.icac.nsw.gov.au/preventing-corruption/736-knowing-your-risks/managing-assets/4302-secondary-employment>

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалт, 19 дүгээр зүйлд давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг тус тус тусгасан байна.

Дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Албан тушаалтан уг хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглохоор заасан.

Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албан тушаалтнаас бусад албан тушаалтан хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил, багшлах, эрдэм шинжилгээ болон бүтээлч ажил, ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын **бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр** бусад алба, гэрээний ажил, үүрэг гүйцэтгэж болно.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан нь салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Харин зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.

Мөн “Татварын албанд ажил үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийг давхар эрхэлж болно.

Таны ажил мэргэжлийн хувьд зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэлт, үндсэн ажил хоёр нь тодорхой заагтай, тусдаа байх ёстой¹².

12 <https://www.staff.lu.se/employment/terms-of-employment/secondary-employment>

Байгууллагын удирдлага юу хийх ёстой вэ?

Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журамд заасанчлан албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.

Танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

Дасгал 23.

Боловсролын яамны мэргэжилтэн “К” сүүлийн хэдэн жил сурах бичиг хэвлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажиллаж байгаа. Туршлагатай мэргэжилтний хувьд “К” “Үүлэн” хэвлэлийн компанид зөвлөхөөр ажиллаж, сар бүр урамшуулал авдаг.



Асуулт: “К”-ийн үйлдэл нь хууль зөрчсөн үү?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт УИХ-ын гишүүний эрхэлж болох давхар ажлын талаар тусгасан байна:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

18.2. Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн дараах ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно:

18.2.1. хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;

18.2.2. нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;

18.2.3. багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил¹³

18.2.4. хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;

18.2.5. хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал.

Дасгал 24.

Улсын Их Хурлын гишүүн “Ю” нь ядуурлыг бууруулах чиглэлээр сургалтын төв байгуулан ажиллуулж, амьжиргааны түвшин доогуур өрхийн гишүүдийг үнэгүй сургаж чадавхжуулах үйл ажиллагаа явуулдаг.

Асуулт: УИХ-ын гишүүн энэ ажлыг давхар хашиж байгаа нь хууль зөрчих үү?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд мөн зарим тусгай албан хаагчийн давхар ажил эрхлэлтийн талаар тусгайлан зохицуулсан байна:

¹³ Хуульд “бүтээлч ажил” гэж “төлбөр, орлого олж байгаа сэтгүүл зүй, утга зохиолын болон урлагийн бүтээлийг” хэлнэ хэмээн тодохойлсон байдаг.



18.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.

Дасгал 25.

Баянзүрх дүүргийн прокурор “К” нь хууль тогтоомж зөрчиж хууль зүйн сургуульд Эрүүгийн эрх зүйн чиглэлээр багшилж байгаа талаар иргэн “Э” гомдол гаргажээ.

Асуулт: Прокурор “К” хууль зөрчсөн үү?



18.4. Зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.

Дасгал 26.

Ажлын бус цагаар “ППП” компанид гэрээгээр ажиллаж байсан Зэвсэгт хүчний ...дугаар ангийн ахмад “Н”-ийг сонирхлын зөрчлийн хуулийг зөрчсөн гэж сахилгын шийтгэл ноогдуулж албан тушаал бууруулсан байна. “Н” нь уг шийдвэрийг үл зөвшөөрч гомдол гаргажээ.

Асуулт: Уг гомдлыг хэрхэн шийдвэрлэх вэ? “Н”-ийг албан тушаал бууруулсан нь зөв үү?

Хариулт: Дээрх заалтын дагуу өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээгээр ажил гүйцэтгэж хууль зөрчсөн байна. Дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т уг хуулийн 18 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл хүлээлгэдэг тул зөв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт дээр дурдснаас бусад албан тушаалтны эрхэлж болох давхар ажлын талаар тусгасан байна:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	
18.5.Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно.	18.5.1.хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил
	18.5.2.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
	18.5.3.ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.

Дасгал 27.

Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн “К”-г эрх бүхий байгууллагаас “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөгчөөр томилж, тэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон байна. Тэрээр төрийн өмчийн төлөөлөгчөөр ажилласны төлөө тогтоосон урамшуулал авдаг.

Асуулт: Энэ үйлдэл хууль зөрчсөн үү?



“К”-ийн энэ үйлдлийг хуулиар хориглоогүй. Тэрээр эрх бүхий байгууллагаас албан ёсны төлөөлөгчөөр томилогдсон тул энэ ажлыг давхар эрхэлж болно.

Дасгал 28.

Аймгийн Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн захирал “Б” гэр бүлээрээ зөгийн аж ахуй эрхэлдэг бөгөөд үүнээс бага бус орлого олдог.

Асуулт: Сургуулийн захирал “Б” тухайн ажлыг давхар эрхэлж болох уу?

Хариулт: Хуулийн 18.6.-д Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно гэж заасан тул үйл ажиллагааг эрхэлж болно.

Дасгал 29.

“Ю” нь Улсын Их Хурлын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн, Сайдын албан тушаалыг хавсардаг. “Ю” нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны явц байдал, холбогдох хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг шалгах зорилгоор Улсын Их Хурлаас хяналт шалгалтын ажлын хэсэг томилох санал оруулжээ.



Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.

Дасгал 30.

Иргэн “Б” нь Төрийн өмчит компанид гадаад харилцаа хариуцсан орлогч захирлаар ажилладаг. Тэрээр дүүргийн Татварын хэлтэст гадаад харилцаа хариуцсан ахлах мэргэжилтнээр орсон бөгөөд ажилд орсон даруйдаа хэлтсийн дарга “Д” энэ тухай бичгээр танилцуулсан байна.

Хэлтсийн дарга “Д” хуульд заасны дагуу 30 хоногийн дотор давхар ажил эрхлэхээ зогсоох шийдвэр гаргахыг “Б”-д мэдэгджээ.

Асуулт: Хэлстийн даргын үйлдэл зөв үү?

Давхар ажил эрхлэлтийн талаарх гадаад улс орнуудын жишээ

Жишээ 10. Агентлагийн ажилтан агааржуулалтын засвар, үйлчилгээний гэрээ байгуулах үүрэгтэй. Тэрээр ийм засварын ажилд оролцдог байсан хоёр компанитай холбоотой байв. Ажилтан эдгээр компанитай холбоотой гэдгээ байгууллагадаа мэдээлээгүй, эсхүл агентлагийн давхар ажил эрхлэлтийн бодлогын дагуу зөвшөөрөл авахыг хүсээгүй байна.

Хэдэн жилийн турш уг ажилтан найз нөхөд, хамтран зүтгэгчдийнхээ эзэмшдэг компаниудтай агааржуулагчийн засвар, үйлчилгээний гэрээ хийжээ. Үүний хариуд нь тэд ажилтны өөрийнх нь бизнест тусалж байв. Ийм зохисгүй аргаар зургаан жилийн хугацаанд 710,000 гаруй ам.доллар олж авсан байна.

<http://www.icac.nsw.gov.au/preventing-corruption/736-knowing-your-risks/managing-assets/4302-secondary-employment>

Жишээ 11. Улсын салбарын агентлаг нь бүс нутгийн хэмжээнд гүүр засварын төсөл хэрэгжүүлж байсан. Энэ төслийг хэрэгжүүлэгч байгууллагын нэг ажилтан 12 сарын хугацаанд цалингүй чөлөө авчээ. Ажилтан энэ үедээ гүүр төслийн ажилд ашиглах боломжтой тоног төхөөрөмжийн эд ангийг зохион бүтээсэн. Ажилтны эхнэрийн нэр дээр бүртгэгдсэн компани уг тоног төхөөрөмжийг байгууллагад ашиглуулах гэрээ байгуулсан байна. Ажилтан ажилдаа эргэж орсны дараа ч тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ үргэлжилсээр байв. Агентлаг тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээнд авлигын эрсдэл байгаа тул энэ байдал нь зохисгүй ойлголт төсөөллийг бий болгосон гэдгийг хүлээн зөвшөөрч тоног төхөөрөмжийг өөр газраас авахаар тохиролцсон байна.

<http://www.icac.nsw.gov.au/preventing-corruption/736-knowing-your-risks/managing-assets/4302-secondary-employment>

Албан тушаалтан нийтийн албанд орох үедээ хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаагаа танилцуулаагүй, давхар ажил гүйцэтгэх зөвшөөрөл аваагүй, зөвшөөрөгдсөн төрлийн ажлаас өөр давхар ажил эрхэлж байгаа тохиолдолд яах вэ? Энэ тохиолдолд хяналтын механизм үр дүнтэй ажиллах шаардлагатай. Давхар ажил эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргаж байгаа эсэх нь илрүүлэхэд хэцүү, зарим тохиолдолд

зөвшөөрөл авалгүй давхар ажил эрхэлж байгаа нь байгууллага дотроо, эсхүл гадны хяналтын эрх бүхий байгууллагаас илрүүлэхэд хүндрэлтэй байдаг.

6.11 | Бусад орлогын хязгаарлалттай холбогдох зохицуулалт

Дасгал 31.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэргэжилтэн “Д” удирдлагаас өгсөн үүргийн дагуу “Малын удмын сангийн төрлийг нэмэгдүүлэх нь” чиглэлээр төслийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэсэн байна. Төсөл амжилттай хэрэгжиж дуусахад “Д”-д төслийн зохицуулагч зөвлөхөөр ажилласны урамшуулалд 2000000 төгрөг олгосон байна.

Асуулт: “Д” дээрх урамшууллыг хүлээн авч болох уу?



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.” гэж заасан.

Дасгал 32.

Төрийн өмчийн оролцоотой “ВВВ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн өмчийн төлөөлөгч “Б” нь төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлд 3 жил ажиллаж байгаад чөлөөлөгджээ.

а. Компанийн ТУЗ хуралдаад түүнд уг компаниас гарган худалдаж буй бондноос 100 ширхэгийг бэлэглэхээр шийдвэрлэсэн байна. Төрийн жинхэнэ албан хаагч “Б” хуулийн 11 дугаар зүйлийн 11.3.2-т заасныг үндэслэн уг бэлэгнээс татгалзсан.

б. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс чөлөөлөгдсөнөөсөө хойш “Б” нь хоёр жилийн турш төрийн албанд үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хийж байгаад өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөж, ганц гишүүнтэй “Ё” ХХК-ийг байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Түүний компани шинэ технологи нэвтрүүлж, зах зээлд худалдан авагчтай болж эхлэхэд “ВВВ” ХК “Ё” ХХК-ийг худалдан авах санал тавьжээ. “Б” зөвшөөрсөн бөгөөд төлбөрийн оронд “ВВВ” ХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг эзэмших, мөн уг компаний гүйцэтгэх удирдлагад ажиллах болзол тавив.

Асуулт: Б-ийн үйлдэл хууль зөрчих үү?



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг

Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

- шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;
- холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;
- холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;
- холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

Дасгал 33.

“Х” нь Дэд бүтцийн яаманд ажиллаж байхдаа 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс мөн оны 07 дугаар сарын 10-ны өдрийг дуустал “Эрдэнэс таван толгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллаж байжээ. Харин Монгол Улсын Засгийн газраас “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2019 оны ногдол ашгийг 2020 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигч иргэн бүрт олгох болсон бөгөөд “Х” нь Засгийн газраас үнэгүй олгосон 1072 ширхэг хувьцааны дагуу ноогдол ашиг хүлээн авсан байна.

Асуулт: Энэ асуудал холбогдох хууль, тогтоомж зөрчих үү?

Хариулт: “Х” нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.1-д заасан хэсгийг зөрчөөгүй. Учир нь дээр дурдсан ногдол ашиг нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2019 оны ногдол ашиг боловч хүлээн авсан хугацаа нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн байна.

6.12 | Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Албан тушаалтан энэ хуулийн 18.6¹⁴-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.” гэж заасан.

Дасгал 34.

Барилгын яамны мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн “Б”-ийн ХАСУМ-ийг АТГ-аас хянан үзэж түүнийг хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “ҮҮҮ” ХХК-ний үүсгэн байгуулагч, 10 хувь эзэмшигч, захирлаар бүртгэлтэй болохыг тогтоож Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1¹⁵-д заасныг хэрэгжүүлэх журмыг баримталж ажиллах талаар хариу хүргүүлжээ.

Тус яамны ТНБД нь “ҮҮҮ” ХХК нь хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тул барилгын асуудал хариуцсан мэргэжилтнээр “Б”-г ажиллуулахад зөрчилд үүсэхгүй гэж үзэн тухайн албан тушаалд томилсон байна.

Асуулт: Энд зөрчил байна уу?

Хариулт: Энэ тохиолдолд мэргэжилтэн Б-ийн эрхлэх асуудлын чиг үүрэг, “ҮҮҮ” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл, тухайн компани ашиггүй ажилладаг зэргээс үл хамаарч дээр дурдсан 20 дугаар зүйлийн 20.1-т заасны дагуу мэргэжилтэн “Б” нь дээрх компанийн удирдлагаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй.

- 14 Хуулийн 18.6 дахь заалт: Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно гэж заасан тул үйл ажиллагааг эрхэлж болно.
- 15 Хуулийн 19.1 дэх заалт: Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, Монгол Улсын Ерөнхий Аудитор, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Төрийн сангийн газрын дарга, тэдгээртэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэсэнээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг биелүүлж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

Дасгал 35.

Ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ЗГ-ын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагджээ. “ХХХ” ХХК нь МУ-ын ЗГ-аас баталгаа гаргуулж Япон улсын “БББ” корпорациас 15 сая ам.доллар зээлж ноолуурын үйлдвэр байгуулжээ. Зээлийн төлбөр дуусаагүй байхад тус компанийн захирал “Г” нь компанийн эзэмшдэг хувьцаагаа өөрийн төрсөн хүүхэд “Б”-дээ шилжүүлэхээр шийдвэрлэжээ. Түүний хүү “Б” нь ... аймгийн ИТХ-ын даргаар ажилладаг.

Асуулт: Энд зөрчил байна уу?

Хариулт: Хуулийн 20.2-т заасан албан тушаалтнууд төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч байж болохгүй, аймгийн ИТХ-ын дарга дээрх албан тушаалтанд хамаарч байгаа тул уг компанийн хувьцаа эзэмшигч байх боломжгүй байна.

Дасгал 36.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд “Я”-ийн төрсөн дүү нь “Б”-ийн “Хар алт” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Уг компани төрөөс баталгаа гаргуулан Японы компаниас их хэмжээний зээл авчээ. “Б”-ийн ахын “Я”-ийн эхнэр уг компанийн 6 хувийн хувьцаа эзэмшигч болов. Энэ талаар эхнэр нь “Я”-д хэлэхэд хуульд заасны дагуу өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч байж болохгүйг сануулжээ.



Асуулт: Та энэ асуудалд ямар дүгнэлт хийх вэ?



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт:

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.

Дасгал 37.

Дээрх явдлаас хойш нэг жилийн дараа “Ө” ажлаасаа чөлөөлөгдсөн байна. Түүний эхнэр дүүгийнх нь компанийн хувьцааг одоо эзэмшиж болохоор болсон тул худалдаж авах гэж байгаагаа хэлсэн байна.



20.4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

Дасгал 38.

Төрийн өмчит компани аюулгүй байдлаа хангахад зориулсан галын хор худалдан авах тендер зарлахад “ФФ” компани шалгарч галын хор нийлүүлэхээр болжээ. Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал “П” “ФФ” компаниас нийлүүлэх гэж буй галын хорын үнийн дүнгийн 10 хувийг өөртөө ашиг болгон авахыг хүсэхэд нийлүүлэгч компани зөвшөөрсөн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалт:

20.5.Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

Дасгал 39.

Иргэн “Б” дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргаар ажиллаж байгаад албан тушаалаасаа чөлөөлөгджээ. “Хайрхан” компани их ашигтай ажиллаж үйл ажиллагаагаа өргөжүүлэх гэж байгаа бөгөөд хөрөнгө оруулж хамтран ажиллахыг санал болгосон. Гэвч “Б” албан тушаалаасаа чөлөөлөгдөөд дөнгөж 1 сар болж байгаа учраас энэ саналыг хүлээн авсангүй. Учир нь “Б” дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа “Хайрхан” компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийж байжээ.

Иймд хуулийн 20.5-д заасны дагуу тэрээр нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа хянах, хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргаж байсан “Хайрхан” компанийн хамтрагч байх боломжгүй юм.

Дасгал 40.

Нэгэн ТӨХК-ийн Хангамжийн албаны дарга “С” нь тус байгууллагын албан хэрэгцээнд зориулж 480 сая төгрөгийн өртөг бүхий сэлбэг, материалыг нээлтэй сонгон шалгаруулалтын аргаар худалдан авах ажлыг зохион байгуулахдаа оролцогчдоос санал болгосон үнийн дүнгээс өөртөө тодорхой ашиг авахыг хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Тухайн бараа материалын нийлүүлэхээр шалгарсан “Н” ХХК түүний саналыг зөвшөөрчээ.

Асуулт: “Н” ХХК нь нээлтэй сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авч шалгарахад Хангамжийн албаны дарга “С” ямар нэгэн нөлөөлөл байгаагүй бол зөрчил мөн үү?

Хариулт: Тухайн сэлбэг, материалын нийлүүлэх тендэрт “Н” ХХК-ийг сонгон шалгаруулахад “С” нөлөөлөл байхгүй хэдий ч нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

6.13 | Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараахь хязгаарлалт

Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа ажил эрхлэхэд ашиг сонирхлын зөрчлөөс улбаалан үүсдэг дараахь эрсдэл байдаг. Үүнд:

- Төрийн алба хашиж байх үедээ ирээдүйд эрхлэх ажлынхаа төлөө албан үүргээ урвуулан ашиглах. Нийтийн албан тушаалтан байсан этгээд нийтийн алба хашиж байх хугацаандаа олж авсан нууц мэдээллийг хувийн ашиг хонжооны төлөө, эсхүл өөр бусад хувь хүн, байгууллагын тусын тулд зүй бусаар ашиглах.
- Нийтийн албан тушаалтан байсан этгээд албан хаагчдад нөлөөлөхийг оролдох. Үүнд төрийн албан хаагч байсан этгээд өмнө нь хамт ажилладаг байсан албан хаагчид, доод ажилтнуудынхаа ажилд нөлөөлөх, эсхүл туслалцаа үзүүлэх замаар тэдэнд дарамт шахалт үзүүлэх зэрэг багтана.
- Тэтгэвэрт гарсан болон цомхотгогдсон албан хаагчдыг дахин ажилд авах. Үүнд: (а) дунд шатны удирдах албан тушаалтан их хэмжээний ажилгүйдлийн тэтгэмж авч, тэтгэмжийн мөнгө авахын сацуу төрийн албаны гүйцэтгэх бус албан тушаалд дахин орж ажиллах; (b) өмнө нь хийдэг байсан ажил үүргээ төрд өндөр үнэ төлбөртэйгээр хийж гүйцэтгэх зөвлөх, эсхүл гэрээт гүйцэггэгч болох зорилгоор төрийн албанаас гарсан төрийн албан хаагчид; (с) бизнес эрхлэхээр шийдсэн төрийн албан тушаалтан тэтгэмжийн мөнгөөрөө өмнөх ажил олгогчийн зарласан ажлын тендерт оролцох зэрэг багтана.

Төрийн албан тушаалтан төрийн албанаас гарсны дараа түүний төрийн байгууллагуудтай тогтоосон холбоо сүлбээг нь ашиглуулахгүй байх үүднээс төрийн салбараас чөлөөлөгдсөний дараах хөдөлмөр эрхлэлттэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм¹⁶.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг

16 ЕАБХАБ, Авлигатай тэмцэх гарын авлага, 2016, 86-р тал

21.1.Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:	21.1.1.урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;
	21.1.2.урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;
	21.1.3.урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

Дасгал 41.

А" Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд зочид буудлын үйлчилгээний тусгай зөвшөөрөл, бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөхөд "Дөрвөлжин" зочид буудлын гүйцэтгэх захирлаар ажиллах санал ирэв. Тэрээр ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн хэл аманд ороос болгоомжилж, яаманд ажиллаж байх үедээ бэлтгэж, боловсруулсан болон гардан хэрэгжүүлсэн шийдвэрүүдийн жагсаалтыг он, сар, өдрөөр нь нэг бүрчлэн нягтлан үзжээ. Түүнчлэн "Дөрвөлжин" зочид буудлын тусгай зөвшөөрөл, гэрээний огноог ч жагсаан гаргав.

Жагсаалтаас харахад "А" нь уг зочид буудалтай холбоотой шийдвэр, үйл ажиллагаанд өмнө нь оролцоогүй байжээ. Тиймээс "А" "Дөрвөлжин өргөө" зочид буудлын гүйцэтгэх захирлаар ажиллахыг зөвшөөрсөн байна.

Асуулт: Уг саналыг хүлээж авсан тохиолдолд "А" хууль зөрчих үү?

Дээр дурдсан хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ (арван зургаан сая¹⁷)-ний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.

Дасгал 42.

“А” яаманд хамт ажиллаж байсан “Д”-ээс зочид буудлын менежментийн талаар зөвлөгөө авах, яамнаас зочид буудлуудад хийх хяналт шалгалтын талаар санал солилцохоор түүнтэй уулзах хүсэлт тавьсан байна.

Байгаль орчны яамны мэргэжилтэн “Д” хэдийгээр “А”-тай хамт ажиллаж байсан боловч цаашид албаны чиг үүргийн дагуу харилцах боломжгүй болж байна.



21.3.Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

Дасгал 43.

“Б” нь “Бүрд” компанид инженерээр ажиллаж байгаад 2017 оны 7 сард Барилгын яаманд мэргэжилтнээр томилогдсон. Тус яамнаас 2018 онд зарласан тендерт “Б”-ийн ажиллаж байсан “Бүрд” компани гүйцэтгэгчээр шалгарсан бөгөөд хэлтсийн дарга нь гэрээ байгуулан ажиллахыг үүрэг болгожээ. “Б”-ийн ажиллаж байгаа хэлтсийн дарга түүнийг урд нь “Бүрд” компанид ажиллаж байсан талаар мэдээгүй бөгөөд “Б” “Бүрд” компанитай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан.

Асуулт: “Б”-ийн үйлдэл хууль зөрчих үү?

21.4.Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

17 Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоол

6.14 | Оффшорын асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт

Өнөөдөр Монгол Улсад оффшорт холбогдох асуудлаар дараахь эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:

2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-аас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 101 дүгээр зүйл (“Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт)-ийг нэмсэн.

Дээрх хуулийн 101 дүгээр зүйлийн 101.4-т заасны дагуу мэдүүлэг гаргагч нь өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд 3 сарын дотор нээлгэсэн банкны дансаа хаалгах, банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээг авч, хөрөнгө, орлогын мэдүүлэгт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлэх үүрэгтэй.

Засгийн газраас 2017 оны 08 дугаар 31-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор оффшор бүсэд хамаарах гадаад улс, нутаг дэвсгэрийн жагсаалтыг баталсан. Гэвч Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолоор оффшор бүсэд хамаарах нийт 49 улс, нутаг дэвсгэрийн жагсаалтыг шинэчилж баталж, өмнөх 244 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон байна.

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралт

**Оффшор бүсэд хамаарах гадаад улс,
түүний нутаг дэвсгэрийн жагсаалт**

Д/д	Нэр (монгол хэлээр)	Нэр (англи хэлээр)
1.	Ангиль	Anguilla
2.	Андоррагийн Хант Улс	Andorra
3.	Антигуа Барбуда	Antigua & Barbuda
4.	Арабын Нэгдсэн Эмират	United Arab Emirates
5.	Аруба	Aruba
6.	Барбадос Улс	Barbados
7.	Бахамын арлууд	Bahamas
8.	Бахрейны Хаант Улс	Bahrain
9.	Белиз Улс	Belize
10.	Бермудын арал	Bermuda
11.	Ботсвана	Botswana
12.	Британийн Виржинийн арлууд	British Virgin Islands
13.	Бруней	Brunei
14.	Бүгд Найрамдах Вануату Улс	Vanuatu
15.	Бүгд Найрамдах Кипр Улс	Cyprus
16.	Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Costa Rica
17.	Бүгд Найрамдах Либериа Улс	Liberia
18.	Бүгд Найрамдах Ливан Улс	Lebanon
19.	Бүгд Найрамдах Мавритан Улс	Mauritius
20.	Бүгд Найрамдах Мальта Улс	Malta
21.	Бүгд Найрамдах Панам Улс	Panama
22.	Бүгд Найрамдах Уругвай Улс	Uruguay
23.	Гернси	Guernsey
24.	Гибралтар	Gibraltar
25.	Гренад Улс	Grenada
26.	Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Dominica
27.	Жерси	Jersey
28.	Ирланд Улс	Ireland
29.	Кайманы арлууд	Cayman Islands
30.	Куракао	Curacao

31.	Куукийн арлууд	Cook Islands
32.	Лихтенштейний Вант Улс	Liechtenstein
33.	Люксембург	Luxembourg
34.	Макао	Macao, SAR
35.	Малайз	Malaysia
36.	Маршаллын арлууд	Marshall Islands
37.	Монако	Monaco
38.	Монтсеррат Улс	Montserrat
39.	Мэний арал	Isle of Man
40.	Нидерландын Антиллийн Арлууд	Netherlands Antilles
41.	Самоагийн Тусгаар улс	Independent State of Samoa
42.	Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс	Seychelles
43.	Сент-Винсент-Гренадин Улс	St. Vincent and Grenadines
44.	Сент-Китс-Невисийн Холбооны Улс	St. Kitts and Nevis
45.	Сент-Люси Улс	St. Lucia
46.	Сингапур	Singapore
47.	Тёркс-кайкосын арлууд	Turks and Caicos Islands
48.	Хонконг	Hong Kong, SAR
49.	Швейцар	Switzerland

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны 91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэл”-ийн маягт”-ыг баталж, Засгийн газраас оффшор бүсэд хамаарах нутаг дэвсгэрийн жагсаалтыг баталсантай холбогдуулж, яам, агентлаг, аймаг, нийслэлийн 108 байгууллага, албан тушаалтанд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлжээ.¹⁸

Дээрх хуулийн 101 дүгээр зүйлийн 101.5-д зааснаар мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг

¹⁸ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2017, УБ 2018, 22-р тал

дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах зэрэгт дээрх оффшорт холбогдох хориглолт нь хамаарахгүй бөгөөд харин албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй.

Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт мэдүүлсэн¹⁹ байна.

19 Авлигатай тэмцэх газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан: <https://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd-41d6-8a42-535892425542/Gazar%20tailan%202018.pdf>

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

7.1 | Хэрэгжилтийг хянах механизм

Авлига бий болох үндсэн суурь шалтгаан бол ноёрхол, хариуцлагын хангалттай механизмгүйгээр үйл ажиллагаа явуулах эрх чөлөө юм.¹

Хувийн ашиг сонирхол нь үеэс үед ажил, албан үүрэг, шийдвэр, үйл ажиллагаатай зөрчилдсөөр ирсэн тул зүй зохистой удирдан зохицуулах нь чухал юм. Албан тушаалтан өөрийн мэргэжил, салбар, байгууллагад даган мөрдөж байгаа ёс зүйн дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж, өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалд эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй. Аливаа дүрэм журам гарснаар асуудал аяндаа шийдвэрлэхгүй. Ашиг сонирхлын зөрчлийн хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангахад дээд зэргээр анхаарах шаардлагатай.

Сонирхлын зөрчлийг шийдвэрлэх аливаа зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараахь бүрдэл хэсгүүд шаардлагатай байдаг.

Олон улсын практикт ашиг сонирхлын асуудлын зохицуулалтыг бүрэн хэмжээнд хариуцан хэрэгжүүлэх орон тооны тусгай ажилтантай байх нь үр

1 НҮБХХ, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар, УБ. 2018, 30-р тал

дүнтэй гэж үздэг бөгөөд тухайн ажилтан дараахь ажил үүргийг хариуцан хэрэгжүүлдэг:

- Хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн тухай өргөдөл, гомдол мэдээлийг хүлээн авах, хариуцах
- Байгууллагын хэмжээнд ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах сургалтыг зохион байгуулах
- Ёс зүй, сонирхлын зөрчлийн асуудлаар заавар, зөвлөгөө өгөх
- Ёс зүйн хүрээний бусад бүрдэл хэсгүүдийг зохицуулах буюу сонирхлын зөрчлийг шийдвэрлэхээс гадна бусад асуудлыг хариуцах²

Мөн өндөр албан тушаалтнуудын хувьд парламентын ёс зүйн зарчмуудыг хэрэгжүүлэхэд хууль тогтоох байгууллагад ёс зүйн байнгын ажилтан ажиллуулбал үр дүнтэй болох нь туршлагаас харагдаж байна. Парламентын аль нэг хороонд хэрэгжилтийг хариуцуулбал ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг зохицуулах үйл ажиллагаа улс төржих, эсхүл улс төрийн сэдэлтэй гэж тооцогдох эрсдэлийг нэмэгдүүлдэг аж.³ Иймд тусгай ажилтан томилох нь үр дүнтэй бөгөөд түүний дүгнэлт шийдвэрт үндэслэж парламентын хороо шийдвэр гаргах зохион байгуулалтын арга хэмжээ байж болно. Үүнийг батлах сайн жишээ бол Их Британийн Дээд танхимын загвар юм. Тэнд Стандартын комиссар⁴ ажилладаг ба дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

- Гишүүдийн ашиг сонирхлын бүртгэлийг хянах;
- Парламентын гишүүдэд болон Стандарт, эрх дархын асуудлаарх сонгох хороонд Ёс зүйн дүрэм болон Гишүүдийн зан үйлийн дүрмийн талаар зохих нууцлалтайгаар зөвлөгөө өгөх;
- Заавар бэлтгэх, гишүүдэд сургалт явуулах;
- Ёс зүйн дүрмийн үйл ажиллагааг хянах, шаардлагатай бол дүрэмд оруулах өөрчлөлтийг санал болгох;
- Ёс зүйн дүрмийн зөрчлийн талаар гомдол хүлээн авах, хянан шалгах ажиллагаа явуулах, Хороонд мэдээлэх тайлагнах.

Үүний дараа Сонгох хорооноос зөрчил гаргасан гишүүнд шийтгэл оногдуулах зэрэг шийдвэр гаргах арга хэмжээ авдаг.

2 2004 оны Германы Холбооны Засгийн газрын Авлигаас сэргийлэх зааварчилгаа: <http://www.u4.no/document/showdoc.cfm?id=45>

3 Энэхтэгийн жишээ <http://www.tribuneindia.com/2005/20051224/main1.htm>

4 http://www.parliament.uk/about_commons/pdfs.cfm

ЕАБХАБ-ын оролцогч улсуудын эрх зүйн бүтэц, уламжлалаас шалтгаалан хөрөнгө, орлогын болон ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах байгууллагууд нь хэлбэр, хэв загвар, дотоод, гадаад хяналтын бүтцээрээ харилцан адилгүй байдаг. Дотоод хяналтын механизмын хувьд зарим улс орны (Герман, Швед, Швейцар, Норвеги) төрийн албан тушаалтнууд өөрийн шууд удирдлагадаа төрд эрхлэх мэргэжлийн албан тушаалаас гадуурх нийтийн болон цалинтай үйл ажиллагааны талаар мэдүүлэх шаардлагатай байдаг. Түүнчлэн хууль тогтоох байгууллага нь (Герман, Ирланд, Испани, НВУ) парламентын гишүүд болон парламентын ажилтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянахад дотоод хяналтын механизмыг ашигладаг байна. Үүнээс гадна гадаад хяналтын механизмыг ч мөн ашигладаг. ЕАБХАБ-ын зарим оролцогч улс (Албани, Монтенегро, Румын, Серб, Словени) оронд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авлигаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл гэж үздэг тул эдгээр улсын авлигатай тэмцэх тусгай байгууллага нь албан тушаалтнуудын мэдүүлэгт хяналт тавьдаг байна⁵.

Монгол Улсын хувьд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээдийг тодорхойлсон болно.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаарх Авлигатай тэмцэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар хянана.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

28 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд

28.1. Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:

28.1.1. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаарх Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг **Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;**

28.1.2. энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг **Авлигатай тэмцэх газар.**

5 ЕАБХАБ, Авлигатай тэмцэх гарын авлага, 2016, 89-р тал

Дээрх хуулийн 26 дугаар зүйлд Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгах харилцааг дараахь байдлаар зохицуулсан байна.

Авлигатай тэмцэх газар хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо шалгана. Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.

Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо шалгана.

Нийтийн албаны ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт олон мянган албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдлийг хариуцан ажиллахад хүргэдэг. Иймд байгууллага, албан тушаалтан нь хангалттай нөөц, чадавхтай байх ёстой. Энэ асуудлаарх сөрөг жишээг Өмнөд Африкт, 2004 оны Төрийн албаны хорооны тайлангаас иш татаж болно. 4300 орчим төрийн албан тушаалтны санхүүгийн мэдүүлгийг хүлээн авах, шалгах ажлыг зөвхөн нэг хүн хариуцаж байсан байна.⁶

6 Өмнөд Африкийн Ардчилалын төлөө Институт, "Апартейдийн дараах Өмнөд Африк дах Засгийн газрын ёс зүй: 2003", http://www.idasa.org.za/index.asp?page=output_details.asp%-3FRID%3D94%26TID%3D1%26OTID%3D2

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх хадгалах журам”-ын 3.1-д “нийтийн албаны удирдлага нь тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албаны эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг тушаал, шийдвэрээр хариуцуулан томилж, түүнд албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно” гэж тусгасан.

Эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах бөгөөд нууцын баталгаа гаргана. Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан хугацаанд мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

Мэдүүлгийг бүртгэж хүлээн авч байгаа эрх бүхий албан тушаалтан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй;
- Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч, бүртгэл хөтлөх бөгөөд хянан шалгах, авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт нэн даруй шилжүүлэх;
- Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.2 дахь заалт, 8.2, 23.3, 23.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 10.3, 10.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу батлагдсан маягтаар бүртгэл хөтлөх;

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан тохиолдолд бүртгэл, хяналт явуулж Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ. Мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий албан тушаалтан авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлийн талаар Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй.

Мэдэгдэл, тайлбарын хувьд дараахь зохицуулалт үйлчилж байна:

Нийтийн албан тушаалтан

- ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ба зохицуулах шийдвэрт хүрнэ.
- ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй талаар шууд удирдлагадаа бичгээр мэдэгдэнэ.
- Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий **байгууллага, албан тушаалтан**

- тухайн **албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг** нэн даруй бичгээр гаргана.
- Дараах тохиолдолд албан тушаалтныг **албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч** болно:
 - - тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
 - - тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.
- тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

7.2 | Зөрчилд хүлээлгэх хариуцлага

Хэрэгжилттэй холбоотой бас нэг асуудал бол ашиг сонирхлын **зөрчилд дүйх арга хэмжээг** авах явдал байдаг. Тухайлбал, хуулийн үүрэг үү, эсхүл гэрээний үүрэг үү гэдгийг харгалзах нь зүйтэй. Хуулийн дагуу бол эрүү, иргэн, захиргааны хуулийн аль тохирох шийтгэлийг онооно (АНУ-д ашиг сонирхлын мэдүүлгээ өгөөгүй бол Эрүүгийн хуулиар шийдвэрлэдэг).

Хууль тогтоогчдын ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг дотоодын зохицуулалтаар голчлон хийдэг ба зөрчил гаргагчид оногдуулах хэд хэдэн хэлбэрийн шийтгэлээр хязгаарлагддаг. Хамгийн хатуу шийтгэл нь хууль тогтоогчийн эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлдэг. Харин АНУ-ын Төлөөлөгчдийн танхим онцгой шийтгэл оногдуулдаг. Конгрессийн хороо нь мэдээлэл өгөхөөс санаатайгаар зайлсхийх, эсхүл худал мэдээлэл өгсөн бол 11000 ам.доллар хүртэл торгох эрхтэй ба эдгээр нь мөн эрүүгийн хэрэгт тооцогдох ба 11000 ам.долларын торгууль, эсхүл тав хүртэл жил хорих ял оногдуулдаг.⁷

Их Британид Сайд нарын Зан үйлийн дүрэм⁸ нь дараахь заалтыг агуулсан байдаг:

- Сайд нар өөрийн сонирхлын жагсаалтыг түүний дотор санхүүгийн сонирхлын жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргад өгөх ёстой. Энэхүү жагсаалтыг хэлэлцэж, аль нэг сонирхлоосоо татгалзах эсэх талаар шаардлагатай бол бусад засгийн газрын байгууллагын зөвлөгөөг авсны үндсэн дээр Сайд шийдвэр гаргана.
- Сайд нар нь хувийн сонирхлоосоо татгалзах, эсхүл Кабинетийн гишүүддээ мэдээлэх, тухайн асуудалд оролцохоос татгалзах замаар өөрийн хувийн сонирхол ба сайдын албан тушаалын хооронд илэрхий болон бодит сонирхлын зөрчил гарах эрсдлээс ухамсартайгаар зайлсхийх ёстой.
- Сайдын мөнгөн сонирхол бүхий асуудалд хамаатай түүний хууль ёсны эрх мэдэл, нөлөөллийн үйлдэл, эс үйлдэхүй шүүхэд нэхэмжилж болох бөгөөд хэрвээ нэхэмжлэл хангагдвал тухайн үйлдэл, эс үйлдэхүйг хүчингүйд тооцож болно гэж Дүрэмд заасан байдаг.

7 <http://ethics.house.gov/Subjects/Topics.aspx?Section>

8 http://www.cabinetoffice.gov.uk/~-/media/assets/www.cabinetoffice.gov.uk/propriety_and_ethics/ministerial_code%20pdf.ashx

Их Британийн хуулийн нэг хүндрэл нь сайд нар сонирхлоо олон нийтэд ил мэдүүлэх үүрэг байхгүйтэй холбоотой. Хэрвээ ийм заалттай байсан бол Их Британийн энэ загвар сайн загвар юм.

Зарим улс орны эрүүгийн хариуцлага: Латвид улсын ашиг сонирхолд ноцтой хохирол учруулсан ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэрэгт 5 хүртэлх жил хорих ял оноодог. Польшид орон нутгийн төрийн албан хаагч ашиг сонирхлоо худал мэдүүлбэл 3 хүртэлх жил хорих ялаар шийтгүүлдэг. Италид ашиг сонирхлоо мэдүүлээгүй, эсхүл худал мэдүүлсэн бол 5 хүртэлх жил хорих ба дээр нь 75000 Еврогийн торгууль оноох зохицуулалттай.

Францад ажлаас гарсны дараахь хориглолт, хязгаарлалтыг зөрчвөл 2 хүртэл жил хорих ял оноож, 30000 еврогийн торгууль оноогдуулдаг.

Унгарт ихэвчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг анхаардаг ба Латви, Польшоос ялгаатай нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн шийтгэл оногдуулдаггүй байна. Харин сахилгын шийтгэийн хувьд Их Британид Парламентын гишүүд ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл хэсэг хугацаагаар цалинг нь зогсоодог. Польшид орон нутгийн түвшинд сонгогдсон албан тушаалтнуудад мөн адил цалинг нь хэсэг хугацаанд зогсоох шийтгэл ногдуулдаг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Уг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага буюу шүүгчийн хүлээлгэх захиргааны хариуцлагын хэлбэр, хэмжээг заасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	
ШҮҮГЧ	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
дараах	
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГА	САХИЛГЫН ШИЙТГЭЛ
хүлээлгэнэ:	
Албан тушаалтныг торгох	сануулах

хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх	албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах
байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох	албан тушаалыг нь бууруулах
эрх бүхий албан тушаалтныг торгох	нийтийн албанаас халах

Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

Авлигын эсрэг хуульд албан тушаалаас нь бууруулах, бууруулах боломжгүй, төрийн албаны хамгийн доод албан тушаал хашиж байгаа, эсхүл сонгогддог албан тушаалтан бол цалинг нь 3 сарын хугацаатайгаар 30 хүртэл хувиар бууруулах, энэ үйлдлээ дахин гаргасан бол төрийн албанаас халах хариуцлагыг тусгасан болно.

Авлигын эсрэг хуульд албан тушаалтан 6 сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыг буюу ямар арга замаар олсноо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзэхээр тусгасан бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид “Хууль бусаар хөрөнгөжих” гэсэн зүйл шинээр оруулсан, өөрөөр хэлбэл, хууль бусаар хөрөнгөжсөн бол эрүүгийн хариуцлага хүлээх юм.

Дээрх хуульд заасан сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ноогдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх үүргийг хүлээлгэсэн бөгөөд албан тушаалтан өөртноогдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг Авлигатай тэмцэх газар баталсан⁹.

9 <https://www.legalinfo.mn/law/details/13777>

НАЙМДУГААР БҮЛЭГ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА, САНААЧИЛГА

8.1 | Олон улсын сайн туршлага, санаачилга

Улс орнуудад сонирхлын зөрчлийн зохицуулалт хийдэг үндсэн хоёр загвар байна. Эхнийх нь хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд суурилсан ёс зүйн хэм хэмжээ буюу нийцлийн хандлага. Энэ загварын хувьд ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох дүрэм журмыг боловсруулж албан хаагчид дагаж мөрддөг. Гол гурван элементэд нь урьдчилан сэргийлэх, илрүүлэх, дагаж мөрдөөгүй тохиолдолд шийтгэх арга хэмжээ багтдаг. Ийм загварыг Сингапур, Өмнөд Солонгос, Япон зэрэг улсууд хэрэгжүүлж амжилтад хүрчээ.

Нөгөө загвар нь шударга байдалд суурилсан ёс зүйн хэм хэмжээ буюу зарчимд тулгуурласан хандлага. Энэ загварын хувьд хууль бус үйлдлийг хориглосон дүрмийг агуулдаг боловч зайлсхийх хэрэгтэй зан үйлээс илүүтэйгээр зохих ёсоор хэрэгжүүлэх ёстой үйлдэл буюу үр дүнд анхаарлаа төвлөрүүлдэг. Зарчимд буюу шударга байдалд суурилсан зохицуулалтыг Канад, Австрали, Норвеги зэрэг улсууд хэрэгжүүлж амжилтад хүрч байна. Ийм зохицуулалтын ач холбогдол нь авлигыг санал болгох явдлыг бууруулах хамтын соёл бий болгох явдал юм.

Төрийн байгууллагууд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах дүрэм журам¹ батлан мөрдүүлж тухайн байгууллагуудад шударга байдлыг баталгаажуулахыг зорьсон байдаг.

Ашиг сонирхлын зөрчлийн асуудалтай холбоотой зарим нэг улс орны туршлагаас танилцуулбал:

БНСУ: Улс төр, эдийн засгийн үйл ажиллагааны хүрээ тэлэх тусам нийтийн алба, хувийн салбар хоёрын харилцан хамаарал улам нягтарч, нийтийн болон хувийн ашиг сонирхол зөрчилдөх нь тухайн улсад ч мөн ихэсч байна.

Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиулах зорилгоор төрийн албан хаагчийг дараахь нөхцөл байдлаар хянана:

- төрийн албанд орохоос өмнөх үе (хөрөнгө, орлогын мэдүүлэг, санхүүгийн бие даасан байдлын талаар судлаж тогтоох, хянах),
- төрийн албанд ажиллаж байгаа хугацаа (хөрөнгө, орлогын мэдүүлэг авч, хянах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх),
- төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа (үйл ажиллагааг нь хязгаарлах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох).

БНСУ-д Нийтийн албан хаагчийн ёс зүйг сахиулахад “Нийтийн албаны үйл ажиллагааг явуулах хэм хэмжээ” (PSEA, 1981.12.01), АСА (2001 он), ISGA (2015 он) зэргийг удирдлага болгож байна. “Нийтийн албаны үйл ажиллагааг явуулах хэм хэмжээний тухай хууль”, 1980 онд батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-д төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын бүртгэл, төрийн албанаас чөлөөлөгдсөн, эсхүл тэтгэвэрт гарсны дараахь хязгаарлалт, ажиглалт, хяналтын талаар зохицуулалтыг нарийвчлан заажээ.

Уг хоёр хуулийг 1980-1988 онд төр улсыг удирдаж байсан Ерөнхийлөгч Чун До-Ваны байгуулсан Зохицуулах Хорооноос баталсан юм. “Нийтийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн тухай хууль”-ийг 1978 онд батлагдсан АНУ-ын Төрийн албаны ёс зүйн хууль (EIGA: Public Law 95-521)-ын заалтуудад тулгуурлан боловсруулсан гэдэг. Эдгээр хуулийн заалтын дагуу төрийн алба болон төрийн өмчит компаниас чөлөөлөгдсөн албан хаагчийг чөлөөлөгдөхөөс нь өмнөх сүүлийн хоёр жилийн хугацаанд хашиж байсан албан тушаалынх нь үүрэг хариуцлагатай холбоотой байсан бөгөөд 10 тэрбум вон, эсхүл түүнээс дээш хэмжээний хөрөнгөтэй, 30 тэрбум вон, эсхүл түүнээс дээш хэмжээний борлуулалтын эргэлттэй ашгийн байгууллагад ажиллахыг 2 жилээр хориглоно.

1 <https://www.staff.lu.se/employment/terms-of-employment/secondary-employment>

Авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлж, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор 2016 оны 2 дугаар сараас хязгаарлалтыг дараахь байдлаар өөрчилсөн байна:

- албанаас чөлөөлөгдөхөөс өмнөх хугацааг сүүлийн таван жил, харин чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацааг 3 жил болгосны зэрэгцээ ашгийн байгууллагын хөрөнгийн хэмжээг 1 тэрбум вон болон түүнээс дээш, борлуулалтын эргэлт нь 10 тэрбум вон болон түүнээс дээш байх;
- хууль, санхүү, татварын фирм, нийтийн худалдаа, эм ханган нийлүүлэх болон нийгмийн эрүүл мэндийн корпорацид ажиллахыг хориглох.

Сингапур Улс: Нийтийн албан тушаалтны зан үйлийг зохицуулахын тулд хатуу дүрэм, журам тогтоодог. Нийтийн албан тушаалтан нь албаны үүрэгтээ өндөр ёс зүйтэй хандаж дараахь стандартыг мөрдөнө. Үүнд:

- ажил хэргийн харилцаатай этгээдээс мөнгө зээлэхгүй байх;
- төлөөгүй өр, төлбөр нь сарын цалингаас 3 дахин их байж болохгүй;
- хувийн ашиг сонирхлын үүднээс албаны мэдээллийг ашиглахгүй байх;
- анх албан тушаалд томилогдсон үеийн болон түүнээс хойших жил бүр хөрөнгө, орлогын мэдүүлгээ зарлаж байх;
- зөвшөөрөлгүйгээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, хагас цагаар ажиллахгүй байх².

Хонг Конг: Авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчин харьцангуй цогц юм. Хээл хахуулиас гадна 3 зүйлийг авлигын гэмт хэрэг гэж тусгаж өгсөн. Үүнд:

- Албан үүрэгтэй нь холбоотой болон холбоогүй байдлаар төрийн албан хаагч заагдсан хэмжээнээс хэтэрсэн үнэ бүхий бэлэг, зээл, хямдрал, үйлчилгээ авсан бол гэмт хэрэг гэж үздэг.
- Төрийн албан хаагч өөрийн бодит орлогын түвшинтэй харьцуулагдахааргүй хөрөнгөтэй, эсхүл түүнээс дээгүүр түвшинд амьдарч байвал түүнийг гэмт хэрэг гэж үздэг.

- Сонирхлын зөрчлийг гэмт хэрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан өөртөө, эсхүл бусад хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгож байгаа бол гэмт хэрэг гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд төрийн албан хаагч зайлшгүй урьдчилан мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Хувийн хэвшил дэх авлигыг онцгойлон авч үздэг улс бол Хонконг юм. Хувийн хэвшил ажиллаж байгаа ажилтнууд нийгмийн өмнө хариуцлага хүлээж, ёс зүйн хэм хэмжээг төрийн албан хаагчтай адил баримтлах ёстойг гэсэн зарчимд тулгуурладаг. Хувийн хэвшил дэх авлигатай үр дүнтэй тэмцэх нь бизнесийн орчинг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтын орчинг нэмэгдүүлэх үндэс болдог.

Япон Улс: Төрийн албаны ёс зүйн хууль³-ийг 1999 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 129 дүгээр хуулиар баталсан. Ёс зүйн хуулийн төслийг анх төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон хэд хэдэн авлигын гэмт хэрэг илэрсний дараа парламентын гишүүдээс боловсруулж өргөн барьсан бөгөөд хуулийг баталсан явдал нь төрийн албан тушаалтнуудын ёс зүйн асуудал нь олон нийтийн анхаарал, шүүмжлэлд өртсөний илэрхийлэл болсон.

Энэхүү хуулийн үндсэн зорилго нь нийтийн албан тушаалтнуудаас чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээг засгийн газрын түвшинд тогтоох эрх зүйн үндсийг бий болгоход оршиж байв. Тиймээс Засгийн газрын 2000 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 101 дүгээр шийдвэрээр “Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэм”-ийг батлан гаргасан байна. Энэхүү дүрэмд нийтийн албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан зохицуулсан.

Ёс зүйн дүрэмд зааснаар нийтийн албан тушаалтнуудыг албан үүрэгтэйгээ холбоотой этгээдээс мөнгө, эд зүйл, үл хөдлөх хөрөнгийг бэлэг хэлбэрээр авах, тэднээс мөнгө зээлэх, тэднээс үнэ төлбөргүйгээр болон тэднээр төлбөрийг нь хийлгэж эд зүйл, үл хөдлөх хөрөнгө зээлээр авах, түрээслэх, тэднээс үнэ төлбөргүй болон тэднээр төлбөрийг нь хийлгэж аливаа үйлчилгээ авах, хийлгэх, тэднээс хувьцаа авах, тэдний зохион байгуулсан болон төлбөрийг нь төлсөн аливаа соёлын болон зугаа цэнгээний арга хэмжээнд оролцох, зугаацах,

ийм төрлийн үйлчилгээ авах, гольф хамт тоглох, хамт аялах, зорчих (нийтийн албаны үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд, тэрхүү зорилгоор хамт аялах, зорчих хамаарахгүй), түүнчлэн эдгээр үйл ажиллагааг нөхцөлдүүлэх байдалд тэднийг хүргэх зэргийг хориглосон байна.

Эдгээрээс гадна нийгэмд хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд зохицохооргүй байдлаар албан тушаалын бүрэн эрх, чиг үүрэгтэйгээ холбоогүй этгээдтэй хамт, мөн тэдний мөнгөөр зугаацахыг хориглосон байна. Төрийн албаны ёс зүйн хуулийн дагуу Төрийн албаны ёс зүйн зөвлөл нь 1999 онд байгуулагдсан. Ёс зүйн зөвлөл нь Ерөнхийлөгч болон 4 гишүүнээс бүрддэг. Бүх гишүүдийг Засгийн газраас томилдог. Зөвлөл нь 15 орчим хүний бүрэлдэхүүнтэй ажлын албатай ба ажлын албыг ерөнхий нарийн бичгийн дарга удирддаг.

Ёс зүйн зөвлөл нь Ёс зүйн дүрмийн агуулга болон түүнд оруулах өөрчлөлтийн талаар Засгийн газарт хүргүүлэх зөвлөмжийг боловсруулах, нийтийн албан тушаалтны ёс зүйг сахиулах асуудлаар хийгдэх сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, уялдуулан зохицуулах, нийтийн албаны ёс зүйн хууль зөрчсөн асуудлыг мөрдөн шалгах үндсэн чиг үүрэгтэй.

Ёс зүйн зөвлөлөөс жил бүр олон тооны сургалт, семинарыг Японы томоохон хот болгонд зохиодог бөгөөд яам, төрийн бусад байгууллагуудаас зохион байгуулдаг ёс зүйн чиглэлийн сургалт, семинарт зориулж сургалтын гарын авлага боловсруулдаг.

Их Британид ашиг сонирхлын зөрчлийг ёс зүйн асуудал гэж үзэх хандлагатай. Орлого, өмч хөрөнгөө мэдүүлэхийг шаардсан ерөнхий шаардлага байхгүй. Үүний гол үзэл санаа нь өндөр албан тушаалд очиж байгаа хувь этгээд өөрөө санхүүгийн болон бусад ашиг сонирхлоо мэдүүлэх ёстой гэж үздэг. Англи улсын хувьд⁴ Авлигын эсрэг хууль тогтоомж 1889 оноос (төрийн албан дахь хахууль) үүдэлтэй бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 1906, 1916 онд, улмаар 1967 онд Эрүүгийн хуульд тусгах хэлбэрээр хэм хэмжээг баталж байсан. Ашиг сонирхлын зөрчлийн хувьд тусгайлсан хууль байхгүй бөгөөд Төрийн болон нийгмийн амьдралын ёс хэм хэмжээний стандартын талаар Хороо 1994 онд байгуулагдсан аж.

4 <http://www.jk.ru/jur-polesno.html>

Уг хорооноос 1995 онд төрийн албан хаагчдын хэм хэмжээний чиглэлээр 7 зөвлөмж боловсруулсан.

Үүнд: Нийгмийн эрх ашгийн төлөө ажиллах, гадны санхүүгийн эсхүл бусад нөлөөнд автахгүй байх, шийдвэр гаргахад аль нэг талыг барихгүй, хариуцлагатай, шударга, манлайлах зэрэг юм. Хувийн орлогоо зайлшгүй мэдүүлэх шаадрлага байхгүй. Улс төрийн албан тушаалтан, засгийн газрын гишүүд бэлгийг мэдүүлэх ёстой бөгөөд цалингийн хэмжээнээс 1 хувиас дээш гарсан үнэ бүхий бэлгийг мэдүүлдэг байна. Шотланд, Уэльс болон Хойд Ирландын парламентын гишүүд ашиг сонирхлоо мэдүүлээгүй нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай. Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх дүрэм журам, хууль байхгүй бөгөөд зөвхөн төрийн албаны ёс зүйн хэм хэмжээний зарчим үйлчилдэг. Английн системийн хувьд төрийн албан тушаал хашиж буй хүн бүр санхүүгийн болон санхүүгийн бус сонирхлоо мэдүүлэх ёстой, хувийн хариуцлага болон ил тод байдал нь гол үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг.

АНУ-ын⁵ авлигын эсрэг хууль тогтоомж маш чанга. Хахуулийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэн хэмжээний торгууль ногдуулах, 15 жил хорих ял, хүндрүүлсэн нөхцөлд 20 хүртэлх жил хорих гэх мэт авлигын гэмт хэрэгт шийтгэл хүлээлгэдэг. АНУ-ын авлигын эсрэг хууль тогтоомж нь системийн шинж чанартай байдаг бөгөөд лобби⁶, банкны болон биржийн бүхий л үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Өөр нэг онцлог нь ямарч албан тушаалтан ерөнхийлөгч, сенатор, конгрессийн гишүүн хэн боловч авлигын гэмт хэрэгт холбогдоход эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг. АНУ-ын Конгрессийн захирамж хэлбэрээр анх 1958 онд төрийн албан дахь хэм хэмжээний журам гарч байжээ. Энэхүү журмыг өргөжүүлэн 1962 онд АНУ-ын Конгресс сонгогдсон болон төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээ, 1965 онд төрийн албан хаагчдын ёс зүйн стандартуудыг тогтоож байсан бөгөөд эдгээр журмууд нь 1978 оноос төрийн албаны ёс зүй болж батлагдсан.

5 www.calstate.edu/gc/docs/conflict_of_interest_handbook.doc

6 “Аливаа нэг шийдвэрийг өөрт ашигтайгаар гаргуулах, эсвэл эсэргүйцэх зорилгоор төрийн захиргааны албаны болон сонгууль ажилтнуудад нөлөөлөх оролдлого”, Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг., Ц.Даваадулам., 2010

АНУ-ын Конгресс 1989 онд Ёс зүйн хуулийн шинэчлэн баталж төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг тусгасан нэлээд өөрчлөлтийг оруулан холбооны хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн бүх байгууллагуудад нэвтрүүлсэн байна.

АНУ-ын Ерөнхийлөгчийн №12731 тоот “Төрийн албаны албан тушаалтны болон албан хаагчийн хэм хэмжээний зарчим” хуулийг 1990 онд баталсан байна. Эдгээр зарчмууд төрийн өндөр албан тушаалтан төдийгүй бага тушаалын төрийн албан хаагчдад хүртэл хамаардаг. Бэлэг сэлт авах (хуанлийн жилийн дотор 100 ам. доллараас хэтэрсэн бэлэг хувь хүн, хуулийн этгэдээс авахыг хориглосон), төрийн худалдан авалтын талаархи мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, иймэрхүү төрлийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцох, өөрийн үндсэн ажлаас гадуур ажил эрхлэх нөхцөлд цалингийн 15 хувиас хэтрэхгүй байх, төрийн албанаас гарсан нөхцөлд төрийн албанд хэрэгжүүлж байсан чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг 2 жилийн турш эрхлэхийг хориглох, хувь хүнээр томилолтын зардлаа (өөрийн болон гэр бүлийн гишүүдийн) санхүүжүүлэх, үүнд улс дотроо 3 өдөр (2 шөнө), гадаадад 7 хоног (6 өдөр) гэх мэт бүхий л харилцааг зохицуулж өгсөн байна. Эдгээрийн хэрэгжилтийг хянах комиссууд байхаар тусгасан ба комисс бүх төрлийн мэдээллийг шаардан гаргуулж авах, албан хаагчдаас тайлбар авах, албаны шалгах ажиллагааг явуулах зэрэг эрх хэмжээг хэрэгжүүлж, албан хаагч буруутай нь нотлогдсон нөхцөлд ажлаас халах, албан тушаал бууруулах зэрэг арга хэмжээ авдаг.

Америкийн хууль эрхзүйн тогтолцоо нь барууны бусад орнуудын нэгэн адил үнэт цаас болон бусад санхүүгийн эргэлтийн хөрөнгө эзэмшдэг төрийн албан хаагчдад зориулсан “сохор итгэл”-ийн тухай ойлголтыг багтаадаг. Үүгээр тэдэнд үнэт цаас болон бусад санхүүгийн эргэлтийн хөрөнгө зохицуулах, хянахыг хориглодог, учир нь тэд өөрийн хөрөнгө хадгалагддаг компанийг хянаж шалгах, удирдах, зохицуулах болж болох юм. Энэ нь ажилд орох үед байсан ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж түүнийг болзошгүй сонирхлын зөрчлийн эх үүсвэр болгож байгаа юм. “Мэргэжлийн сохор итгэл”-ийг АНУ-ын төрийн ёс зүйн албанаас зөвшөөрсөн ба тухайн эзэмшигчийн үнэт цаас болон бусад активыг түүнд нэр нь тодорхойгүй мэргэжилтнүүд зохицуулдаг. “Сохор итгэл”-ээс ашиг хүртэгч нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж чадахгүй, хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломжгүй, харин жилд нэг удаа ашиг, алдагдлын талаар тайланг хүлээж авдаг.

Европын холбооны улсууд

Европын холбооны албан хаагчдын хувьд эхнэр (нөхөр)-ийнх нь мэргэжлийн үйл ажиллагааг ч анхааралдаа авдаг. Төрийн ажил эрхлэлтийн 13-р зүйлд “хэрэв эхнэр (нөхөр) нь цалин орлоготой мэргэжлийн үйл ажиллагаа явуулбал, уг нийтийн албан тушаалтан байгууллагад томилох эрх бүхий албан тушаалтанд энэ талаараа мэдүүлэх хэрэгтэй. Хэрэв тэдний эрхэлж буй үйл ажиллагаа нь нийтийн албан тушаалтны ажил үүрэгтэй үл зохицох/үл нийцэхээр бөгөөд эхнэр (нөхөр)-ийнхээ ажлыг тодорхой хугацаанд дуусна гэдгийг баталгаажуулж чадахгүй бол томилох эрх бүхий албан тушаалтан Хамтарсан хорооны шийдвэрийг харгалзан уг албан тушаалтныг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, эсхүл өөр ажилд шилжүүлэхийг шийддэг.

Унгар Улсын⁷ хувьд төрийн өндөр албан тушаалтан буюу парламентын гишүүд орлого, бэлэг сэлтээ, мэдүүлэх үүрэгтэй. Нийтийн албан тушаалтан гэр бүлийнх нь сонирхолтой холбоотой үйл ажиллагааг хянадаг, мониторинг хийдэг тохиолдолд тухайн салбарт ажил үүрэг гүйцэтгэхийг хориглодог. Унгар, Францад орон нутгийн түвшинд сонгогдсон албан тушаалтнууд үндэсний парламентын гишүүн байж болдог. Хотын захирагч нь парламентын гишүүнээр сонгогдож болно. Унгар, Польш, Их Британид ахлах албан тушаалтнууд улс төрийн намд албан тушаалтай байхыг хориглодог.

ХБНГУ⁸ Давхар ажил эрхлэлтийг бусад европын орнуудтай харьцуулахад нэлээд чанга зохицуулсан байдаг бөгөөд хувийн орлогыг зайлшгүй мэдүүлэх шаардлагагүй. Парламентын гишүүд 5000 еврогоос дээш гарсан үнэ бүхий бэлгийг мэдүүлдэг.

7 <http://www.oecd.org/dataoecd/12/32/39577476.pdf>

8 Мөн тэнд

Испанид парламентын гишүүд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад албан тушаал давхар хашихыг хориглодог. Төрийн өндөр албан тушаалтан өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, материаллаг эд баялаг, хөрөнгөө анх албан тушаалд томилогдохдоо, жил бүр, мөн төрийн албанаас чөлөөлөгдөхдөө мэдүүлдэг. Түүнчлэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхөөр бол төлөвлөж буй хувийн үйл ажиллагааныхаа талаараа мөн мэдүүлдэг. Мөн шинээр албан тушаалд томилогдож буй хувь этгээд өмнөх ажлуудынхаа талаар мэдүүлдэг. Энэ шаардлага нь түүний эхнэр (нөхөр), албан тушаалд томилогдохоос өмнө хоёр жил хамтран амьдарсан этгээд, хоёр дахь үеийн төрөл садан (ах, эгч гэх мэт) зэрэгт нь мөн хамаатай. Испани⁹ улсын хувьд давхар ажил эрхлэлтийг бусад европын орнуудтай харьцуулахад нэлээд чанга зохицуулсан байдаг бөгөөд Парламентын гишүүд сонгогдсон албан тушаалаас гадна хувийн албан тушаал хашихыг хориглодог. Төрийн худалдан авалттай холбоотой ашиг сонирхлоо тухайн албан тушаалд томилогдохоосоо өмнөх болон албан тушаалаас чөлөөлөгдснөөс хойших 2 жилийн хугацааг хамруулан мэдүүлдэг. Тус улсын хувьд төрийн албаны хэм хэмжээ, ёс зүйтэй холбоотой ямарч хуульгүй байсан нь нэлээд шүүмжлэлд өртөж 2005 онд Сайн засгийн газрын тухай хуулийг санаачилсан байна. Хуульд төрийн алба хашиж байхад өөр албан тушаал давхар хашихыг хатуу хориглосон ба төрийн сектортой гэрээ хэлэлцээр хийж буй хувийн компанийн 10-аас дээш хувийн хувьцааг худалдан авахгүй байх гэх мэт заалтууд орсон байна. Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хүлээн авч буй байгууллага нь Төрийн захиргааны яамны хяналтын алба байхаар заасан.

Австри Улс: Албан ёсны арга хэмжээний зардалтай холбоотой хязгаарлалт Албан ёсны арга хэмжээний зардал гэдэгт бэлэг дурсгал, замын зардал, хоолны зардал, үзвэр, үйлчилгээний зардал болон бусад үйл ажиллагааны зардлыг хамааруулан ойлгодог. Эрүүгийн хуульд эдгээр зардалд тавигдах хэмжээ хязгаарыг тодорхой зааж өгөөгүй бөгөөд нийтийн албан тушаалтанд албаны чиг үүргээ гүйцэтгэхэд нь хууль бусаар нөлөөлөх шинж чанаргүй байхыг шаарддаг.

Нийтийн албан тушаалтанд зориулан зарцуулах зардал нь авлигын шинж чанар агуулсан эсэхийг тодорхойлох дараахь шалгуурууд байж болно гэжээ.

Үүнд:

- Нийтийн албан тушаалтан өөртөө зориулан тодорхой зардал гаргахыг идэвхтэй байдлаар шаардвал тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэнэ.
- Тухайн зардал нь үнийн хувьд бага бөгөөд орон нутгийн зан заншилтай холбоотой бол зөвшөөрч болохоор заасан байна. Тодорхой тохиолдлууд дээр гаргасан шийдвэрээс үзвэл 100 еврогоос дээшгүй хэмжээний зардлыг орон нутгийн зан заншилтай холбоотойгоор зарцуулсан бол тухайн нийтийн албан тушаалтанд нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Ийм зардлын жишээнд Зул сарын баярын бэлэг, төрсөн өдрийн цэцэг, лекцийн дараах хоолны зардал зэргийг дурджээ.

Франц¹⁰ Европын холбоонд шинээр орсон орнуудтай харьцуулахад Авлигын эсрэг өргөн хүрээний стратеги байхгүй хэдий ч “хууль бусаар сонирхол хайх” хэмээн томъёолон эрүүгийн гэмт хэрэгт тооцсон зүйл нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой аж. Бэлэг сэлтийг өртгөөс үл хамааран парламентын гишүүд мэдүүлэх ёстой. Хувийн компаниуд улсын салбартай гэрээ хэлцэл хийсэн, эсхүүл төрийн албан тушаалтан хянадаг, зохицуулдаг нөхцөлд уг хувийн компанийн өмчлөх эрхийг эзэмшихийг хориглох заалтуудтай.

Ашиг сонирхлын зөрчлөө мэдүүлээгүй нөхцөлд 5 хүртэлх жилийн хорих ял ноогдуулах болон 75000 еврогын торгуульноогдуулах шийтгэлтэй. Мөн төрийн албан тушаалаас гарснаас хойшхи заалтыг зөрчсөн нөхцөлд 2 хүртэлх жил болон 30000 еврогын торгууль ноогдуулах заалттай талаар өмнө дурдсан. Төрийн албан тушаалаас гарч хувийн хэвшилд шилжихэд маш нарийн шалгалт явуулдаг. Тухайн асуудлыг шалгах шийдвэрлэх 3 төрлийн комисс ажилладаг нь энэ асуудлыг хамгийн сайн зохицуулсан улс гэж хэлж болно.

Португали улсын¹¹ хувьд албан тушаалтан төрийн худалдан авалттай холбоотой ашиг сонирхлоо мэдүүлдэг. Үүнд тухайн албан тушаалд томилогдсноос өмнөх болон албан тушаалаас чөлөөлөгдснөөс хойших 3 жилийн хугацаа хамаардаг. Гол онцлог бол хувийн компанийн 10 хувиас дээш хэмжээний дүрмийн санг төрийн албан тушаалтан, түүний гэр бүлийн гишүүд эзэмшдэг тохиолдолд тус компани төрийн худалдан авалтын тендерт оролцох эрхгүй. Бас нэг онцлог нь ашиг сонирхлын зөрчлийн хянах үүргийг Үндсэн хуулийн шүүх гүйцэтгэдэг явдал. Албан тушаалтан тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 60 хоногийн дотор ашиг сонирхлоо мэдүүлэх бөгөөд шүүх хянаж үзээд шийдвэрээ гаргадаг. Хэрэв албан тушаалд томилогдсноос хойш уг мэдүүлгийг гаргаж өгөөгүй тохиолдолд шүүхээс дахин 30 хоногийн хугацаа өгөх бөгөөд хугацаандаа гаргаж өгөөгүй бол албан тушаалаасаа чөлөөлөгддөг. Их Британитай нэг адил Португалид парламентын гишүүд хуулийн төсөл өргөн барихдаа, эсхүл парламентын шийдвэрээр хөндөгдөж болох өөрийн шууд болон шууд бус сонирхол бүхий парламентын үйл ажиллагаанд оролцохдоо сонирхлынхоо талаар урьдчилан мэдүүлсэн байх ёстой.

Латви¹² авлигын эсрэг стратегид ашиг сонирхлын зөрчлийн асуудал тусгагдсан. Зөвхөн хөрөнгөө мэдүүлээд зогсохгүй, орлогоо, ашиг сонирхлын зөрчил зэргийг төрийн өндөр албан тушаалтан төдийгүй жирийн албан тушаалтнууд мөн мэдүүлдэг. Бэлгийг төрийн өндөр албан тушаалтнууд төдийгүй жирийн албан тушаалтнууд заавал мэдүүлэх ёстой.

Хувийн компаниуд улсын салбарт гэрээ хэлцэл хийсэн, эсхүл төрийн албан тушаалтан хянадаг, зохицуулдаг нөхцөлд уг хувийн компанийн өмчлөх эрхийг эзэмшихийг хориглох заалтууд байдаг. Ашиг сонирхлын зөрчлийн заалтуудыг зөрчсөн нөхцөлд 5 хүртэлх жилийн хорих ялаар шийтгүүлэх заалттай. Ашиг сонирхлын зөрчлийн хуулийн хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газар нь хариуцан хянаж шалгах, захиргааны хариуцлага ноогдуулах бүрэн эрхтэй.

11 <http://www.oecd.org/dataoecd/12/32/39577476.pdf>

12 Мөн тэнд

ОХУ-д хуульд заасан төрийн албан тушаалтнууд, тэдгээрийн эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдүүд ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадна банкны данс нээх, эзэмших, дэлэн мөнгө, үнэт зүйлс хадгалахыг хориглодог.

Харин хэрэв төрийн алба болон иргэд, байгууллага буюу төрийн хууль ёсны ашиг сонирхолд зөрчил үүсээгүй тохиолдолд дотооддоо үнэт цаас эзэмшиж болно. Хэрэв төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхлын хооронд зөрчил үүсвэл, эсхүл үүсч болзошгүй бол тухайн албан тушаалтан өөрийн үнэт цаас, хувьцаагаа итгэмжлэгдсэн этгээдэд түр шилжүүлэх үүрэгтэй.

ОХУ-ын төрийн албан хаагчийг өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн хүмүүсээр дамжуулан ашиг олох, аливаа үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байдаг.

ОХУ-ын төрийн албан хаагч сурган хүмүүжүүлэх, шинжлэх ухаан, бүтээлч үйл ажиллагаанаас өөр орлого олох ямар ч үйл ажиллагаа эрхэлж болохгүй.

Төрийн албан хаагч төрийн албан хаагчийнхаа хувиар нийтлэл бичих, үг хэлснийхээ төлөө шагнал, урамшуулал авах эрхгүй байдаг.

Төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагчид төрийн албаны нууцлалын зэрэглэлд ч хамаарч болзошгүй мэдээллийг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор зарим улс оронд үйл ажиллагааг нь хянах, хязгаарлалт тогтоож, өөр ажил ямар нөхцөлөөр эрхлэх болсныг тодруулах, тайлбар авах, мэдээллийг шалгах журам боловсруулж мөрддөг.

ОХУ-д төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагч ажилд шинээр орохдоо өмнө нь ажиллаж байсан байгууллагынхаа “Нийтийн албан хаагчийн ёс зүйг сахиулж, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах комисс”-т хүсэлт гаргаж “бизнесийн байгууллагад ажиллах” зөвшөөрөл авах ёстой тухай 2008 оны 12-р сарын 25-ны өдөр баталсан хуулийн 12 дугаар зүйлд заасны зэрэгцээ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2016-2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хүрээнд ОХУ-ын Хөдөлмөрийн яам “Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа тухайн ажилтнууд өөр байгууллагатай хөдөлмөрийн, эсхүл ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад хязгаарлалт тавих арга зүйн зөвлөмж” боловсруулж баталсан нь төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагчдын ажил эрхлэх асуудлыг тогтсон нэгдмэл механизмаар шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой болжээ.

Зөвлөмжид зааснаар төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагч ажилд шинээр орохдоо эрх бүхий тусгай комиссоос зөвшөөрөл авах ёстой.

Зарим улс оронд, тухайлбал, АНУ, Их Британид чөлөөлөгдсөн албан хаагчийг ажилд авсан тухай албан ёсоор мэдэгдээгүй бол тухайн компанийг төрийн худалдан авалтын тендерт шалгаруулалтад орох, улсаас хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэг авах зэрэг эрхийг хасах зэргээр хариуцлага тооцдог.

Нөгөөтэйгүүр, ажил горилогч нь хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа өмнө нь хашиж байсан албан тушаалынхаа тухай ажил олгогчид танилцуулах үүрэгтэй бөгөөд санаандгүй, эсхүл санаатайгаар нуун дарагдуулсан тохиолдолд ОХУ-ын Хөдөлмөрийн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 77, 84-д заасны дагуу хөдөлмөрийн, эсхүл ажил гүйцэтгэх гэрээг цуцалж, ажлаас хална.

НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн бусад улс оронд ч хориг, хязгаарлалт тавих арга хэмжээ авч байна. Жишээлбэл, манай урд хөрш БНХАУ хатуу зарчим баримталж зарим албан тушаалтан, түшмэлүүдийг төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа албан тушаал хашихыг хориглодог. Улс оронд баримталж байгаа нэгдсэн зарчмаар бүх төрийн албан хаагчдад хориг, хязгаарлалт тавихгүй, гагцхүү хууль тогтоомжид заасан албан тушаалын жагсаалтад хамаарах, мөн ажилд орох гэж буй байгууллага нь өмнөх үүрэг хариуцлагатай нь шууд холбоотой байсан тохиолдолд л хязгаарлалт үйлчлэх юм.

Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа баримтлах журам нь улс оронд нийтлэг зүйл боловч АНУ-д уг хязгаарлалтыг албан тушаалын зэрэг дэвээс хамаарч нарийвчилж тогтоосон нь хууль бус үйлдэл газар авахаас урьдчлан сэргийлсэн оновчтой алхам болсон байна.

Жишээ 12. Америкийн Тусгай Хамгаалалттай газрыг хариуцах Үндэсний паркт ажиллаж байсан эмэгтэй Төрийн бус байгууллагад ажилд оржээ. Тэрээр төсөл боловсруулж тухайн төрийн бус байгууллагын өмнөөс санхүүжилт хүссэн өргөдөл гаргах явцад АНУ-ын төрийн байгууллагын албан хаагчтай холбоо барьжээ. Энэ үйлдэл нь өмнөх албан тушаалаа ашиглан бусдад нөлөөлөхийг оролдсон гэж үзэх үндэслэл болно.

Жишээ 13. “...” компанийн боловсруулсан гүний усыг шинжлэх программын техник үзүүлэлтийг хэлэлцэж зөвлөгөө өгөхөд оролцож байсан нэг төрийн албан хаагч Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа тус “...” компанитай хөдөлмөрийн гэрээ байгуулсаны үндсэн дээр компанийн дэд захирлын хүсэлтийн дагуу туршилт шинжилгээний дүнг батлав.

Өмнө ажиллаж байсан төрийн байгууллагад шинжилгээний дүнг танилцуулахад ямар ч зөрчил, асуудал гараагүй бөгөөд “Нөлөөлөхийг оролдох”-ыг хязгаарлана гэж харилцах журамд заагаагүй байжээ. Гэтэл хэлэлцүүлгийн явцад гэрээний зарим нэг заалт дээр үл ойлголцож маргаан үүссэн учир нөгөө залууг “...”-ий талд дэмжлэг үзүүлэх зорилгоор дуудсан байна.

Мэргэжилтэн залуу уг уулзалтад оролцох ёсгүй. Гэрээний талаар маргаан үүсчээ гэсэн үндэслэл байгаа бол тэрээр уулзалтад оролцох шаардлагагүй.

Жишээ 14. Тусгай хамгаалалттай газрын Үндэсний паркт ахлах түшмэлийн алба хашиж байсан иргэн чөлөөлөгдсөний дараахан “...” компанид ажиллах болсон бөгөөд чөлөөлөгдсөнөөс нь хойш 8 сарын дараа Үндэсний Парк дээр хэлэлцүүлж байгаа асуудалд тэрээр тус “...” компанийг төлөөлж оролцов. Ахлах түшмэлийн албыг хашиж байх үед нь уг асуудал түүний үүрэг хариуцлагатай холбоогүй байсан.

Тэрээр уг асуудалд оролцож болохгүй. Учир нь түүний хашиж байсан албан тушаал ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хязгаарлалтад хамрагдаж байгаа тул ажиллаж байх хугацаанд нь уг асуудал холбоогүй байснаас үл хамаарч хуулийн заалтыг биелүүлэх ёстой.

Жишээ 15. Газар, эрдэс баялгийг зохицуулах газарт орлогч даргын албан тушаал хашиж байсан эрхэм чөлөөлөгдсөнийхөө дараа нэгэн компанид зөвлөхөөр ажил оров. Түүний нэг үйлчлүүлэгч нь Тусгай хамгаалалтын газрын албатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хүсэлтэй тул холбоо барьж өгөхийг хүсчээ. Ингээд тэрээр албанаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 6 сарын дараа үйлчлүүлэгчийнхээ нэрийн өмнөөс Тусгай хамгаалалтын газрын албатай холбогдож үйлчлүүлэгчийг нь хүлээн авч уулзахыг хүссэн байна.

Тэрээр хариуцлагатай үүрэг бүхий албан тушаалтан тул ийм үйлдэл хийж болохгүй. Өөрөөр хэлбэл, тухайн албан тушаалаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 1 жилийн турш өөр хүний өмнөөс ажиллаж байсан байгууллагынхаа ажилтнуудад нөлөөлөхийг хориглох зохицуулалт үйлчилдэг.

Австрали Улс: Австралийн Засгийн газраас авлигатай тэмцэх үйл ажиллагаанд баримталдаг үндсэн зарчим, үзэл санаа нь авлигатай тэмцэх чиг үүргийг зөвхөн нэг байгууллагад хариуцуулах бус харин төрийн бүх байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг мэдээлэх чиг үүрэг хүлээх ёстой гэж үздэг явдал юм. Тус улс нь холбооны, муж улсын, орон нутгийн гэсэн гурван түвшинтэй засгийн газар бүхий холбооны тогтолцоот улс бөгөөд холбооны түвшинд Хууль сахиулах байгууллагуудын Ёс зүйн комисс, Австралийн Гэмт хэрэгтэй тэмцэх комисс, Хамтын нөхөрлөлийн омбудсман, Австралийн Холбооны цагдаагийн газар зэрэг байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Давхар ажил эрхлэлттэй холбоотой авлигын эрсдлийг зохицуулах нь

Байгууллага давхар ажил эрхлэлттэй холбоотой авлигын эрсдлийг зохицуулах зорилгоор наад зах нь:

- бодлого боловсруулах, давхар ажил эрхлэлтийн бодлого, журмыг нэвтрүүлэх
- бодлого, журмыг зөрчсөн тохиолдолд авах хориг арга хэмжээг бодлогод оруулах
- хоёр жил тутамд бодлогыг эргэн хянах
- ёс зүйн дүрэм гэх мэт компанийн холбогдох баримт бичгүүдэд давхар ажил эрхлэлтийн менежментийн талаар тодорхойлж бичих
- бүх ажилтнуудад үүрэг хариуцлагыг нь ойлгуулах байх үүднээс бодлого, журмын талаар сургалт явуулна
- давхар ажил эрхлэлтийн менежментийг байгууллагын дотоод хяналт шалгалт болон авлигын эрсдлийн удирдлагын үйл явцад үнэлүүлэхээр оруулах
- арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь чухал.

Давхар ажил эрхлэлтийн эрсдлийн менежментийн стратеги

Ажилтнуудынхаа давхар ажил эрхлэлтийн эрсдлийн үнэлгээг хийсний дараа эрсдэлийн менежментийн стратегийг шийдвэрлэх хэрэгтэй. Австралийн Шинэ Өмнөд Уэлсийн Авлигатай тэмцэх бие даасан хороо зөвлөмж¹³ гаргасан байдаг:

Давхар ажил эрхлэлтийн эрсдлийн менежментийн стратеги:

- Ажилтнуудын хувийн хэрэгт төлөвлөсөн болон төвлөрсөн цахим мэдээллийн сан дахь ажлын цаг зэрэг бүхий л давхар ажил эрхлэх өргөдөл, зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх;
- 12 сар тутамд давхар ажил эрхлэлтийн бүх шатны зөвшөөрлийг хянаж шалгах;
- Давхар ажил эрхлэлттэй холбоотой хуулиар тогтоогдсон үүргийг ажилтнууддаа байнга сануулж байх, тухайлбал, жилд нэг удаа гүйцэтглийн хяналт шалгалт хийж байх;
- Давхар ажил эрхлэх зөвшөөрөл авсан бүх ажилтны ирц бүртгэлд байнга хяналт тавьж байх;
- Авлигын эрсдэлтэй уялдуулан худалдан авалт, гэрээний менежмент гэх мэт тодорхой албан тушаалд ажилтнуудын давхар ажил эрхлэлтийг хязгаарлах, эсхүл хориглох зэрэг арга хэмжээ авах.

13 <http://www.icac.nsw.gov.au/preventing-corruption/736-knowing-your-risks/managing-as-sets/4302-secondary-employment>

8.2 | Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах зөвлөмж

ЕВРОПЫН ЗӨВЛӨЛИЙН ЁС ЗҮЙН ЖИШИГ ДҮРЭМ¹⁴

(ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлын тодорхойлолт)

13-р зүйл. Ашиг сонирхлын зөрчил

1. Нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхолтой байх, тэр нь түүний албан ажил, үүргээ шударгаар, бодитой гүйцэтгэхэд нөлөөлөх, эсхүл нөлөөлж болзошгүй байх нөхцөлд ашиг сонирхлын зөрчил үүснэ.
2. Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол гэж өөртөө, гэр бүлдээ, ойрын хамаатнууддаа, найз нөхөддөө, бизнесийн болон улс төрийн харилцаатай хувь хүн, эсхүл байгууллагад аливаа давуу байдал олгохыг хэлнэ. Үүнд мөн эдгээртэй холбоотой санхүүгийн, эсхүл иргэний хариуцлага багтана.

(Уг зүйл заалт нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой үүрэг хариуцлагыг ерөнхийд нь тодорхойлсон байна.)

3. Нийтийн албан тушаалтан нь дээрх нөхцөл байдалд орсон эсэхээ мэдэж буй цорын ганц этгээд тул:
 - Аливаа бодит, эсхүл болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх;
 - Ийм зөрчлөөс зайлсхийх арга хэмжээ авах;
 - Ийм зөрчлийн талаар олж мэдсэн даруйдаа удирдлагадаа шууд мэдэгдэх;
 - Тухайн нөхцөл байдлаас нэрээ татах, эсхүл зөрчил үүсгэж буй давуу байдлыг эдлэхээс татгалзах эцсийн шийдвэрийг ёсчлон биелүүлэх зэрэг үүрэг хүлээнэ.
4. Юу ч хийх шаардлагатай болсон нийтийн албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн албанд, эсхүл төрийн албаны шинэ албан тушаалд орох гэж буй нэр дэвшигч аливаа ашиг сонирхлын зөрчлөө мэдүүлсэн бол ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг тухайн албанд томилогдохоос өмнө шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Ашиг сонирхлыг мэдүүлэх гэсэн 14 дүгээр зүйлд: Хуульд заасны дагуу албан үүрэгт нь хувийн ашиг сонирхол нь нөлөөлж болзошгүй нийтийн алба хашдаг албан тушаалтан нь томилогдсон даруйдаа, түүнээс хойш тухай бүр, ашиг сонирхлын цар хүрээ, мөн чанар өөрчлөгдөх бүрт мэдүүлэх үүрэгтэй хэмээн ашиг сонирхлыг тогтмол мэдүүлдэг байх тогтолцоог зөвлөмж болгожээ.

14 [https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec\(2000\)10_EN.pdf](https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec(2000)10_EN.pdf)

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах талаар Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын удирдамжийг товчлон хүргэж байна.

1. Сонирхлын зөрчилтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох. Ямар нөхцөл байдал, харилцаа нь сонирхлын зөрчилд хүргэж болох талаар тодорхой, бодитойгоор тодорхойлно. Ажлын байран дахь сонирхлын зөрчлийн тодорхой нөхцөл байдлыг тодорхойлохын тулд сонирхлын зөрчлийн бодлогод байгууллагын стратеги, туршлагад дэмжлэг болох ёстой.
2. Сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг тодорхойлох, удирдан зохицуулах, шийдвэрлэх журмыг бий болгох. Төрийн албан тушаалтнууд тэдний сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг тодруулах, мэдэгдэхэд шаардагдах зүйлсийг мэдэж байх ёстой. Төрийн албан тушаалтнууд сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд яах ёстой талаар дүрмэндээ тодорхой тусгаж өгвөл удирдлагад ч, ажилтнуудад ч зохих удирдамж болно.
3. Манлайлагчийн үүрэг хариуцлагыг харуулах. Олон нийтэд үйлчилдэг менежерүүд, манлайлагчид нь ашиг сонирхлын зөрчлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ. Үүний тулд дэс дараатай шийдвэр гаргах үйл явцыг бий болгох, тодорхой тохиолдолд энэ загвар дээр тулгуурлан шийдвэр гаргах, бодлогын үр дүнтэй байгаа байдлыг үнэлэх, хянах, шаардлагатай бол бодлогыг илүү үр дүнтэй болгон сайжруулах, эсхүл өөрчлөх.
4. Ажилтнуудтайгаа түншлэл тогтоох. Сонирхлын зөрчлийн бодлогыг хэвлэн нийтэлж, сургалт, зөвлөгөө өгөх замаар Сонирхлын зөрчлийн талаарх ойлголтыг баталгаажуулна. “Эрсдэлтэй” газруудад болзошгүй сонирхлын зөрчилтэй нөхцөл байдлыг судална. Сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүссэн үед хэрэглэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох. Сонирхлын зөрчилтэй асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээг чөлөөтэй хэлэлцэж болохуйц байгууллагын нээлттэй соёлыг хөгжүүлэх, хэвшүүлэх.
5. Сонирхлын зөрчлийн бодлогыг албажуулах/хэрэгжүүлэх. Сонирхлын зөрчлийг тогтоох журам бий болгох, үүндээ уг журмыг мөрдөөгүй тохиолдолд гарах үр дагавар, сахилгын шийтгэл зэргийг багтаах. Бодлогын зөрчлийг илрүүлэх хяналтын механизмыг бий болгож, үр дүнд гарсан ахиц, үр ашгийг харгалзан үзэх. Урьдчилан сэргийлэх, албажуулах арга хэмжээг зохицуулж, тэдгээрийг холбогдох институцын тогтолцоонд нэгтгэх. Сонирхлын зөрчлийн бодлогод байнга мөрдөж буйг харуулсан үлгэр жишээ зан үйлийг хүлээн зөвшөөрч, урамшуулах механизм бий болгох.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ:

Ном, гарын авлага, судалгааны тайлан:

1. Жереми Поуп “Авилгалын эсрэг сурвалж бичиг, Улаанбаатар хот, 2003 он
2. OECD 2000 “Trust in Government: Ethics measures in OECD countries”.
3. Ж.Амарсанаа нар “Хууль зүйн тайлбар толь”, Улаанбаатар хот, 2003 он
4. Г.Бямбажав, “Монголын уламжлалт менежмент”, Улаанбаатар хот, 2004 он
5. НҮБХХ, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, Ёс зүйн гарын авлага, Улаанбаатар хот, 2006 он
6. Vozeman, B. (2007) Public Values and Public Interest: Counterbalancing Economic Individualism. Washington, DC: Georgetown University Press.
7. Р.Вандангомбо “Төрийн албаны ёс зүй”, Улаанбаатар хот, 2007 он
8. “Үндэсний шударга ёсны тогтолцоо түүний үзүүлэлтүүд”, Улаанбаатар хот, 2007 он
9. НҮБХХ, Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг Засгийн газар, Улаанбаатар хот, 2008 он
10. Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу”, Улаанбаатар хот, 2009 он
11. Д.Зүмбэрэлхам, “Авлига гэмт явдал”, Улаанбаатар хот, 2011 он

13. Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, “Нийтийн албанд дахь ашиг сонирхлын зөрчил: зохицуулалт ба удирдлага” гарын авлага, Улаанбаатар хот, 2012 он
14. Л.Батжав, Э.Болормаа, Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу, Улаанбаатар хот, 2012 он
15. Alan lawton, Julie Rayner and Karin Lasthuizen, Ethics and management in the public sectors, 2013
16. АТГ, “Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх 2012 оны тайлан”, Улаанбаатар хот, 2013 он
17. Richard Cowell, James Downe, and Karen Morgan. “Managing politics? Ethics regulations and conflicting conceptions of good conduct”. Public administration review. January/February 2014
18. УИХ, “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” онол-практикийн хурлын материал, Улаанбаатар хот, 2014 он
19. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Авлига, албан тушаалын гэмт хэрэг: Хуульчдад зориулсан гарын авлага”, Улаанбаатар хот, 2014 он
20. С.Оюунтуяа, “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага”, Улаанбаатар хот, 2014 он
21. АТГ, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Нийтийн албан тушаалтны гарын авлага”, Улаанбаатар хот, 2014 он
22. АТГ, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Сургагч багшийн гарын авлага”, Улаанбаатар хот, 2014 он
23. АТГ, “Дэлхийн улс орнуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа”, Улаанбаатар хот, 2015 он
24. АТГ, “Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2017”, Улаанбаатар хот, 2018 он
25. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага, УБ, 2018 он
26. Д.Баатарсайхан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” илтгэл, Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөний материал, 2018 он

27. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Авлигатай тэмцэх гарын авлага, Улаанбаатар хот, 2016 он (АТГ-ын орчуулга)
28. Ц.Даваадулам, “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар бичиг”,
29. Н.Бурмаа, “Төрийн хяналт хариуцлага”, Улаанбаатар хот, 2018 он.
30. OECD 2018 “Behavioral Insights for Public integrity: Harnessing the Human factor to counter corruption”.
31. OECD 2018 “Education for Integrity: Teaching on Anti-corruption, Values and the Rule of Law”.

Бусад материал:

1. Европын зөвлөл, Сайд нарын хорооноос Нийтийн албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээний талаарх гишүүн улс орнуудад хүргүүлсэн R(2000) 10 тоот зөвлөмж, 2000, [pdf]. [https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec\(2000\)10_EN.pdf](https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec(2000)10_EN.pdf)
2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), “Төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчлийг удирдах нь”, ЭЗХАХБ-ын гарын авлага, улсуудын туршлага, 2003, [pdf]. <http://www.oecd.org/gov/ethics/48994419.pdf>
3. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), “Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг: Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам”, 2011, ЭЗХАХБ-ын хэвлэл [pdf]. <http://www.oecd.org/corruption/antibribery/47489446.pdf>
4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), Авлигатай тэмцэх шилдэг туршлагауд, Бүлэг 3 “Ашиг сонирхлын зөрчил ба Санхүүгийн хөрөнгийг хянах нь”, 2004 [pdf]. <http://www.osce.org/eea/13738?download=true>
5. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), “ЕАБХАБ-ын гишүүн орнуудын авлигаас урьдчилан сэргийлэх стратеги үйл ажиллагаа, ЕАБХАБ-ын амлалтын хэрэгжилтэд хийсэн тайлан”, 2012 [pdf]. <http://www.osce.org/eea/93468?download=true>
6. НҮБ, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн Оролцогч улсуудын Бага хурал, “Ашиг сонирхлын зөрчил, Авлигын хэрэг болон хөрөнгө мэдүүлэх, конвенцийн 7-9 дүгээр зүйл”, 2012 [цахим хуудас]. <http://www.unodc.org/unodc/en/corruption/WG-Prevention/conflict-of-interest.html>

7. М.Полейни, “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн гарын авлага”, 2015, Лондонгийн Олон улсын хуулийг практикт хэрэгжүүлэх төв, Авлигын эсрэг форум <http://www.lcilp.org/wp-content/uploads/2015/02/Guide-to-the-UN-Convention-Against-Corruption-Martin-Polaine.pdf>
8. United Nations Office on Drugs and Crime, United Nations Anti-corruption Toolkit, p. 15-16. http://www.unodc.org/documents/corruption/publications_toolkit_sep04.pdf
9. Bruno W. Speck, Conflict of Interest: Concepts, Rules and Practices regarding Legislators in Latin America
10. The Latin Americanist, Volume 49 Issue 2 (Feb 2008)
11. Dr. Londa Esadze, PLAC Project Guidelines for Prevention of Conflict of Interest Dr. Londa Esadze Senior International Non Key Expert on Justice and Home Affairs, November, 2013 Belgrade, Serbia
12. “Их Британийн Төрийн албаны менежментийн дүрэм”, 4.1.3 <http://www.civilservice.gov.uk/iam/codes/csmc/index.asp>
13. G. Carney, Conflict of Interest: Legislators, Ministers and Public Officials, Transparency International Working Paper, 1998.
14. “Өмнөд Африкийн Парламентийн Ёс зүйн дүрэм”, 6-р бүлэг http://www.parliament.gov.za/live/content.php?Item_ID=235
15. http://164.100.24.167/template/mem_interest.pdf
16. “Дээд танхимын Ёс зүйн дүрэм”, 2005, <http://www.publications.parliament.uk/pa/cm/code.pdf>
17. “Парламентийн Ёс зүйн дүрэм, 294 (1)-р дүрэм”, http://rajyasabha.gov.in/com_ethics/ethics_main.asp
18. Европын зөвлөл, “Сайд нарын хорооноос Нийтийн албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээний талаарх гишүүн улс орнуудад хүргүүлсэн R (2000) 10 тоот зөвлөмж”, 2000. [https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec\(2000\)10_EN.pdf](https://www.coe.int/t/dghl/monitoring/greco/documents/Rec(2000)10_EN.pdf)
19. Tough anti-corruption law takes effect in South Korea <http://newsinfo.inquirer.net/819878/tough-anti-corruption-law-takes-effect-in-south-korea#ixzz4LWdzIEAK>
20. Өмнөд Африкийн Ардчилалын төлөө Институт, “Апартейдийн дараах Өмнөд Африк дах Засгийн газрын ёс зүй: 2003”, http://www.idasa.org.za/index.asp?page=output_details.asp%-3FRID%3D94%26TID%3D1%26OTID%3D2

21. Secondary employment <https://www.staff.lu.se/employment/terms-of-employment/secondary-employment>
22. Германы Холбооны Засгийн газрын Авлигаас сэргийлэх зааварчилгаа, 2004: <http://www.u4.no/document/showdoc.cfm?id=45>
23. <http://www.tribuneindia.com/2005/20051224/main1.htm>
24. http://www.parliament.uk/about_commons/pcfscfm
25. <http://ethics.house.gov/Subjects/Topics.aspx?Section=114>
26. http://www.cabinetoffice.gov.uk/~-/media/assets/www.cabinetoffice.gov.uk/propriety_and_ethics/ministerial_code%20pdf.ashx
27. <http://www.jk.ru/jur-polesno.html>
28. http://www.nwapa.spb.ru/sajt_ibo/gos_sluzhba_polnotekst/kazachenkova.htm
29. <http://www.nm.md/daily/article/2009/01/20/0304.html>
30. www.calstate.edu/gc/docs/conflict_of_interest_handbook.doc
31. <http://www.jk.ru/jur-polesno.html>
32. <http://www.oecd.org/dataoecd/12/32/39577476.pdf>
33. <http://www.info-evropa.rs/wp-content/uploads/2013/11/Londa-Es-adze-Guidelines-for-Prevention-of-Conflict-of-Interest.pdf>
34. http://www.usoge.gov/laws_regs/regulations/5cfr2635.aspx
35. http://www.marsgroupkenya.org/Reports/LawsandConventions/Kenya_PublicOfficer_Ethics_Act_2003.pdf
36. <http://www.publications.parliament.uk/pa/cm/code.pdf>
37. <http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/index.html>